

Лианхона



**Гэр бүлээ
бэхжүүлэх есөн
арга зам, х. 26**

**Зорилготой залбирал:
Миний хүсэл биш харин
Таны хүсэл, х. 38, 48**

**Муу киноноос үүдэлтэй
асуудал, х. 60**

**Би баптисм хүртэхдээ
сандарч байлаа, х. 66**



“Гэрлэлт нь хүмүүний аль ч бусад харилцаанаас илүүгээр аз жаргалтай байх боломжуудыг нээж өгдөг.”

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Рассел М.Нелсон, “Гэрлэлтээ бэхжүүлэхүй,” *Лиакхона*, 2006 оны 5-р сар, 36.



22

ЗАХИАСУУД

- 4 Тэргүүн Зөвлөлийн захиас бичиг: Нэг дороо эргэлдэх нь Ерөнхийлөгч Диетер Ф.Угдорф
- 7 Айлчлагч багшийн захиас бичиг: Гэр бүлийн түүхээс ирдэг баяр баясгалан

ОНЦЛОГ ӨГҮҮЛЛҮҮД

- 14 Төөрөөд алга болсон хоньд ч гэсэн үнэ цэнэтэй
Ерөнхийлөгч Жеймс И. Фауст
Төөрөлдсөн хүүхдүүдийн эцэг эхчүүдэд хандсан захиас
- 22 Санваараар дамжуулан гэр бүл болон сүмийг хүчирхэгжүүлэх нь
Ричард М. Ромни
Дэлхий даяарх удирдагчдын сургалтын захиас нь хувь хүн, гэр бүл, тойрог гадасуудыг адисалж байна.
- 26 Амжилттай гэрлэлт ба бат бөх гэр бүлийн есөн зарчим
Женнифер Грейсе Жөүнс
Гэр бүлийн тунхаг дахь зарчмууд танай гэр бүлтэй хэрхэн холбогддог вэ?

ХЭСГҮҮД

- 8 Бид Христийн тухай ярьж байна: “Би чамайг мартахгүй”
Беки Сквайре
- 10 Сайн мэдээний сонгомол бүтээл: Үнэн бөгөөд амьд Бурханыг шүтэн бишир
Ерөнхийлөгч Спенсер В. Кимбалл
- 13 Сүмд үйлчилсэн минь: Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст үйлчлэх нь
Беки Янг Фосетт
- 34 Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн дуу хоолой
- 74 Сүмийн мэдээ
- 80 Биднийг дахин уулзалал: Арлынхны итгэл
Жошуа Ж. Перки

ХАВТСАН ДЭЭР

Нүүрэн талд: Гэрэл зураг чимэглэлийг Дэвид Стокер.
Ар талд: Гэрэл зураг чимэглэлийг Дэвид Стокер.
Дотор тал дахь оруулга хавтас: Гэрэл зургийг
Жастин Жон Содерквист.



38

38 Тэд бидэнд хандан ярив:
Хувийн залбирлаа хэрхэн сайжруулах вэ?
 Ахлагч Кевин В.Пийрсон
Бидний хувийн залбирал бол бидний сүнслэг хуч чадлын хэмжүүр, сүнсний сайн сайхан байдлын үзүүлэлт юм.



Энэ дугаарт нуусан Лиахонаг олоорой.

Санамж: олохдоо тэвчээртэй байгаарай.

- 42 Асуулт, хариултууд**
- 44 Сүмийн түүхийг судлахдаа тэнцвэртэй байдлыг хангах нь**
 Ахлагч Стивен Э.Снөү
Бид Сүмийн түүхийг судлахдаа тэнцвэртэй байдлыг хэрхэн хадгалах вэ?
- 48 Сүнсний хүчтэй мэдрэмжүүд**
 Ахлагч Д.Тодд Кристофферсон
Бид Сүнснээс өдөөлтүүд хүлээн авах зөв нөхцөлд байхын тулд юу хийж болох вэ?
- 51 Ай Бурханы маань төлөвлөгөө хэчнээн агуу билээ!**
 Э.Амарсанаа
Ах бид хоёр муудалцсаны уригаар өөр өөрийн замыг хөөхөөс аргагүй болсон юм. Би түүнтэй дахин уулзах болов уу?
- 54 Санваартны удирдагчдын зөвлөгөөг дагах таван арга зам**
Санваартны удирдагчдаа дэмжихийн тулд таны хийж чадах таван энгийн зүйлийн тухай өгүүлье.
- 56 Залуучуудын бат бөх байдлын төлөө: Талархал**
 Дэвид Л.Бек
- 58 Эмээдээ өгсөн бэлэг**
 Кимберли Сабин Плам
Юм бүхэн байдаг эмээд юу төгс бэлэг болж чадах вэ?

51



63

- 60 Муу кино**
 Жюли Вудбөри
Манай ангийхан муу кино үзэх санал гаргалаа. Би яах ёстой вэ?
- 62 Онцгой гэрч: Тэнгэрлэг Эцэг Сүмийн гишүүдийг бусад хүмүүсээс илүү хайрладаг уу?**
 Ахлагч Квинтин Л.Кук
- 63 Шаргуу залбирал**
 Ахлагч Хосе Л.Алонсо
Залбирлын харуу тэр дороо ирдэггүй ч заавал ирдэг.
- 64 Хүүхдийн Хэсгийг гэртээ авчрах нь: Би баптисм хүртэж, гишүүнээр батлуулснаар Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөг дагана**
- 66 Баптисм бол адислал**
 Кейси Айре
Тревор усан дотор орохоос айдаг байсан гэнэ. Тэр баптисм хүртэж чадах болов уу даа?
- 68 Сайн байна уу! Би Монголын А.Энхжин байна!**
Энхжин болон түүний гэр бүл бас дуртай зүйлсийнх нь тухай уншиж сонирхоно уу.
- 70 Бага насны хүүхдүүдэд зориулав**
- 81 Бошиглогчийн хөрөг:**
 Лорензо Снөү

**2013 ОНЫ ЗУРГАДУГААР САРЫН ДУГААР 14 NO. 3
ЛИАХОНА 10786 363**

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн
Сүмийн олон улсын сэтгүүл

Тэргүүн Зөвлөл: Томас С.Монсон, Хенри Б.Айринг,
Диетер Ф.Угдорф

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулга: Боид К.Пакер,
Л.Том Перри, Рассел М.Нелсон, Даллин Х.Өүкс,
М.Рассел Баллард, Ричард Г.Скотт, Роберт Д.Хейлс,
Жеффри Р.Холланд, Давид А.Беднар, Квинтин Л.Кук, Д.Тодд
Кристофферсон, Нийл Л.Андерсен

Эрхлэгч: Крейг А.Кардон
Зөвлөхүүд: Шэйн М.Боуэн, Брэдли Д.Фостер,
Бага Кристоффел Гоулдэн, Энтони Д.Пэркинс

Удирдах захирал: Дэвид Т.Варнэр
Гэр бүл болон гишүүдийн тусламжийн захирал:
Винсент А.Ваун

Сүмийн сэтгүүлийн захирал: Алан Р.Лоиборг
Бизнесийн менежер: Гарфф Каннон

Гүйцэтгэх редактор: Р.Вал Жонсон
Гүйцэтгэх захирлын туслах: Раян Карр,
ЛаРин Портер Гаунт

Хэвлэлийн туслах: Мэлисса Зентено
Редакцийн баг: Сюзан Барретт, Дэвид Диксон,
Давид А.Эдвардс, Маттью Д.Флиттон, Минди Рая Фриедман,
Лори Фуллер, Гарри Х.Гарфф, Женнифер Грейс Жөүнс,
Хайжари Лофтус, Майкл Р.Моррис, Ричард М.Ромни, Пол
ВанДенБерг, Жюлия Вудбери

Зураглал чимэглэлийн удирдагч менежер:
Ж.Скотт Кнудсен

Зураглал чимэглэлийн удирдагч: Тадд Р.Петрсон
Уран бүтээлийн ажилтнууд: Жанетт Эндрьюс,
Фиэ П.Андрус, С.Кимбол Ботт, Томас Чаилд, Керри Линн
С.Херрин, Коллийн Хинкли, Эрик П.Жонсен, Скотт М.Моои,
Брэд Тиаре

Оюуны өмчийн зохицуулагч: Жэин Анн Петрс
Хэвлэлийн захирал: Жэин Анн Петерс
Хэвлэх баг: Конни Буаторп Бриж, Ховард Г.Браун, Жюли
Бердетт, Браян В.Гизи, Катлин Ховард, Денис Көрби, Гинни
Ж.Нилсон, Тай Пилчер, Гейл Тейт Рафферти
Хэвлэлийн захирал: Крейг К.Седвик

Хуваарилалт хариуцсан захирал: Эван Ларсен, Нэгдсэн
Улс, Канадаас бусад орнууд дахь захиалга болон үнийн
талар орон нутгийн Сүмийн хангамжийн төв болон тойрог,
салбарынхаа удирдагчтай холбоо барина уу.

Гар бичмэл болон асуултаа интернет веб сайт
liahona.lds.org руу; шуудангаар *Liahona*, Rm. 2420,
50 E. North Temple St., Salt Lake City, UT 84150-0024, USA
хаягаар; эсвэл э-мэйлийн: liahona@ldschurch
.org хаягаар ирүүлнэ үү.

Лиэхона нь (Мормоны Номон дахь утгаараа бол "луужин"
буюу "заллагч") албани, англи, армен, бислам, болгар,
вьетнам, гаити, герман, грек, дави, индонез, ирланд, испани,
итали, камбож, кирибати, латви, литва, малагаж, маршалл,
монгол, нидерланд, норвеги, орос, польш, португали, румын,
свахили, самоа, себуано, солонгос, тагалог, тай, тахити,
тонга, украин, унгар, урду, фижи, фин, франц, хорват,
хятад, хятад (хялбаршуулсан), чех, швед, эстони, япон хэлээр
нийтлэгддэг. (Жилд нийтлэгдэх дугаарын тоо улс бүрд өөр
байна.)

© 2013 by Intellectual Reserve, Inc. Бүх эрх хамгаалагдсан.
Америкийн Нэгдсэн Улсад хэвлэв.

Лиэхона дахь сэдэв, үзүүлэн, материалуудыг онцгой
тохиолдолд арилжааны бус зорилгоор сүм болон гэрт
ашиглахын тулд хувилж болно. Урлагийн бүтээлийг
хуулбарлахыг хориглосон бол үзүүлэнг хувиран олшруулж
болохгүй. Зохиогчийн эрхийн талаарх асуултаа Intellectual
Property Office, 50 E. North Temple St., Salt Lake City,
UT 84150, USA хаягаар; эсвэл электрон шуудангийн:
cor-intellectualproperty@ldschurch.org хаягаар ирүүлнэ үү.

For Readers in the United States and Canada:
June 2013 Vol. 14 No. 3. LIAHONA (USPS 311-480) Mongolian
(ISSN 1525-7584) is published six times a year (January, April,
June, July, October, and December) by The Church of Jesus
Christ of Latter-day Saints, 50 E. North Temple St., Salt Lake City,
UT 84150. USA subscription price is \$5.00 per year; Canada,
\$6.00 plus applicable taxes. Periodicals Postage Paid at Salt Lake
City, Utah. Sixty days' notice required for change of address.
Include address label from a recent issue; old and new address
must be included. Send USA and Canadian subscriptions to Salt
Lake Distribution Center at address below. Subscription help
line: 1-800-537-5971. Credit card orders (Visa, MasterCard,
American Express) may be taken by phone. (Canada Poste
Information: Publication Agreement #40017431)

POSTMASTER: Send all UAA to CFS (see DMM 707.4.12.5).
NONPOSTAL AND MILITARY FACILITIES: Send address changes
to Distribution Services, Church Magazines, P.O. Box 26368,
Salt Lake City, UT 84126-0368, USA.

Гэр бүлийн үдшийн санаанууд

Энэ дугаарт гэр бүлийн үдэшт ашиглах өгүүлэл, үйл
ажиллагаануудыг бичсэн байгаа. Зарим жишээг доор харуулав.



ГЭР БҮЛИЙН ҮДШИЙН САНААНУУД © ИИ

"Эмээдээ өгсөн бэлэг," 58-р хуудас:
Эмээдээ өгөх Кимберлигийн бэлгийн
тухай унш. Энэ түүхийг ярилцахад тус-
ламж авахын тулд та дараах асуултуудыг
ашиглаж болно: Түүний захидал эмээд
нь яагаад маш чухал зүйл байх болно гэж
та бодож байна? Хүн ямар нэг зүйлийн
төлөө өөрт чинь талархал илэрхийлэхэд
чамд ямар санагддаг вэ? Тэнгэрлэг Эцэгт
талархал илэрхийлэхэд Түүнд ямар са-
нагддаг гэж та боддог вэ? Та *Залуучуудын*
бат бөх байдлын төлөө товхимлын 18-р
хуудсан дахь талархлын тухай уншиж
болно. Лук 17:11–19 дэх уяман өвчтэй 10
хүнийг Есүс хэрхэн эдгээсэн тухай түүхийг
уншиж, энэ түүх талархлын тухай юу
зааж байгааг ярилцахыг бод. Гэр бүлийн
гишүүн бүр талархлын захидал бичиж,
энэ долоо хоногт хэн нэгэнд өгөх үйл
ажиллагааг явуулж болно.

"Баптисм бол адислал," 66-р хуудас:
Та "Нифайн зориг" (*Children's Songbook*,
120) дуг дүүлж, гэр бүлийн үдшээ эхэлж
болно. Дараа нь Тревор уснаас айх айд-
саа хэрхэн даван туулсан тухай түүхийг
уншиж, дараах асуултуудад хариул: Та
ямар нэг зүйл хийхээс айж байсан уу?
Айхгүй байхад чинь юу тусалсан бэ?
Санаа зовж, тэвдэлгүйгээр хийх хэрэгтэй
ямар зүйлс байгаа тухай санал бодлоо ху-
ваалцахыг гэр бүлийн гишүүдээс хүс. Гэр
бүлээрээ бие биедээ илүү зоригтой боло-
ход туслах арга замуудыг ярилц. Ийм үйл
ажиллагаа зохиож болно. Өрөөнд хүний
явах зам дээр саад тавиад гэр бүлийн нэг
гишүүний нүдийг боо. Тэгээд тэр өөрт нь
өгөх зааврыг даган саадыг тойрч гарахыг
хичээх хэрэгтэй. Айсан үед Сүнс биднийг
хэрхэн удирдаж, тайтгаруулдаг тухай
ярилцаж болно.

ТӨРӨЛХ ХЭЛЭЭРЭЭ

Лиэхона болон Сүмийн бусад материалуудыг олон хэлээр www.languages.lds.org
– аас үзэж болно.

ЭНЭ ДУГААР ДАХЬ СЭДВҮҮД

Тоонууд нь өгүүллийн эхний хуудсыг зааж байгаа.

Авралын төлөвлөгөө, 51
Ариун Сүнс, 64
Ариун сүмийн ажил, 7, 14
Баптисм, 64, 66
Бэрхшээл, 8, 51
Бужиг, 35
Гэр бүл, 8, 22, 26, 42, 51, 58, 68
Гэр бүлийн түүх, 7, 37
Гэрчлэл, 48, 80
Дуулгавартай байдал, 54

Дэмжих, дэмжүүлэн батлуулах, 54
Ерөнхий чуулган, 4
Есүс Христ, 8, 14, 70
Жишгүүд, 35, 60
Залбирал, 34, 36, 38, 63
Зан төлөв, 14
Иосеф Смит, 48
Итгэл, 10, 14, 66, 80
Порнограф, 42
Санваар, 54
Судрууд, 4

Сүмийн дуудлагууд, 13, 14
Сүмийн түүх, 44
Талархал, 56, 58
Уучлал, 42
Хайр, 62
Хөгжлийн бэрхшээл, 13
Чин үнэнч зан чанар, 14
Шүтлэг бишрэл, 10
Арга хэрэгсэл, 60
Үйлчлэл, 13, 14, 36
Үлгэр дууриал, 14



**Ерөнхийлөгч
Диетер Ф.Угдорф**

Тэргүүн Зөвлөлийн
Хоёрдугаар зөвлөх

НЭГ ДОРОО ЭРГЭЛДЭХ НЬ

Та төөрсөн хүмүүс нэг дороо эргэлдэх хандлагатай байдаг хэмээх хуучны үгийг сонсож байсан уу?

Германы сэтгэл зүйч Жан А.Саумэн энэ нь үнэн эсэхийг шинжлэх ухааны үүднээс тодорхойлохыг хүсчээ. Тэрээр туршилтын хэдэн хүнийг томоохон ой мөн Сахарын цөл рүү авч явсан бөгөөд тэдний байрлалыг тогтоохын тулд дэлхийг хамарсан байршил тодорхойлох системийг ашиглажээ. Тэдэнд ямар нэгэн луужин эсвэл өөр ямар нэгэн хэрэгсэл байсангүй. Харагдаж байгаа газрыг нүдээр баримжаалан чигээрээ явган явах энгийн зааврыг тэдэнд өгсөн ажээ.

Эрдэмтэн Саумэн хожим нь юу тохиолдсоныг ийн дүрсэлжээ. “Тэдний [зарим] нь үүлтэй бүрхэг өдөр явсан бөгөөд [газрын чиглэлийг нүдэн баримжаагаар тодорхойлох боломж хязгаарлагдмал байлаа]. . . . [Тэд] бүгд өөрсдөө ч мэдэлгүй дороо эргэлдсээр байсан байна.” Харин бусад нь газрын зүг чиг сайн харагдаж байсан нартай үеэр явсан байна. “Эдгээр хүмүүс . . . бараг л төгс гэмээр шулуун замаар хазайлгүй явсан ажээ.”¹

Энэ туршилтыг бас өөр хүмүүс дээр өөр аргаар туршиж үзсэн ажээ. Үр дүн нь мөн л дээрхтэй адил байв.²

Хүн нүдээр баримжаалах юмгүй бол нэг дороо эргэлдсээр байдаг байна.

Судрууд бол зам заагч

Хүн төрөлхтөн сүнсний зам заагчгүйгээр мөн л төөрч будилдаг. Бурханы үггүй бол бид урагш ахихгүй дороо эргэлдсээр байх болно.

Бид хувь хүмүүсийн хувьд ч, нийгмийн хувьд ч энэхүү загвар цаг хугацааны эхлэлээс хойш эрин үе болгонд давтагдсаар ирснийг хардаг. Бид Бурханы үгийг хараанаасаа алдвал төөрөх болно.

Чухам иймээс энэ нь Их Эзэн Лихайд хөвгүүдээ гуулин ялтсуудыг авчруулахаар Иерусалим руу буцаах зарлиг өгсний эргэлзээгүй шалтгаан юм.

Судрууд бол Бурханы үг. Судрууд нь бид Аврагчид илүү ойртож, зөв зорилгодоо хүрэхийн төлөө аялах ёстой замыг бидэнд зааж өгдөг Бурханы зүг чиг заагч юм.

Ерөнхий чуулганы зам заагч

Ерөнхий чуулган дээр өгдөг зааврууд нь бидэнд зөв зам дээр байгаа эсэхээ мэдэхэд тусалдаг зам заагч юм.

Заримдаа би өөрөөсөө “Би Сүмийн хамгийн сүүлийн чуулгануудаар үг хэлсэн хүмүүсийн үгсийг сонссон уу? Би тэдний үгсийг дахин дахин уншиж судалсан уу? Би тэдгээрийг тунгаан бодож, амьдралдаа хэрэгжүүлсэн үү? Эсвэл би зүгээр л сайхан үгс байна гээд сүнслэг захиасуудыг нь амьдралдаа хэрэгжүүлэхийг үл тоомсорлосон уу?” гэж асуудаг.

Та чуулган дээр хэлсэн үгсийг сонсох юм уу унших үедээ тэмдэглэл хөтөлж болно. Та зарим зүйлсийг илүү сайн буюу өмнөхөөсөө өөр байдлаар хийхээр шийдэж болно. Сүүлчийн ерөнхий чуулганы захиасуудын тухай эргэцүүлэн бод. Олон захиас гэр бүлээ болон гэрлэлтээ бэхжүүлэхэд бидэнд урам хайрладаг. *Лиакхона* сэтгүүлийн ерөнхий чуулганы дугаар нь бас эдгээр мөнхийн үнэ цэнэтэй зүйлс болон бидний амьдралыг адислах



практик ач холбогдолтой олон зөвлөмж дээр анхаарал төвлөрүүлдэг.

Энэхүү үнэ цэнэтэй зөвлөгөөг бид анхааралтай уншиж, амьдралдаа хэрэгжүүлдэг бил үү? Бид энэхүү бодитой бөгөөд үнэ цэнэтэй зам заагчийг таньж, баяртайгаар хүлээн авдаг бил үү?

Сүнслэг байдлын төөрөгдлийг эдгээх нь

Биднийг нарийн бөгөөд давчуу зам дээр байхад сүнслийн зам заагч амин чухал юм. Энэхүү зам заагч нь хэрэв бид үүнийг таньж, баяртайгаар хүлээн авах юм бол бидний явах ёстой зүг чигийг бидэнд тод томруунаар зааж өгдөг билээ.

Хэрэв бид энэхүү зам заагчаар удирдуулахаас татгалзвал энэ нь тодорхой зорилгогүй, амьдралын нэгэн хэвийн явцад дорвитой нөлөөлж чадахгүй, зүгээр л нэг түр зуур шохоорхол татах, утга учир муутайхан зүйл байх болно.

Бид зөвхөн зөн билгээрээ удирдагдах нь хангалтгүй юм.

Сайн бодол санаа, сайн төлөвлөгөөтэй байх нь ч хангалтгүй.

Төрөхөөс заяасан мэдрэхүүдээ найдах нь ч хангалтгүй.

Бид өөрсдийгөө сүнслэг байдлын давчуу замаар замнаж байгаа гэж бодсон ч биднийг удирдах сүнслийн зам заагч буюу Сүнслийн удирдамж байхгүй бол бид төөрөх болно.

Тиймээс, ачлалт Бурханаас хүүхдүүддээ өгсөн зам заагчуудыг нүдээ нээж, харцгаая. Бурханы үгийг уншиж, сонсон, амьдралдаа хэрэгжүүлцгээе. Үнэн зорилготойгоор залбирч, Сүнслийн өдөөлтүүдийг сонсож дагацгаая. Хэрэв бид хайр энэрлээр дүүрэн Тэнгэрлэг Эцгийнхээ өгсөн бурханлаг зам заагчуудыг таньж, хүлээн авбал бидний амьдрал тэдгээр зам заагчуудаар удирдагдах болно. Бид сүнслийн зам заагчуудаар удирдагдах явцдаа зам мөрөө хянан алдаагаа байнга залруулж байх ёстой.

Ингэвэл бид нэг дороо эргэлдэхгүй харин итгэлтэйгээр тэрхүү агуу тэнгэрлэг адислал руу алхах болно. Уг тэнгэрлэг адислал нь Христийн шавь нарын нарийн бөгөөд шулуун замаар замнасан бүх хүмүүсийн ууган хүүгийн эрх юм. ■

ЭШЛЭЛ

1. Жан А.Саумэн ба бусад, "Walking Straight into Circles," *Current Biology*, vol. 19 (2009 оны 9-р сарын 29), 1538.
2. Жишээ нь, Жан А.Саумэн "A Mystery: Why Can't We Walk Straight?" npr.org/blogs/kruhwich/2011/06/01/131050832/a-mystery-why-can-t-we-walk-straight-ыг-үз.

ЭНЭ ЗАХИАСААС ЗААХ НЬ

Та энэ захиасаас заахаар бэлтгэхдээ сүнслийн зам заагчаар удирдуулсан эсвэл нэг дороо эргэлдэж төөрсөн хүмүүсийн тухай судрын жишээнүүдийг хайж олж болно. Та дараах судруудыг судлахаас эхэлж болно: Тооллого 14:26–33; 1 Нифай 16:28–29; Алма 37:38–47. Хэрэв та сүнсээр өдөөгдвөл заадаг хүмүүстэйгээ эдгээр жишээнүүдийг хуваалцаж болно. Бид эдгээр түүхүүдээс юу сурч болохыг тэднээс асуу.

Таны зам заагч

Ерөнхийлөгч Угдорф ерөнхий чуулган болон судруудыг сүнсний төөрөгдлөөс зайлсхийхэд тань туслах зам заагчууд хэмээн дүрсэлсэн байдаг. Амьдралыг тань удирдан, нөлөө үзүүлсэн сүнсний бусад зам заагчуудын тухай тунгаан бодогтун. Туршлагынхаа тухай тэмдэглэлдээ бич. Ерөнхийлөгч Монсонгийн дараах захиасууд танд тусалж болох юм:



“Таны адислал цэвэрхэн нугалж, цааш хийж хадгалахад зориулагдаагүй. Мөн жаазанд хийх эсвэл нийтэд зарлахад зориулагдаагүй. Харин энэ нь уншихад, эрхэмлэн нандигнахад, мөн дагахад зориулагдсан юм. Патриархын адислал тань хамгийн хүнд хэцүү цаг мөчид танд туслах болно. Энэ нь таныг амьдралын аюул дундуур удирдан хөтлөх болно.”

“Your Patriarchal Blessing: A Liahona of Light,” *Ensign*, 1986 оны арваннэгдүгээр сар, 66.

“Тэнгэрлэг Эцэг маань Түүнээс удирдамж хүлээн авах арга хэрэгслээр хангалгүйгээр Түүнд эсэн мэнд, найдвартайгаар эргэж очих мөнхийн аянд биднийг гаргаагүй юм. Би залбирлын тухай ярьж байна. Би бас намуун, зөөлхөн дуу хоолойн шивнээний тухай ярьж байна.”

“Амьдралын уралдаан,” *Лиахона*, 2012 оны 5-р сар, 92.


ХҮҮХДҮҮДЭД ЗОРИУЛАВ

Би замаа олж чадна

Сүнсний зам заагч нь зөвийг сонгож, Аврагчид илүү ойртоход бидэнд тусалдаг учраас бид түүнийг дагадаг байх хэрэгтэй гэж Ерөнхийлөгч Угдорф хэлжээ. Эдгээр зам заагчийн зарим нь залбирал, судрууд, ерөнхий чуулган дээр хэлсэн үгс, тэрчлэн *Лиахона* юм.

Эдгээр зам заагчуудыг дагаж, амьдралын ээдрээ бартаан дундуур өнгөрөн замаа ологтун.

Гэр бүлтэйгээ хамт сүүлчийн ерөнхий чуулган дээр хэлсэн нэг үгийг унш. Зөв зам дээр байхын тулд юу хийхийг үг хэлэгч бидэнд санал болгосон байна вэ? Мэдсэн зүйлээ амьдралд хэрэгжүүлэх зорилгыг гэр бүлтэйгээ хамт тавь.



Энэ материалыг залбирч судлан гэрт нь очиж заадаг эгч нартайгаа аль болох ойлгомжтойгоор ярилц. Эгч нарыг хүчирхэгжүүлэх болон Нийгмийн Халамжийн бүлэг өөрийн тань амьдралд идэвхтэй үүрэг гүйцэтгэхэд туслах асуултаудыг асуу. Нэмэлт мэдээллийг reliefsociety.lds.org-аас үзнэ үү.

Гэр бүлийн түүхээс ирдэг баяр баясгалан

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Рассел М.Нелсон, Елиагийн Сүнс бол “гэр бүлийн бурханлаг мөн чанарыг гэрчиддэг Ариун Сүнсний илэрхийлэл мөн” хэмээн заажээ.¹

Христийн сэргээгдсэн Сүмийн гишүүд бид өвөг дээдсээ судалж, тэдний өмнөөс сайн мэдээний авралын ёслолуудыг хийлгэх гэрээний үүрэг хариуцлагатай билээ. Тэд бидэндгүйгээр “төгс болгогдож” (Еврей 11:40) чадахгүй бас “бид өөрсдийн нас барагсадгүйгээр төгс болгогдож чадахгүй” (С ба Г 128:15).

Гэр бүлийн түүхийн ажил нь мөнх амьдралын адислалуудад биднийг бэлтгэдэг бөгөөд итгэл, хувийн зөв шударга байдлаа нэмэгдүүлэхэд тусалдаг. Гэр бүлийн түүх бол Сүмийн үүрэг зорилгын нэн чухал хэсэг бөгөөд бүхний төлөө аврал, өргөмжлөлийн ажлыг хийх боломжийг бидэнд олгодог билээ.

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ерөнхийлөгч Боид К.Пакер хэлсэн нь: “Бид өвөг дээдсийнхээ



судалгааг эхэлснээр тэдний нэрсээс илүү чухал зүйл бидний сонирхлыг татдаг. . . . Бидний сонирхол зүрх сэтгэлийг маань бидний эцгүүд рүү эргүүлж—тэднийг олж, мэдэж, үйлчлэхийг эрэлхийлдэг.”²

Судруудаас

Малахи 4:5–6; 1 Коринт 15:29;
С ба Г 124:28–36; 128:15

Эшлэл

1. Рассел М.Нелсон, “A New Harvest Time,” *Лиахона*, 1998 оны 7-р сар, 34.
2. Боид К.Пакер, “Гэр бүлийн түүхээ хэрхэн эхлэх вэ?” *Лиахона*, 2011 оны 11-р сар, 17.
3. Сүмийн Ерөнхийлөгчдийн сургаалаас: *Иосеф Смит* (2007), 475.
4. *Daughters in My Kingdom: The History and Work of Relief Society* (2011), 21-ийг үзнэ үү.



Итгэл, Гэр бүл,
Халамж

Бидний түүхээс

Бошиглогч Иосеф Смит ийн сургасан билээ, “Бурхан энэ дэлхий дээр бидэнд ноогдуулсан хамгийн чухал үүрэг хариуцлага бол нас барагсдыгаа эрж олох явдал мөн.”³ Бид нас барсан өвөг дээдсийнхээ өмнөөс ариун сүмд төлөөлөх ёслол хийлгэн тэдний төлөө шаардлагатай ёслолуудыг гүйцэтгэж болно.

14 настай хүү нь нас барсан Иллинойн Наувугийн Салли Рандал мөнхийн гэр бүлийн тухай амлалтаас агуу тайтгарлыг олсон ажээ. Нөхөр нь хүүгийнхээ өмнөөс баптисм хүртсэний дараа тэр төрөл садангууддаа ингэж бичжээ: “Нас барсан бүх өвөг дээдсийнхээ өмнөөс баптисм хүртэж, тэд нас бараад хэчнээн ч олон жил болсон хамаагүй тэдний тухай мэдээлэл цуглуулж чадсан бол . . . тэднийг аварч болдог нь хэчнээн гайхалтай сайхан хэрэг билээ.” Тэгээд тэр өвөг дээдсийнхээ тухай мэдээллийг өөртөө илгээхийг төрөл садангуудаасаа хүсч, “Би [гэр бүлээ] аврахын тулд чадах бүхнээ хийх бодолтой байна” гэжээ.⁴

БИ ЮУ ХИЙЖ ЧАДАХ ВЭ?

1. Хариуцсан эгч нартаа гэр бүлийн түүхийн ажлыг хийхэд нь би хэрхэн тусалж чадах вэ?

2. Би өөрийнхөө түүхийг бичдэг бил үү?

“БИ ЧАМАЙГ МАРТАХГҮЙ”

Беки Сквайре

Би товлосон цагтаа эмч дээрээ очихдоо сэтгэл догдлон итгэл найдвар дүүрэн байлаа. Хэвлий дэх өөдсийн чинээхэн үрийнхээ зүрх цохилохыг би хэт авиагаар аль хэдийн харсан. Түүнээс хойш хэдэн долоо хоног өнгөрчихөөд байхад бяцхан үр минь томорсон баймаарсан. Хэдийгээр би гурван удаа жирэмсэлсэн ч гэсэн бяцхан хүүхдийнхээ зүрх цохилж, хөдөлж эхлэх энэхүү гайхамшигт мэдрэмжийг мэдрэсээр байсан юм.

Би арван минутын дараа машин дотроо ганцаараа уйлж суулаа. Зүрх нь цохилохгүй байгаа, амьгүй хүүхдийн дүр төрх ухаан бодлоос минь гарсангүй.

Дараагийн өдрүүдэд нь би, хагас ухаантай гэмээр гөлөрч, яах ч учраа олохгүй ганцаардмал, хоосон мэдрэмжийг мэдрэч байлаа. Нөхөр маань ажилдаа явахад би гурван хүүхдэдээ хоол ундыг нь хийж өгч, гэр орноо цэвэрхэн байлгахгаар урам муутайхан хичээх болов. Санаагаар унаж, сэтгэл түгшүүртэй байх болов. Нэг удаа ойр зуурын ажлаар гадуур явж ирээд эзгүй байх үеэр хүн утасдаж уу гэдгийг хамгийн түрүүнд шалгалаа. Хэн ч утасдаагүй байлаа. Э-мэйлээ цаг тутам шалгана. Ганц ч э-мэйл алга. Найз нар, хөршүүд маань миний зовлонг огт тоохгүй байгаа юм байхдаа гэж бодлоо. Ерөөсөө тэд миний найз нар мөн гэж үү? Сатан надад нөлөөлж эхэлснийг би мэдсэнгүй.

Нэг орой би бодол санаагаа нөхөртэйгөө хуваалцахад тэрээр болж байгаа зүйлийг тэр дор нь харсан юм. Тэр 1 Нифай 21:15–16-г надтай хуваалцав:

“Би чамайг [мартах] нь үгүй, Ай Израилын угсаа.

Болгоогун, би та нарыг гарынхаа алган дээр сийлсэн; таны хананууд миний өмнө үргэлж байх бөлгөө.”

Би Цагаатгалын тухай өмнө нь судалсан болохоор Цагаатгал гэж юу болохыг мэддэг хэмээн боддог байлаа. Гэвч би үүнийг амьдралтайгаа холбож боддоггүй байжээ. Есүс бидний бүх зовлон, бүх уй гашууг аль хэдийнэ үүрч, үүний төлөө зовсон шүү дээ. Тэр надад ямар байсныг мэдэж байсан нь лавтай.

“Түүний хамгийн дээд үлгэр жишээч үйлдэл болох Цагаатгал нь ‘бүх зүйлээс доогуурт’ (С ба Г 88:6) бууж ирэн, ‘бүх хүмүүний шаналлыг’ (2 Нифай 9:21) хүлцэн тэвчихийг Есүсээс шаардсан юм. Тийнхүү Цагаатгал нь зөвхөн нүглийг даван туулах арга хэрэгслээр хангасан төдийгүй үүнээс илүү өргөн зорилготойг бид тийнхүү ойлгодог. Дэлхий дээр гүйцэлдүүлэх ёстой байсан энэхүү хамгийн агуу үйл хэрэг нь: ‘Хэрэв та нар зүрх сэтгэлийн дүүрэн зорилготойгоор Их Эзэнд хандвал, . . . тэр та нарыг . . . чөлөөлөх болно’ (Мозая 7:33) гэсэн энэхүү амлалтыг биелүүлэх хүчийг Аврагчид өгсөн юм.”¹

Энэхүү эмгэнэлт үед миний уй



ТЭР ОЙЛГОДОГ

“Есүсийн ойлгож чадахгүй тийм зовлон зүдгүүр бидэнд тохиолдоно гэж хэзээ ч байхгүй бөгөөд Тэрээр биднийг залбирлаар дамжуулан Тэнгэрлэг Эцэгтээ буцаж очихыг хүсдэг. Хэрэв бид дуулгавартай, хичээнгүй байх юм бол бидний залбирал хариулагдаж, асуудлууд багасан, айдас арилж, тайтгарал ирж, гутрал цөхрөлийн харанхуй сарнин алга болж, Их Эзэнд улам ойртон Түүний хайр болон Ариун Сүнснээс ирдэг тайтгарлыг мэдрэх болно гэдгийг би гэрчилж байна.”

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Роберт Д.Хейлс, “Behold, We Count Them Happy Which Endure,” *Ensign*, 1998 оны 5-р сар, 77.



гашууг хуваалцах жинхэнэ сайн найз хэн байж болох билээ? Надад тохиолдсон эмгэнэлт явдлыг даван туулахад Аврагчийн тусламж хэрэгтэй байгааг би ухаарсан. Их Эзэнд хандан залбирмагцаа намайг хайрладаг Түүний хайрыг би мэдэрсэн. Би тэд дорoo амар амгаланг мэдэрлээ. Бас Есүс өмнө нь миний хэзээ ч бодож байгаагүйгээр намайг ойлгосныг би мэдэрсэн. Надад тохиолдсон тэрхүү золгүй явдлын дараа миний хамгийн ихээр эгээрэн хүсч байсан, надад хамгийн хэрэгтэй анд найз бол Тэр байлаа.

Би зөвхөн нүглээ наманчлах хэрэгтэй болсон үед төдийгүй намайг тайтгаруулах хэн нэгэн хэрэгтэй үед Аврагчид хандах хэрэгтэй гэдгээ мэддэг. Тэр надад туслахад үргэлж бэлэн байдаг. Бидний зовлон бэрхшээлүүдийг ойлгох хэн нэгэн хэрэгтэй болсон үед хамгийн итгэлтэй анд найз Есүс Христ бидэнд байдгийг мартахагүй байцгаая. ■

Энэ өгүүллийг бичигч АНУ-ын Ютад амьдардаг.

ЭШЛЭЛ

1. Дональд А.Холстром, "Их Эзэнд ханд," *Лиакхона*, 2010 оны 5-р сар, 80.

Нөхөр маань 1 Нифай 21:15–16-г надтай хуваалцав. Уй гашуугаа даван туулахад надад Аврагчийн тусламж хэрэгтэйг би ойлгосон.

БИД АМАР АМГАЛАНГ ОЛЖ ЧАДАХ УУ?

Ерөнхийлөгч Томас С.Монсон бид амьдралдаа амар амгаланг олж болох гурван арга замын тухай өгүүлжээ:

"Би хүмүүний өгдөг амар амгалангийн тухай биш харин Бурханы амласан амар амгалангийн тухай ярьж байна. Гэр оронд, бидний зүрх сэтгэлд, бидний амьдралд байдаг амар амгалангийн тухай би ярьж байна. Хүмүүний замаар ирдэг амар амгалан мөхөж үгүй болдог харин Бурханы замаар ирдэг амар амгалан улам дэгждэг. . . .

Нэгдүгээрт: Дотоод сэтгэлээ шинж. . . . Цэвэр ариун ёс суртахуун, зарчимч байдал, амар амгалан байдлын зарчмуудыг

хөгжүүлэхэд хөтөлдөг зан төлөвийн шинж чанаруудыг хөгжүүлэхгүйгээр хувь хүнд амар амгалан ирэхгүй. . . .

Хоёрдугаарт: Бусдад үйлчилж, тэдэнд тусал. . . . Үйлчлэх үй олон боломж та бидэнд Сүмийн гишүүдийн дунд үргэлж байх болно. . . .

Гуравдугаарт: Тэнгэр өөд хар. Бид ингэснээр залбирлаар дамжуулан Тэнгэрлэг Эцэгтэйгээ харилцсанаас сүнсний хүч чадал, амар амгаланг олоход хөтлөх тайтгарал хийгээд сэтгэл ханамжийг олох болно."

"Амар амгаланг олохуй," Лиакхона, 2004 оны 5-р сар, 3–7.

Та эдгээр гурван санаанаас алийг нь амьдралдаа илүү бүрэн дүүрэн ашигладаг вэ?



Сүмийн
арванхоёр дахь
Ерөнхийлөгч
Спенсер В.Кимбалл
(1895–1985)

ҮНЭН БӨГӨӨД АМЬД БУРХАНЫГ ШҮТЭН БИШИР

*Их Эзэн бидэнтэй хамт
байхад бид юунаас айх юм бэ?*

Итгэлээ ашиглах нь гарт хамгийн ойр байгаа зүйлүүдэд итгэл найдвараа тавихаас үргэлж хавьгүй хэцүү байдгийг бид судруудаас мэддэг билээ. Ийнхүү дэлхийн хүн Бурханд итгэх итгэлээ материаллаг зүйлсээр солиход бэлэн байдаг. Тиймээс бүх эрин зуунуудад хүмүүн Сатаны хүчин дор сөхрөн итгэлээ алдаж, найдвараа “махан биеийн мутарт” мөн “юу ч үздэггүй, юу ч сонсдоггүй, юу ч ойлгодоггүй алт, мөнгө, хүрэл, төмөр, мод чулуун бурхдад” (Даниел 5:23) буюу хиймэл шүтээнүүдэд тавьсаар ирсэн юм. Энэ бол Хуучин Гэрээний зонхилох сэдэв гэдгийг би мэднэ. Хүн зүрх сэтгэл, итгэл найдвараа юун дээр хамгийн ихээр тавьдаг вэ? гэвэл түүний бурхан юм. Хэрэв түүний бурхан Израилын амьд Бурхан биш аваас тэр хүн хиймэл шүтээн шүтдэг байж таарна.

Бид Нифайн зөвлөмж болгосны дагуу судруудыг уншиж, “тэдгээрийг өөрсөдтэйгөө адилтгахыг” (1 Нифай 19:24) хичээх юм бол эртний хиймэл шүтээний дүрсүүд, өнөө үеийн бидний зан төлөвийн хэв шинжийн хооронд олон адил төстэй зүйл

байгааг харах болно гэдэгт би баттай итгэдэг.

Их Эзэн биднийг үргэлж адисалсаар байдаг. . . . Бидний мэдэлд хангалттай нөөц боломжууд байдаг бөгөөд эдгээр нь дэлхий дээр бидний хийх ажилд чухал юм. Гэвч биднээс олон нь . . . Бурханаас бидэнд соёрхсон нөөц боломжуудыг хуурамч шүтээн болгон шүтсэнээс тэдгээр нь эргээд бидний эрхшээлдээ оруулах хүчтэй болж байна уу даа хэмээн би айдаг. Бид эдгээр сайн зүйлүүдээс олныг нь итгэлээсээ илүү эрхэмлэдэг болж байна уу даа? Олон хүмүүс мөнгө, өмч хөрөнгө, үнэт цаас, хөрөнгө оруулалтын багц, газар, зээлийн карт, тавилга, авто машинууд болон бусад зүйлсийг махан биеийнхээ аюулгүй байдлын *баталгаа* болгож, өөрийн дүр төрхийг бүтээхийн төлөө хамаг цаг заваа зориулж байна. . . .

Бидний үүрэг

Бид эдгээр нөөц боломжуудыг гэр бүлдээ болон чуулгууддаа Бурханы хаант улсыг байгуулах, номлолын ажил, удмын бичиг болон ариун сүмийн ажилд дэмжлэг үзүүлэх, үр хүүхдээ Их Эзэний үр бүтээлтэй үйлчлэгчид болгон өсгөн хүмүүжүүлэх, бусад хүмүүс ч мөн итгэлтнүүд байхын тулд тэднийг зүйл бүрээр адислахад ашиглах үүргээ үл тоомсорлож байна. Бид үүний оронд эдгээр адислалуудыг, “Яагаад та нар амьгүй болох түүгээр өөрсдийгөө чимэглэх мөртлөө өлсгөлөн мөн гачигдалтай, мөн

нүцгэн, мөн өвчтэй, мөн шаналсан нь хажуугаар тань өнгөрөн одохыг зөвшөөрч, мөн тэднийг эс анзаарна вэ” (Мормон 8:39) хэмээн Моронайн хэлсэнчлэн хувийн хүслээ хангахад зориулж байна.

Их Эзэн Өөрөө манай өнөө үед ингэж хэлсэн юм, “Түүний зөв шударга ёсыг бий болгохын тулд тэд Их Эзэнийг эрэлхийлдэггүй, харин дэлхийнхтэй адил дүр төрх бүхий өөрийнхөө бурхны дүр төрхийг дуурайн хүн болгон өөрийнхөө замаар замнадаг бөгөөд тэдний эд хөрөнгө нь хуучирч өгөршин Вавилонд, бүр унах тэрхүү агуу Вавилонд мөхөх *хиймэл шүтээнийх* бөлгөө” (С ба Г 1:16; онцлон тэмдэглэлт нэмэгдсэн).

Агуу адислалаа хэрэггүй юмаар бүү соль

Миний таньдаг нэг хүн Сүмд үйлчлэх албан тушаалд дуудагдсан ч хувийн бизнес нь Их Эзэний ажилд зориулж цаг гаргах боломжгүй тийм их учраас дуудлагыг хүлээн авах боломжгүй байсан гэж боддог байлаа. Тэр хүн Их Эзэнд үйлчлэхээ орхиж, дэлхийн эд баялагийн төлөө эрэлд гарсан бөгөөд эдүгээ саятан болоод байна.

Харин би саяхан нэгэн сонирхолтой баримтыг олж мэдлээ. Хэрэв хүн сая долларын үнэтэй алтыг эзэмшдэг байлаа гэж бодвол энэ нь ойролцоогоор дэлхийн царцдаас дахь бүх алтыг хорин долоон тэрбум хуваасны ердөө ганцхан хувь нь ажээ. Энэ бол хүмүүний оюун ухаанд төсөөлөх аргагүй өчүүхэн

тоо юм. Гэвч үүнээс хавьгүй илүү нэг онцгой чухал зүйл бий: Их Эзэн энэ дэлхийг бүтээсэн бөгөөд үүнийг удирдах бүх хүч Түүнд байдаг мөн “тоо томшгүй” (Мосе 1:33) олон бусад дэлхийнүүдийг бүтээсэн бөгөөд хүн санваарын тангараг ба гэрээг хүлээн авснаар (С ба Г 84:33–44-ийг үз), “Эцэгт минь байгаа бүхнийг” (С ба Г 84:38) хүлээн авах болно гэсэн амлалтыг Их Эзэнээс хүлээн авдаг билээ. Жижигхэн алттай хайрцагны төлөө, махан биеийн аюулгүй байдлын төлөө эдгээр агуу амлалтуудыг тоомсорлох нь хэтийн төлөвтөө юутай ч зүйрлүүлшгүй том алдаа гаргаж байгаа явдал юм. Сэтгэл хангалуун байдлыг олохын тулд түүний бий болгосон зүйл нь өрөвдмөөр хөөрхийлөлтэй юм. Учир нь хүмүүний бодгалийн үнэ цэнэ үүнтэй зүйрлүүлэх аргагүй их юм.

Нэг залуу номлолд дуудагдаад энэ ажлыг хийх авьяас чадваргүй гэж өөрийгөө голжээ. Харин тэр шинэ машинаа дээд зэргээр халамжлан гамнаж эдлэхдээ гаргуун нэгэн байж. . . . Сайхь залуугийн аав нь хүүгийнхээ талаар “Манай хүү ямар ч юмыг гараа гаргаж, хийсэн шиг хийдэг хүн. Энэ чинь л болоо шүү дээ” хэмээн үргэлж магтдаг байлаа.

Бурханы хүүд энэ чанар үнэхээр хангалттай гэж үү? Машиных нь хүч далай тэнгисийн буюу нарны хүчтэй харьцуулахад хумхийн тоос лугаа адил өчүүхнийг, хуулиар хийгээд санваараар хянагддаг олон гараг ертөнц байдгийг, түүний эзэмшдэг санваарын хүчийг Их Эзэнд үйлчилснээр улам хөгжүүлдгийг энэ залуу ойлгоогүй ажээ. Тэрээр ган, резин хоёроос бүтсэн, гялалзсан будагтай, үнэ цэнэгүй

бурхныг өөртөө бий болгон түүнээсээ сэтгэл ханамжийг олдог ажээ.

Настай нэгэн хос ажил хөдөлмөрөөсөө бас Сүмээс ч гэсэн амарч тэтгэвэртээ гарчээ. Тэд аяллын тоног төхөөрөмжтэй ачааны жижиг машин худалдаж аваад дэлхийг үзэхээр гэрээ орхин явжээ. Ариун сүмд орох, удмын судалгаа хийх, номлолд үйлчлэх цаг зав тэдэнд байсангүй. Нөхөр нь дээд пристүүдийн чуулгатайгаа холбоо тасарч, хувийн түүхээ гэртээ бичих ч завгүй болсон гэнэ. Тэдний туршлага, удирдлагын ур чадвар салбарт нь туйлын чухал байсан ч тэд зав гаргаагүй ажээ. . . .

Хэрэв бид бүх цаг зав, нөөц боломжоо өөрсдөдөө зориулж, дэлхийн хаант улсыг байгуулахад зориулах аваас бид үүнийгээ өвлөн авах болно.





Хэрэв хүн мөнхийн ямар нэг зүйлийг жинхэнэ хэтийн төлөвөөр нь харах юм бол адислалууд нь “дэлхийн” зүйлсийг орхисны үнэ цэнээс асар их юм.

Дэлхийн зүйлүүдийг орхи

Бид өнгөрсөн үеийн хүмүүст байгаагүй тансаг зүйлсийг эзэмшин хэрэглэдэг орчин үеийн азтай хүмүүс гэж өөрсдийгөө боддог бол Их Эзэнд хамгийн жигшүүртэй зүйл болох хиймэл шүтээнийг бишрэн шүтэгчид болсон нь тэр.

Бид Их Эзэний ирэлтэд бэлтгэх үүргээсээ амархан няцдаг. Хэрэв бид зөв шударга байх юм бол Их Эзэн дайснууд бидэн дээр ирэхийг үл хүлцэн . . . бидний төлөө бидэнтэй хамт тулалдах болно гэдгийг бид мартдаг (Египетээс Гарсан нь 14:14; С ба Г 98:37-г үзнэ үү. Эдгээр нь үй олон эшлэлээс зөвхөн хоёрхон нь юм). . . .

Их Эзэн бидэнтэй хамт байхад бид юунаас айх юм бэ? Бид Түүнд итгэх итгэлийнхээ жижигхэн хэсгийг ч болов ашиглахгүйгээр Их Эзэнд итгэлтэй байж чадна гэж үү? Бидний

үүрэг тодорхой юм. Бид дэлхийн зүйлүүдийг амьдралынхаа зорилго болгодгоо бас хиймэл шүтээн шүтдэгээ орхин, итгэлээрээ жигүүрлэн урагш тэмүүлж, тэд бидний дайснууд байхаа больж болохын тулд сайн мэдээг дайснууддаа хүргэх явдал мөн.

Улам илүү их итгэлийг хөгжүүл

Бид өнөө үеийн хиймэл шүтээнүүдийг хийгээд “махан биеийн мутарт” найддагаа орхих ёстой. Учир нь Их Эзэн өнөө үед бүх дэлхийд хандан, “Вавилонд үлдсэн хэнийг ч би амь хэлтрүүлэх нь үгүй” (С ба Г 64:24) гэж хэлсэн билээ. . . . Их Эзэний чиглүүлснээр хүн бүрийг, гэр бүл болгоныг бэлтгэх зам нь итгэлээ илүү идэвхтэй ашиглан, наманчилж, дэлхий дээрх Түүний хаант улс болох Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн ажилд оролцох явдал мөн

гэдэгт бид итгэдэг. Энэ нь эхлээд бага зэрэг хэцүү юм шиг санагдаж болно, гэвч хүн энэ ажлын үнэнийг ойлгохоороо, мөнхийн ач холбогдолтой ямар нэг зүйлийг хэтийн төлөвөөр нь харж, адислалууд нь “дэлхийг” орхисны үнэ цэнээс асар их болохыг харж эхэлдэг.

Жинхэнэ аз жаргал энэхүү зарчимд оршино. Тиймээс бид газар бүрийн бүх хүмүүсийг энэ ажилд нэгдэхийг урьдаг. Бүх талаар золиослол хийж, Их Эзэнд үйлчлэхээр эргэлтгүй шийдсэн хүмүүст мөнх амьдралд хүрэх зам нээлттэй байдаг. Үүнээс бусад аливаа зүйлс нь зөвхөн уг зорилгод хүрэхийн тулд ашиглах төдий зүйлс юм. ■

Дэд гарчгууд нэмэгдэж, зөв бичгийн дүрэм, цэг таслал, том үсгээр бичих дүрмийг стандартын дагуу болгосон.

“The False Gods We Worship,” Tambuli, 1977 оны 8-р сар, 1–4.

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСТ ҮЙЛЧЛЭХ НЬ

Беки Янг Фосетт

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст үйлчлэх Сүмийн үйлчлэл

Линн Парсонс Техасын Хөрст гадасны хөгжлийн бэрхшээлтэй гишүүдийн зохицуулагчаар дуудагдаад гадасныхаа гишүүдийн ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй гишүүд болон тэдний гэр бүлийн амьдралыг адислах замаар дуудлагаа биелүүлэхийг хүссэн ажээ.

Линн эгчийн анхны хийсэн зүйлүүдийн нэг нь LDS.org (lds.org/callings/disability-specialist) дахь дуудлагынхаа талаар мэдээллийг нэгтгэн дүгнэж, хөгжлийн бэрхшээлийн талаарх Сүмийн албан ёсны бодлогыг ойлгохын тулд *Гарын авлага 2: Сүмийг удирдах нь* номыг уншжээ. Хөгжлийн бэрхшээлийн тухай (lds.org/disability) вэб сайт нь бас чухал эх сурвалж болсон ажээ. Уг вэб сайт хөгжлийн янз бүрийн бэрхшээл болон гадасныхаа гишүүдтэй хуваалцах сайн эх сурвалж материал болсон гэнэ.

Гарын авлага 2-т, “Бишопын зөвлөл болон гадасны ерөнхийлөгчийн зөвлөл хувь хүмүүс болон гэр бүлдүүдэд туслах тойргийн буюу гадасны хөгжлийн бэрхшээлтэй гишүүдэд үйлчлэх зохицуулагчийг дуудаж болно”¹ гэж зааварласан байдаг. LDS.org-т энэ дуудлагын талаар нэмэлт мэдээлэл өгч, “хөгжлийн

бэрхшээлтэй гишүүдэд үйлчлэх зохицуулагчийн үүрэг нь Сүмийн хөгжлийн бэрхшээлтэй гишүүдийн оролцоо, идэвхийг сайжруулахад туслах явдал мөн хэмээн тайлбарлажээ.”²

Линн эгч үүнийг ойлгосноор “хөгжлийн бэрхшээлтэй гишүүдэд үйлчлэхэд хэрэгтэй арга хэрэгслийг олоход нь удирдагчдад туслахыг” хүссэн юм гэж хэллээ.

Линн бас нийгмийн болон үндэсний эх сурвалжууд, интернет болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй ажиллаж байсан гадасны болон тойргийн гишүүдээс холбогдох мэдээллийг олж ашигласан байна. Тэрээр эдгээр эх сурвалжуудыг бас гадасныхаа удирдагчид болон гэр бүлдүүдэд тулгарч байгаа сорилтуудын шийдлийг олохын тулд ашигласан ажээ. Бид мэдээлэл, тусламж олж авахын тулд хэнд хандахыг мэдэхгүй үедээ “залбирахыг чин сэтгэлээсээ хүсч сүнсээр өдөөгдвөл хариу хүлээн авах болно” гэж тэр ярилаа.

Хэрэгцээг ойлгосон нь

Линн бас өөрийн бүс дэх хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй холбоотой хэрэгцээг мэдэхийн төлөө ажилладаг ажээ. Тэр энэ ажлыг хийхийн тулд өөрийнх

нь дуудлагын талаарх мэдээллийг агуулсан захидлыг бишопуудад явуулахыг гадасны удирдагчдаас хүссэн ажээ. Уг захидалд хөгжлийн бэрхшээлийн асуудлаар түүнээс тусламж авах хэрэгтэйг бишопуудад сануулсан гэнэ. Мөн тэрээр гадасны Хүүхдийн Хэсгийн ерөнхийлөгчийн зөвлөлд уг асуудлыг ойлгуулж, бусад бүлгүүдийн удирдагчидтай уулзан төлөвлөгөө гаргасан байна. “Би мэдээллийг өөрөө олж авахын хамт эдгээрийг хаанаас олж болохыг хүмүүст мэдүүлэхийг хүссэн юм” гэж Линн яриу.

Линн гадасны гишүүдэд үйлчлэхэд бэлэн байгаагаа мэдүүлснээр удалгүй удирдагчдад туслах боломжтой болжээ. Хөгжлийн бэрхшээлтэй гишүүдэд үйлчлэх зохицуулагчаар дуудагдсанаас хойш хэдхэн сарын дараа хөгжлийн бэрхшээлтэй гишүүдтэй ажиллах онцлогийн талаар тойргийн зөвлөлд таницуулахыг урьсан гэнэ. Тэрээр бас зожиг хүүхдэд хэрхэн заахыг ойлгоход нь нэг багшид тусалж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд заах Хүүхдийн Хэсгийн багшийн туслахыг дуудах санал гаргаж, хичээлд нь сууж зөвлөгөө өгсөн ажээ.

Линн эгч үүний дараа удирдагчдад дуудлагаа биелүүлэхэд нь туслахаар төлөвлөжээ. Тэр ингэхийн тулд бусдыг, түүний дотор хөгжлийн бэрхшээлтэй гишүүдийг хайрлаж, туслан, тэдэнтэй нөхөрлөхөд Аврагчийн үлгэр жишээг дагахад нь гадасны гишүүдэд тусалж байна. ■

ЭШЛЭЛ

1. *Гарын авлага 2: Сүмийг удирдах нь* (2010), 21.1.26
2. “Disability Specialist,” www.lds.org/callings/disability-specialist.







Тэргүүн Зөвлөлийн
хоёрдугаар зөвлөх
**Ерөнхийлөгч
Жеймс И. Фауст
(1920–2007)**

ТӨӨРӨӨД АЛГА БОЛСОН ХОНЬД Ч ГЭСЭН ҮНЭ ЦЭНЭТЭЙ

*Дуулгаваргүй хүүхдүүддээ заахдаа залбиралтай байдаг,
зүрх сэтгэл нь шаналсан, зөв шударга, хичээнгүй эцэг
эхчүүд та нарт Сайн Хоньчин тэдгээрийг харж
байгаа гэдгийг бид хэлж байна.*

Ерөнхийлөгч Жеймс И. Фауст Тэргүүн Зөвлөлийн хоёрдугаар зөвлөхөөр 1995 оны 3-р сарын 12-нд дэмжин батлагдсан ба 2007 оны 8-р сарын 10 хүртэл энэхүү дуудлагадаа үйлчилсэн. 2003 оны 4-р сарын ерөнхий чуулган дээр танилцуулагдсан эцэг эхчүүдэд хандсан энэхүү яриа нь гэр бүлийг хүчирхэгжүүлэх талаарх хэд хэдэн өгүүллийн нэг болж энэ дугаарт орж байна.

Хайрт ах, эгч, найз нар минь, энэ өглөө өгч буй миний энэ захиас хүүхдүүдээ хайраар зөв шударгад өсгөхдөө чадахынхаа хэрээр зүтгээд, зүрх сэтгэл нь шаналсан эцэг эхчүүдэд өгөх найдвар мөн тайвшрал юм. Тэд хүүхэд нь хилэнцэт ба сүйрлийн замыг дагахаар эсэргүүцэхэд эсвэл замаасаа гажиж төөрсний нь улмаас цөхөрсөн байдаг. Та нарын мэдэрч буй гүн шаналалын талаар бодож суухад Иеремиагийн үгс миний санаанд орж ирэв: “Дуу Рамад сонсдов, . . . Рахел хүүхдүүдийнхээ төлөө уйлна. Тэрээр тайтгарлыг авахгүй байна.” Энэ үед Их Эзэн ийн тайтгарал өгсөн: “Уйлахаас дуу хоолой . . . тэвчин барь. Учир нь чиний үйлс шагнагдана . . . ; Тэд дайсны нутгаас буцаж ирнэ”.¹

Энэ сүм дэх эцэг эхчүүдэд зориулсан Их Эзэний үг, Сургаал ба Гэрээний 68-р хэсэгт энэхүү онцгой заавар агуулагдаж байдаг хэмээх гэрчлэлээрээ би үгээ эхлэх ёстой: “Мөн дахин, Сионд эсвээс түүний зохион байгуулагдсан аль

Төөрөлдсөн тэдгээр нь “гэм нүглийнхээ төлөө шаналах болно; бартаатай замаар алхаж магадгүй, хэдий ч энэ нь нүглээ наманчилсан Үрэлэн хүүгийн адилаар эцэст нь тэднийг хайрладаг, өршөөдөг эцгийн зүрх сэтгэлд ба гэртээ ирэхэд хөтөлдөг бол гашуун сургамж нь дэмий хоосон байхгүй.”



ч гадаснуудад эцэг эхчүүд хүүхдүүдтэй байхын хэрээр, тэдэнд наманчлалын сургаал амьд Бурханы Хүү Христэд итгэх итгэл хийгээд баптисм хүртээх мөн гар тавилтаар ирдэг Ариун Сүнсний бэлгийг ойлгохыг тэд заадаггүй бол, найман нас хүрэхэд, уг нүгэл эцэг эхчүүдийнх нь тэргүүн дээр байх болно.”² Эцэг эхчүүд “залбирахыг, мөн Их Эзэний өмнө цэх шулуун алхахыг хүүхдүүддээ заах”-аар зааварлагддаг.³ Эцэг, өвөө, элэнц эцэг хүний хувьд би үүнийг Их Эзэний үг хэмээн хүлээн авч, Есүс Христийн үйлчлэгчийн хувьд би эцэг эхчүүдийг энэхүү зөвлөгөөг чадахынхаа хэрээр, чин сэтгэлээсээ дагахыг шаардаж байна.

Ямар хүмүүс сайн эцэг эх байдаг вэ? Тэд бол үлгэр жишээ ба “залбирахыг, мөн Их Эзэний өмнө цэх шулуун алхах” дүрмээр хүүхдүүддээ заахын тулд хайр, залбирал, үнэн сэтгэлээрээ хичээсээр байдаг тэдгээр нь юм.⁴ Зарим хүүхдүүд дуулгаваргүй эсвэл дэлхийн хэрэгт автсан байдаг ч энэ нь үнэн билээ. Хүүхдүүд энэ дэлхийд өөрсдийн гэсэн сүнс ба хувийн зан чанартай ирдэг. Зарим нь “ямар ч нөхцөл байдалд, ямар ч эцэг эх байсан сорьдог. . . . Магадгүй, ямар ч эцэг эсвэл эх байсан амьдралыг нь адисалж мөн баяр баясгалан нь болдог хүүхдүүд бас байдаг.”⁵ Сайн эцэг эхчүүд гэдэг бол гэр бүлийнхээ нөхцөл байдалд чадах хэрээрээ золиослол хийн тэмцсээр байгаа хүмүүс юм.

Хүүхдүүдээ гэх эцэг эхийн хайр хэмжигдэх боломжгүй юм. Өөр ямар ч харилцаа үүнтэй адил биш. Тэд өөрсдийнхөө амьдралыг хүүхдүүдээ аврахын төлөө өгөхөд бэлэн байдаг. Хүүхдээ гэх эцэг эхийн хайр бол хувиршгүй бөгөөд зүрх шимшрэх болон сэтгэл гонсойх зэргийг ч давж гарна. Бүх эцэг эхчүүд хүүхдүүдээ ухаалаг шийдвэр гаргаасай хэмээн найддаг ба залбирч байдаг. Дуулгавартай, хариуцлагатай хүүхдүүд эцэг эхдээ төгсөшгүй бахархал, сэтгэл хангалуун байдлыг авчирдаг билээ.

Итгэлтэй, хайрладаг эцэг эхээр заалгасан тэдгээр хүүхдүүд эсэргүүцэн эсвэл төөрч одвол юу болох вэ? Найдвар байна уу? Дуулгаваргүй хүүхдийнхээ төлөөх эцэг эхийн уйтгар гуниг бараг тайтгаршгүй юм. Хаан Давидын гуравдах хүү Абсалом ах нарынхаа нэгийг алж түүнчлэн эцгийнхээ эсрэг бослогыг удирджээ. Абсалом Иоабд алуулсан. Абсаломын үхлийн тухай сонссон Хаан Давид уйлан уйтгар гунигаа ийн илэрхийлсэн: “Миний хөвгүүн Абсалом минь, хүү минь. Миний хөвгүүн Абсалом минь. Чиний оронд би үхсэн бол дээр байсан юм. Абсалом хүү минь, хүү минь.”⁶

Эцэг эхийн ийм хайр үрэлгэн хүүгийн тухай сургаалт үлгэрт бас илэрдэг. Өвлөн авсан эд хөрөнгөө замбараагүй амьдралд үрэн таран хийснийхээ дараа дуулгаваргүй хүү нь гэртээ буцаж ирэхэд эцэг нь тарган тугал нядалж үрэлгэн хүүгийнхээ буцаж ирснийг тэмдэглэдэг. Тэр дуулгавартай хүүдээ “Харин чиний дүү үхсэн байсан.

Гэтэл одоо амьдарчээ. Алдагдсан боловч олдлоо. Иймээс бид баярлан цэнгэх ёстой” хэмээн уурлан ундууцах үед нь хэлжээ.⁷

Би Ахлагч Орсон Ф.Уитнийн [1855–1931] хэлсэн:

“Бошиглогч Иосеф Смит, итгэлтэй эцэг эхчүүдийн мөнхийн холболтууд ба Үнэний учир шалтгаанаар зоригтой үйлчилснийх нь төлөө тэдэнд өгөгдсөн ариун нандин амлалтууд нь тэднийг төдийгүй үр удмыг нь авардаг хэмээх сургаалыг тунхагласан бөгөөд үүнээс илүү тайтгаруулах сургаалыг заагаагүй билээ. Зарим хонь төөрч болох ч Хоньчны нүд тэдний дээр байдаг ба эрт орой хэдийд ч тэд тэдний араас ирж хашаанд нь буцааж аваачих Тэнгэрлэг тусламжийн гарыг мэдрэх болно. Тэд шударга ёсоор өрөө төлөх ёстой болно; тэд гэм нүглийнхээ төлөө шаналах болно; бартаатай замаар алхаж магадгүй; хэдий ч энэ нь нүглээ наманчилсан Үрэлгэн хүүгийн адилаар эцэст нь тэднийг хайрладаг, өршөөдөг эцгийн зүрх сэтгэлд болон

Хүүхдээ гэх эцэг эхийн хайр хувиршгүй бөгөөд зүрх шимшрэм, сэтгэл гонсойлгосон зүйлийг ч давж гарна. Бүх эцэг эхчүүд хүүхдүүдээ ухаалаг шийдвэр гаргаасай хэмээн найдаж мөн залбирч байдаг.



Үрэлгэн хүүг гэр бүлдээ урьсан ч түүний эд хөрөнгө үрэгдэж дууссан байсан. Нигүүлсэл нь шударга ёсыг дээрэмдэхгүй. Итгэлтэй эцэг эхчүүдийн мөнхийн холболтын хүч төөрөлдсөн хүүхдүүдийн дээр тэдний наманчлал ба Христийн Цагаатгалын нөхцөлд л баталгаатай байх болно.



гэртээ ирэхэд хөтөлдөг бол гашуун сургамж нь дэмий хоосон байхгүй. Хайхрамжгүй, дуулгаваргүй хүүхдүүдийнхээ төлөө залбир, итгэлээрээ тэдгээрт та тэвчээртэй бай. Их Эзэний авралыг хартлаа найд, итгэ” хэмээх тайтгаруулах мэдэгдэлд итгэн хүлээн зөвшөөрдөг.⁸

Энэхүү мэдэгдлийн байнга орхигддог нэг зарчим бол тэд бүрэн наманчлах, “гэм нүглийнхээ төлөө шаналах” ба “шударга ёсоор өрөө төлөх” ёстой байх явдал юм. Одоо “Их Эзэнтэй уулзахад бэлтгэх” цаг нь гэдгийг би ухаарч байна.⁹ Төөрөлдсөн хүүхдүүдийн наманчлал энэ амьдралд тохиолдохгүй аваас тэдгээрийн наманчлалыг гүйцэтгэхэд холболтын хүч хангалттай хүчтэй байх боломж хэвээр байна уу? Сургаал ба Гэрээнд бидэнд хандан:

“Наманчилдаг нас барагсад, Бурханы өргөөний ёслолуудад дуулгавартай байснаар дамжуулан гэтэлгэгдэх болно”,

“Мөн тэд зөрчлийнхөө цээрлэлийг төлсний, мөн угагдан цэвэршсэний дараа, ажлуудынхаа дагуу шагналаа хүлээн авах болно, учир нь тэд авралыг өвлөгчид бөлгөө”¹⁰ хэмээн заажээ.

Бид үрэлгэн хүү өвлөсөн эд хөрөнгөө үрж бүх зүйл нь байхгүй болсныхоо дараа эцгийнхээ гэрт эргэж ирснийг санадаг. Тэгэхэд түүнийг гэр бүлдээ урьсан ч түүний эд хөрөнгө үрэгдэж дууссан байсан.¹¹ Нигүүлсэл нь шударга ёсыг дээрэмдэхгүй. Итгэлтэй эцэг эхчүүдийн мөнхийн холболтын хүч төөрөлдсөн хүүхдүүдийн дээр тэдний наманчлал ба Христийн Цагаатгалын нөхцөлд л баталгаатай байх болно. Наманчлалтай төөрөлдсөн хүүхдүүд аврал ба түүнтэй хамт ирэх бүхий л адислалуудыг хүлээн авах ч өргөмжлөл нь хамаагүй илүү зүйл юм. Энэ нь бүрэн дүүрэн төлөгдсөн байх ёстой. Хэн өргөмжлөгдөх вэ гэсэн асуулт нь Их Эзэнд, Түүний нигүүлсэлд үлдэх ёстой.

Эсэргүүцэл ба хилэнцийн үр нь агуу байх “наманчилж чадахааргүй их гэм нүгэл үйлдсэн” тэдгээр нь үлэмж цөөхөн

байдаг.¹² Тэрхүү шүүлт нь Их Эзэнд түүнчлэн үлдэх ёстой. Тэрээр бидэнд: “Их Эзэн, бибээр өршөөх түүнийгээ өршөөх болно, харин бүх хүмүүнийг уучлах нь та нараас шаардагдана” хэмээн хэлдэг.¹³

Бидэнд зөв шударга эцэг эхчүүдийн хүүхдүүдтэйгээ холбогдох холболтын хүч хэр зэрэг бат бөх болохыг энэ дэлхийд бүрэн гүйцэд ойлгох нь өгөгдөөгүй байж болох юм. Бидний мэддэгээс илүү туслах эх сурвалжууд байдаг нь маш сайн байж болно.¹⁴ Хөшигний нөгөө талаас ирэх хайртай өвөг дээдсийн маань нөлөөлөл бидэнтэй үргэлжилж байх учраас гэр бүлийнхнээс маань нас эцэслэсэн хүмүүсийн хүчтэй нөлөө байдаг гэдэгт би итгэдэг.

Ерөнхийлөгч Ховард В.Хантер [1907–95] “наманчлал бол бодгалийн гэрээ санасан байдал боловч эцэг эхийн тасралтгүй ба болгоомжтой халамж нь Их Эзэний хувиршгүй өршөөлийн газар дэлхий дээрх хамгийн шударга хэлбэр нь юм” хэмээн тэмдэглэжээ. Аврагчийн зорилгоороо тогтоохоор эрэлхийлсэн, хамгийн адилхан зүйл нь гэр бүл биш үү?¹⁵

Бид эцэг эхээсээ эцэг эх болох талаар их зүйл сурдаг. Миний эцгээ хайрлах хайр түүний найрсаг, тэвчээртэй бас намайг ойлгодог байхаас нь улам гүнзгийрсэн билээ. Намайг гэр бүлийнхээ автомашиныг эвдэх үед тэр зөөлөн бас өршөөнгүй байсан. Хэрэв хүүхдүүд нь үнэнийг нуух эсвэл дүрмүүдийг үргэлжлүүлэн зөрчих, ялангуяа эхээ үл хүндэтгэвэл хатуу сахилгажуулдаг байлаа. Эцэг минь өнгөрөөд бараг хагас зуун жил болсон ч түүний ухаалаг, хайрлам зөвлөгөөг авахаар түүн дээр очдог байснаа би одоо хүртэл үнэхээр их санаж байдаг. Би түүний зөвлөгөөг үе үе асуудаг байсан ч түүнээс намайг хайрлах хайрыг хэзээ ч нэхэж чадаггүй байсан. Би түүний сэтгэлийг гонсойлгохыг хэзээ ч хүсэж байгаагүй.

Бид эцэг эхчүүд болохын хувьд чадахынхаа хэрээр хийх нэг чухал зүйл бол хайрлах явдал ч бас чанд сахиага бат юм. Бид хүүхдүүдээ сахилгажуулахгүй бол



бидэнд эсвэл хүүхдүүдэд маань нийцэхгүй арга замаар нийгэм үүнийг нь хийж магад. Хүүхдүүдээ сахилгажуулах ажлын нэг хэсэг бол тэднийг хөдөлмөрлөхөд сургах явдал юм. Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли [1910–2008]: “Хамгийн агуу үнэт зүйлсийн нэг бол . . . шударга хөдөлмөрлөх урам зориг байдаг. Хөдөлмөргүй мэдлэг бол үр ашиггүй. Хөдөлмөрлөсөн үед мэдлэг бол сод ухаан юм”¹⁶ хэмээн хэлжээ.

Газар сайгүй тархсан Сатаны урхи ихэссээр байгаа, үүний улмаас хүүхэд өсгөн хүмүүжүүлэх нь улам хэцүү болж байна. Тиймээс, эцэг эхчүүд чадахынхаа хэрээр хамгийн сайнаа хийж сүмийн үйлчлэл ба үйл ажиллагаагаар өгөгдөж болох тусламж дэмжлэгийг авах хэрэгтэй. Эцэг эхчүүд түр ч гэсэн биеэ буруу авч явах ба замаасаа холдвол зарим хүүхдүүд тэрхүү үлгэр жишээнээс амархан сурч авах хандлагатай байдаг.

Одоо зоосны нөгөө талыг дурдах хэрэгтэй байна. Би эцэг эх нь байх ёстойгоосоо дор байсан хэдий ч тэдэнд гараа сунган туслахыг эцэг эхээсээ хөндийрсөн хүүхдүүдээс гуйж байна. Эцэг эхийнхээ талаар шүүмжлэлтэй байдаг хүүхдүүд Моронайн: “Миний төгс бусын улмаас намайг, бас түүний төгс бусын улмаас эцгийг минь ч, бас түүний өмнө бичсэн тэднийг ч бүү буруушаа; харин та нар бидний байснаас илүү ухаалаг байхад сурч болохын тулд, бидний

Үлгэр жишээ болон "залбирах, мөн Их Эзэний өмнө цэх шулуун алхах"-ыг заахын тулд хайр, залбирал, үнэн сэтгэлээрээ ямагт хичээдэг тэдгээр нь сайн эцэг эхчүүд юм. Зарим хүүхдүүд дуулгаваргүй эсвэл дэлхийн зүйлст автсан байдаг ч энэ нь үнэн билээ.

Би тэдэнд гараа сунган туслахыг эцэг эхээсээ хөндийрсөн хүүхдүүдээс гуйж байна. . . . Би бүх хүүхдүүд аажимдаа зүрх сэтгэлээ эцгүүд рүүгээ түүнчлэн эхчүүд рүүгээ хандуулах болно гэж найдаж байна.



төгс бусыг та нарт илчилсэнд нь Бурханд талархлаа мэдүүл” хэмээн хэлсэн ухаалаг зөвлөгөөг сайн санаж магад.¹⁷

Моронай залуу бошиглогч Иосеф Смит дээр 1823 онд айлчлах үедээ Елиагийн номлолтой холбоотой дараах шүлгээс эш татсан байна: “Мөн тэрээр эцгүүдэд нь хийсэн амлалтуудыг хүүхдүүдийнх нь зүрх сэтгэлд суулгах болно, мөн хүүхдүүдийнх нь зүрх сэтгэл эцгүүд рүүгээ эргэх болно.”¹⁸ Би бүх хүүхдүүд аажимдаа зүрх сэтгэлээ эцгүүд рүүгээ түүнчлэн эхчүүд рүүгээ хандуулах болно гэдэгт найдаж байна.

Залуу байхдаа миний мэддэг байсан нэгэн гайхамшигтай хос дуулгаваргүй бөгөөд гэр бүлээсээ хөндийрсөн нэгэн хүүтэй байсан юм. Хожим нь олон жилийн дараа тэрээр эвлэрсэн бөгөөд тэр гэр бүлийн хамгийн энэрэнгүй, халамжтай хүүхэд нь болсон. Биднийг нас ахих тусам хөшигний нөгөө талд байгаа бидний эцэг эх, өвөө эмээ нарын нөлөө улам хүчтэй болдог. Тэд бидний зүүдэнд ирдэг нь таатай мэдрэмж байдаг.

Зарим хүүхдүүд нь эцэг эхийнхээ заасан зүйлс ба хайрыг эсэргүүцэн эсвэл хөндийрдөг учраас сайхан сэтгэлтэй, итгэлтэй эцэг эхчүүдийг шүүх нь шударга бус бөгөөд хатуудсан хэрэг болно. Тайвшрал, сэтгэл хангалуун байдлыг авчирдаг хүүхдүүд, ач нартай хосууд ерөөлтэй. Бид дуулгаваргүй хүүхдүүдийнхээ төлөө шаналж, тэмцэж байгаа зохистой, шударга эцэг эхчүүдийн талаар санаа тавьдаг байх хэрэгтэй. Миний нэг найз, “Хэрэв та хүүхдүүдтэйгээ хэзээ ч, ямар ч асуудалгүй байдаг байсан бол ердөө жаахан азна” гэж хэлсэн.

Хэн ч хүүхдүүд нь тодорхой нэг нөхцөл байдалд юу хийх талаар өчүүхэн төдий ч тодорхой хэлж чадахгүй юм. Ухаалаг хадам эх маань бусад хүүхдүүдийн биеэ буруу авч явж байгааг хараад, тэр, “Намайг ярьж байхад манай хүүхдүүд үүнийг зөвөөр хийж болох учраас тэднийг ийм зүйл хийхгүй гэж би хэзээ ч хэлдэггүй!” хэмээн хэлдэг байж билээ. Эцэг эхчүүд дуулгаваргүй, төөрөлдсөн хүүхдүүдийнхээ төлөө гашуудаж

байхад бид өрөвдөх сэтгэлтэй байж “эхлээд чулуу шидэхийг” хориглох ёстой.¹⁹

Нэрээ бичиж үлдээгээгүй сүмийн нэгэн гишүүн, эцэг эхэд нь төвөг учруулж, байнга сэтгэлийг нь шаналгаж байдаг дүүгийнхээ тухай бичжээ. Тэр хар тамхинд орсон. Тэр биеэ хянах ба сахилга батын бүхий л хүчин чармайлтыг эсэргүүцдэг байв. Тэр хуурмаг бас авир муутай байжээ. Үрэлгэн хүүгээс ялгаатай нь энэ итгэл эвдсэн хүү гэртээ өөрөө эргэж ирээгүй. Харин цагдаагийнхан түүнийг баривчилж өөрийнх нь хийсэн үйлдлийн төлөөх үр дагавруудтай нь нүүр тулахаар албаджээ. Хоёр жилийн туршид эцэг эх нь Биллийг хар тамхины хамаарлаас аажимдаа эдгээх эмчилгээний хөтөлбөрийг дэмжсэн байна. Биллийн эгч нь эцэст нь бичихдээ: “Эцэг эх минь ер бусын хүмүүс юм. Тэд Биллийн өөртөө болон гэр бүлийнхэндээ хийж байсан зүйлийг нь хүлээн зөвшөөрдөггүй, тэр бүү хэл үзэн яддаг байсан хэдий ч Биллийг хайрлах хайрандаа хэзээ ч эргэлзэж байгаагүй. Тэд хэцүү цаг үеийг туулан илүү хатуу газарт очиход нь Биллд шаардлагатай бүхий л арга замаар дэмжихийн тулд үүргээ хангалттай биелүүлсэн. Тэд төөрөлдсөн нэгнээ хайрласнаараа Христийн илүү гүнзгий, илүү зөөлөн сэтгэлтэй ба өргөн хүрээтэй сайн мэдээг хэрэгжүүлжээ”²⁰ гэжээ.

Хүүхдүүд минь Их Эзэний арга замуудаар бидний зааж буй зүйлст дуулгавартай, хүндэтгэлтэй байдаг бол бардамнахаас илүүтэй даруухан талархалтай байх боломж өөрсдөдөө олго. Дуулгаваргүй хүүхдүүдээ заахдаа зөв шударга, хичээнгүй, залбиралтай байдаг, зүрх сэтгэл нь шаналсан тэдгээр эцэг эхчүүд та нарт Сайн Хоньчин тэднийг харж байгаа гэдгийг бид хэлж байна. Их Эзэн та нарын их гунигийг мэддэг, ойлгодог. Найдвар байна. Иеремиагийн “чиний үйлс шагнагдана”, хүүхдүүд тань “дайсны нутгаас буцаж ирнэ” хэмээх үгсээс тайтгарал ав.²¹ Есүс Христийн нэрээр ийн гэрчилж, залбирч байна. Амен. ■

ТЭМДЭГЛЭЛҮҮД

1. Иеремиа 31:15–16
2. Сургаал ба Гэрээ 68:25
3. Сургаал ба Гэрээ 68:28
4. Сургаал ба Гэрээ 68:28
5. Ховард В.Хантер, “Parents’ Concern for Children,” *Ensign*, 1983 оны 11-р сар, 65
6. 2 Самуел 18:33
7. Лук 15:32
8. Орсон Ф.Уитни, Чуулганы илтгэл, 1929 оны 4-р сар, 110
9. Аама 34:32
10. Сургаал ба Гэрээ 138:58–59.
11. Лук 15:11–32-г үзнэ үү
12. Алонза А.Хинкли, Чуулганы илтгэл, 1919 оны 10-р сар, 161
13. Сургаал ба Гэрээ 64:10
14. Жон К.Кармэк “When Our Children Go Astray,” *Лиахона*, 1999 оны 3-р сар, 28–37.
15. *The Teachings of Howard W. Hunter*, эмхтгэсэн Клайд Ж.Виллямс (1997), 32.
16. *Teachings of Gordon B. Hinckley* (1997), 704.
17. Мормон 9:31
18. Иосеф Смит—Түүх 1:39
19. Харольд Б.Лий, *Decisions for Successful Living* (1973), 58.
20. “With Love—from the Prodigal’s Sister,” *Ensign*, 1991 оны 6-р сар, 19.
21. Иеремиа 31:16.

Тайвшрал, сэтгэл хангалуун байдлыг авчирдаг хүүхдүүд, ач нартай хосууд ерөөлтэй. Бид дуулгаваргүй хүүхдүүдийнхээ төлөө шаналж, тэмцэж байгаа зохистой, шударга эцэг эхчүүдийн талаар санаа тавьдаг байх хэрэгтэй.



САНВААРААР
ДАМЖУУЛАН
ГЭР БҮЛ
БОЛОН СҮМИЙГ
ХҮЧИРХЭГЖҮҮЛЭХ НЬ

*Эцэг эхчүүд, гэр бүлүүд болон хувь хүмүүс сүнслэгээр өдөөгдсөн
эдгээр захиасыг судалж, ярилцсанаар адислагдах болно.*

Ричард М.Ромни

Сүмийн сэтгүүлүүд

Та эдгээр амлалтыг санаж байна уу? Та эдгээрийг зөвлөлийн хуралдаан, тав дахь ням гарагийн цуглаан, Нийгмийн Халамжийн Бүлэг эсвэл санваарын чуулгын хичээл дээр үзүүлсэн видео бичлэгээс үзэж, сонссон байж болно. Эсвэл та эдгээрийн талаар гэр бүлийн үдшээрээ ярилцсан ч байж болох юм.

Эдгээрт:

- Эхнэр нөхрүүд нэгдэн нийлэх болно;
- Эцэг эхчүүд илүү сүнслэг удирдамжаар гэр бүлээ удирдана;
- Өсвөр үеийнхэн нандин гэрээнүүдийг хийж, тэдгээрийг сахин мөн бүрэн цагийн номлолынхоо үеэр болон амьдралынхаа туршид Их Эзэнд үйлчлэхэд бэлтгэгдэнэ;
- Ганц бие гишүүд туслуулан дэмжүүлж, өөрсдийн гэр орондоо санваарын адислалыг хүлээн авч, мөн Бурханы хаант улсыг байгуулахад идэвхтэйгээр оролцоно;

- Тэнгэрлэг Эцэгийн хүүхдүүдэд үйлчлэхэд чуулга ба зөвлөлүүд хамтран ажиллана;
- Сүм хүчирхэгжинэ гэсэн амлалтууд тусгагдсан.

3-р сард Тэргүүн Зөвлөл ба Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгаас *Санваараар дамжуулан гэр бүл болон сүмийг хүчирхэгжүүлэх нь* хэмээх DVD-ийн хамтаар илгээсэн захиасанд эдгээр амлалтуудыг өгсөн. Тэр үеэр тойрог ба гадасны зөвлөлүүдэд уг захиасыг авч үзэн, хэрхэн ашиглах талаар хэлэлцэн зөвлөлдөхийг хүссэн. Мөн гэр бүлүүдийг интернет дэх <http://www.lt.lds.org> хаягаар орж, эдгээр видео бичлэгээс бэлэн болж гарах богино бичлэгүүдийг үзэхийг урьсан. Удирдагч болон багш нарыг хурал цуглаан, хичээл дээр гишүүдэд видео бичлэгийн хэсгүүдийг үзүүлэн, санал бодол, туршлага, мөн сүнслэгээр өдөөгдөх үедээ гэрчлэлээ хуваалцахыг урамшуулан дэмжсэн билээ. Эцэг эхчүүдийг ч мөн адил гэртээ үүнийг хийхийг урьсан.

“Энэхүү сургалтыг хэрхэн ашиглах вэ” хэсэгт “Өөрсдийн үүрэг болон хариуцлагадаа санваараар дамжуулан хэрхэн хүчирхэгжиж чадахыг Ариун Сүнс гишүүдэд заах болно” хэмээн хэлсэн байдаг.

Үр дүнтэй ярилцлагууд

Уг захиасууд нь гурван сарын өмнө өгөгдсөн хэдий ч эдүгээ мөн эдгээрийг судлах, харилцан ярилцах болон эдгээрээс ирэх адислалууд үргэлжилсээр байна. Энэ нь Сүмд явагддаг сургалтуудыг хийх шинэ арга замыг нээсэн. Тойрог, гадасны удирдагч нарт зориулан ихэвчлэн нэг удаа явагддаг байсан өмнөх сургалтуудаас ялгарах онцлог нь энэхүү сургалт цаашид

үргэлжлэн явагдах болно. Тиймээс видео бичлэгүүдийг wwlt.lds.org вэбсайт дээр тавьсан билээ. Мөн leadershiplibrary.lds.org вэбсайтаар дамжуулан эдгээр видео бичлэгийг үзэх боломжтойгоос гадна гэр бүл, хувь хүмүүс, чуулга, анги болон зөвлөүүдэд ойлголтоо гүнзгийрүүлж, сурсан зүйлээ амьдралдаа хэрэгжүүлэхэд нь туслах нэмэлт материалууд ч тавигдсан байгаа.

Видео бичлэгийн хэсэг бүр нь санваарын өөр өөр талуудад анхаарлаа хандуулсан. Тэргүүн Зөвлөл, Арванхоёр Төлөөлөгчийн Чуулга, Ерөнхий эрх мэдэлтнүүд болон ерөнхий албан тушаалтнууд дараах зүйлсийн талаар сүнслэгээр өдөөгдсөн заавруудыг өгсөн болно:

ВИДЕО БИЧЛЭГҮҮД БОЛОН МАТЕРИАЛУУДЫГ ХААНААС ХАЙХ ТУХАЙ

Видео бичлэгийн хэсгүүд болон бусад туслах материалуудыг <http://wwlt.lds.org-ooc> үзэх боломжтой. Цуглааны байранд эдгээрийг үзүүлэхдээ удирдагчид интернэтээр шууд үзүүлэх бус харин компьютер дээрээ татаж аван үзүүлэхийг дэмжиж байна.



- Санваарын хүчээр дамжуулан гэр бүлүүд хэрхэн хүч чадал, амар амгаланг олж болох тухай;
- Гэр бүл бүрт санваарын адислалуудыг хүртэхэд нь хэрхэн туслах тухай;
- Санваарын түлхүүр атгагч тэдгээр хүмүүс гэр бүлүүдийг хэрхэн хүчирхэгжүүлдэг тухай;
- Христтэй адил арга замаар хэрхэн үйлчлэх тухай;
- Хүүхдүүдээ гэрэл ба үнэнд хэрхэн өсгөх тухай.

Санваараар дамжуулан гэр бүл болон сүмийг хүчирхэгжүүлэх нь хэсэгт өгүүлсэн сайн мэдээний олон зарчмуудыг *Гарын авлага 2: Сүмийг удирдах нь* номонд мөн заасан байдаг. Иймд үүнээс судалж, харилцан ярилцах үедээ энэхүү гарын авлагын “Гэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг”-аас уншиж судлах нь зүйтэй.

Тэргүүн Зөвлөлийн нэгдүгээр зөвлөх Ерөнхийлөгч Хенри Б.Айринг: *Санваараар дамжуулан гэр бүл болон сүмийг хүчирхэгжүүлэх нь* хэсэг дэх захиасууд нь “Тэнгэрлэг Эцэг маань бидэнд ялангуяа гэр бүлүүдэд хэрхэн үйлчлэх байсны адилаар Ариун Сүнсний хүчээр дамжуулан сурахад бидэнд туслах зорилготой” хэмээн тайлбарласан. Эдгээрт заасан зарчмуудын талаар

тунгаан бодож, ярилцах явцад бидэнд Ариун Сүнсний заадаг зүйлс нь видео бичлэгийн хэсгүүдэд хэлж ярьсан зүйлсээс илүү чухал гэдгийг ойлгох нь энэхүү сургалтын хамгийн их нөлөө бүхий хэсэг юм.

Хаана хуваалцах вэ

Бүх удирдагч, гишүүд, гэр бүлүүдэд *Санваараар дамжуулан гэр бүл болон сүмийг хүчирхэгжүүлэх нь* видео бичлэгийг DVD эсвэл интернетээр сонсож мөн энэ талаар харилцан ярилцах боломж олгох хэрэгтэй.

Гэр бүлүүд эдгээр захиасыг гэр бүлийн үдэш болон бусад үйл ажиллагаандаа ашигласнаар адислагддаг. Үр хүүхдүүдээ удирдан чиглүүлэхэд эхнэр, нөхрүүд эрх тэгш хамтрагчид мөн. “Энэ бол Түүний ажил” хэмээх видео бичлэгийн хэсэгт Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч М.Рассел Баллард хэлэхдээ: “Эцэг эсвэл эхэд зарчим заах шаардлагатай тохиолдол гарч болох ба тэд хүү эсвэл охиндоо туслахыг хичээж байх үедээ энэхүү материалыг ашиглаж болно” гэжээ. Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Даллин Х.Өүкс “Санваар эсвэл Залуу Эмэгтэйчүүдийн зөвлөхүүдийн заадаг зүйлс Сүмд хэчнээн чухал мөн үр дүнтэй гэдэгт бид итгэдэг ч эцгийн эсвэл

СУРГАЛТААС ӨГӨГДСӨН БОШИГЛОЛЫН ЗАРЧМУУД

Санваараар дамжуулан гэр бүл болон сүмийг хүчирхэгжүүлэх нь захиаст агуулагдсан видео бичлэгийн хэсгүүд нь мартагдашгүй сургаалаар дүүрэн юм. Энд Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүдийн заасан зүйлсээс эш татлаа.

Санваарын түлхүүрүүдийн тухай ярилцлагыг удирдаж байхдаа **Ахлагч Л.Том Перри** “Бид Аврагчийн сүмд харьяалагддаг. Дэлхий дээрх Өөрийн бошиглогчийг Тэрээр өөрөө хөтлөн, удирдаж, чиглүүлдэг билээ. Тэрээр Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн удирдагч гэдэгт би огтхон ч эргэлздэггүй” хэмээн гэрчилсэн.

Ахлагч Рассел М.Нелсон заахдаа: “Гэр орондоо санваарын зөв шударга нөлөөг мэдэрч мөн өөрсдийн амьдралд үүнээс ирэх адислалуудыг мэдрэхээс илүү чухал зүйл гэж ирээдүйн номлогч нарт үгүй билээ” хэмээн хэлжээ.

Ахлагч Даллин Х.Өүкс “санваарын хүч чадал нь хувийн зөв шударга байдлаас хамаардаг” бөгөөд санваарын хүч чадлын адислалууд нь “эрэгтэй, эмэгтэй хүмүүст ижил боломжтой өгөгддөг” гэж зөвлөсөн. Тэрээр гэр бүлүүд бол “сестелиел хаант улс дахь өргөмжлөлийн бэлэг тэмдэг бөгөөд анхдагчид мөн” гэж хэлсэн.

Ахлагч М.Рассел Баллард “санваарын эрх мэдэл нь гэр бүлүүдийг Их Эзэний өргөөнд лацдах ёслолоор дамжуулан мөнхөд холбож чаддаг” болохыг гэрчилсэн. Тэрээр мөн “тойрог ба гадасыг удирддаг ах нар энэхүү хүчтэй ойр байснаар сүмийн эмэгтэйчүүдийг Бурханы хаант улсыг байгуулахад оролцуулж чадна” хэмээн зөвлөсөн байна.



Санваараар дамжуулан гэр бүл болон сүмийг хүчирхэгжүүлэх нь хэсэгт заагдсан захиасуудыг гадас, тойргийн зөвлөл гэх мэт янз бүрийн нөхцөлд хуваалцаж болно.

эхийн үлгэр жишээнээс илүү үр дүнтэй зүйл үгүй юм” хэмээн тэмдэглэсэн.

Сүмд эдгээр захиасыг гадасны ерөнхийлөгчийн зөвлөл ба бишопын зөвлөлийн хурал, гадас ба тойргийн зөвлөлийн хурал, санваарын гүйцэтгэх хорооны хурал, гадасны туслах бүлгүүдийн хурал, ерөнхийлөгчийн зөвлөлийн хурал түүнчлэн Аароны санваарын чуулгын ерөнхийлөгчийн зөвлөл ба Залуу Эмэгтэйчүүдийн ангийн ерөнхийлөгчийн зөвлөлийн хурал, санваартнууд ба Нийгмийн Халамжийн Бүлгийн хамтарсан тав дахь ням гарагийн цуглаан, Ням гарагийн чуулгын цуглаан ба туслах бүлгүүдийн ангиуд, гадас эсвэл дүүргийн чуулган (Ням гарагийн ерөнхий цуглаан дээр биш), тойрог эсвэл салбарын чуулган (ариун ёслолын цуглаан дээр биш) зэрэг дээр ашиглаж болно.

Ярилцаагууд нь өсвөр үеийнхэн ба ганц бие залуучуудыг хэрхэн хүчирхэгжүүлэх тухай байж болно. Удирдагчид эдгээр ярилцлага дээр тулгуурласан үүрэг даалгаврыг өгч, зөвлөлийн хурал дээр энэ тухай тогтмол авч хэлэлцэж болно.

Эдгээр захиасыг судалж, харилцан ярицахын гол зорилго бол хувь хүмүүс ба гэр бүлүүдийн итгэлийг хүчирхэгжүүлэн, тэднийг гэрчлэлтэй болгож мөн Есүс Христийн сайн мэдээнд илүү гүн гүнзгийгээр хөрвөгдөхөд нь туслах юм.

“Бидний аюулгүй байдал болон амжилт нь бид зөвхөн өөрсдийн хүсэл зорилго, зүрх сэтгэлээ Бурханы хүсэл мөн Түүний хүчтэй нэгдүүлэхийг биднээс шаарддаг” хэмээн Ерөнхийлөгч Айринг хэлсэн. Эдгээр захиас нь “тийнхүү бид хүслээ Бурхантай нэгдүүлж бусдыг дагуулах удирдамж мөн түлээц болдог юм.”

“Үйлчлэл” видео бичлэгийн хэсэгт санваарын

удирдагчид нь хувь хүмүүс ба гэр бүлүүдээр айлчлан очиж буй талаар мөн идэвх султай гишүүдийг анхаарч, ярилцах нь ямар их тустай болох тухай үр дүнтэй жишээнүүдийг харуулсан.

“Энэ бол Түүний ажил” видео бичлэгийн хэсэгт Тэргүүлэх бишоп Гэри Э.Стивинсон хэлэхдээ: “Сул доройчуудад туслан, доош унжсан гарнуудыг өргөн мөн сул дорой өвдөгнүүдийг хүчирхэг болгох үүргийнхээ тухай бодоод үзэхээр хэн нэгний гэрт нь очин, ганцаарчлан уулзаж, Есүс Христийн ашигладаг байсан энэхүү арга замаар үйлчлэхээс илүү сайн арга байхгүй юм” гэжээ. “Бид харилцан ярилцаж, сурч дараа нь сурсан зүйлээ хэрэгжүүлэхэд жинхэнэ үр дүн гарна” гэж тэрээр хэлсэн.

Хүч чадал ба амар амгалан

Энэхүү сургаал нь сүм даяар үргэлжлэн явагдсанаар гишүүд үүнээс заалгасан сайн мэдээний зарчмуудыг хэрэгжүүлэн, адислалуудыг нь хүлээн авах болно. “Бурханы бүх охид, хөвгүүд эдгээр танилцуулгын жишээ болон заасан зүйлсийг дагах аваас адислагдах болно” хэмээн Ахлагч Баллард хэлсэн.

Эхнэр нөхөр, эцэг эх, өсвөр үеийнхэн, ганц бие гишүүд, чуулга ба зөвлөлүүд санваараар дамжуулан Есүс Христийн жишээг дагаснаар бусдад үйлчлэн, сүнслэг өдөөлтийг хүлээн авна. Тэд ийн үргэлжлүүлэн үйлдсэнээр *Санваараар дамжуулан гэр бүл болон сүмийг хүчирхэгжүүлэх нь* хэсэгт өгөгдсөн амлалтууд биелэгдэх болно. Гишүүд уг захиасын сүүлийн видео бичлэгээс хүнд хэцүү үед ч “бидний гэр бүл хүчтэй мөн амар амгалан байж чадна” хэмээх Ерөнхийлөгч Айрингийн амлалт биелэхийг харах болно. ■



9
ecoh




ГЭРЭЛ ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ КРЕЙГ ДАЙМОНД КОДИ БЕЛГНАР © ИГ

АМЖИЛТТАЙ ГЭРЛЭЭЛТ
БА БАТ БӨХ ГЭР БҮЛИЙН

ЗАРЧИМ

Женнифер Грейс Жөүнс

Сүмийн сэтгүүлүүд



АНУ-ын Вашингтоны Ами Адамсын ээжтэйгээ ярилцсан нэг яриа бодол санааг нь өөрчилсөн ба тэрээр бага насны гурван хүүхдэдээ хамгийн сайн тохирох үйл ажиллагаануудыг сонгохыг хичээжээ. “Хэрэв чи хүүхдүүдэдээ спортоор буюу бүжгээр хичээллэхээс илүү дээр ямар нэг зүйлийг санал болговол энэ нь юу байх вэ?” “Хэрэв тэд гэртээ байж, Сүнсийг улам сайн мэдэрч сурвал яах вэ?” гэж Амигийн ээж асуужээ. Тэгээд ээж нь амьдралын үндсэн харилцаан дээр хүч чармайлтаа төвлөрүүлэх тухай Тэргүүн Зөвлөлийн Хоёрдугаар зөвлөх Ерөнхийлөгч Угдорфын заасан зүйлийг түүнд сануулсан ажээ (жишээ нь, “Хамгийн чухал зүйлс,” *Лиакхона*, 2010 оны 11-р сар, 19–22).

Ами нөхөр Бреттэйгээ энэ зөвлөгөөний талаар залбирч, тунгаан бодож үзээд тэд гэр бүлээрээ гэртээ илүү олон цаг хамт байх нь зөв гэдгийг мэджээ. Тэд нэг жилийн хугацаагаар бүжиг, спортоос татгалзаж, оронд нь хоол хийх, Хүүхдийн Хэсгийн дуунууд сурах, музей үзэх, гэрийнхээ гадаа тоглож байхаар шийдсэн ажээ. “Бид үе үе завсарлаж, хүүхдийн дуу, судар сургаалууд сонсдог байсан учраас манай хүүхдүүд Сүнсийг мэдэрдэг болсон” гэж Ами хэллээ. Тэдний хүүхдүүд спорт, бүжгийн одод болохгүй байж болно, харин “Аврагчийн тухай гэрчлэлтэй болсон” гэж тэр яриу.

Ами, Бретт хоёр өнөө үеийн бошиглогчдын зөвлөгөөг өөрсдөө хэрхэн дагавал зохихыг мэдэхийн тулд залбирсан нь гэр бүлийнхээ төлөө сүнсний удирдамж хүлээн авах боломжийг тэдэнд олгожээ. Энэхүү сүнсний удирдамж нь түүнд “эх хүний хувьд хамгийн бахархалтай агшин” байсан хэмээн Ами хэллээ.

“Гэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг”-т өнөө үеийн бошиглогчид сайн мэдээн дээр төвлөрсөн бат бөх гэр бүлийн есөн зарчмыг ийн тодорхойлсон юм: “Аз жаргалтай гэрлэлт болон гэр бүлүүд нь итгэл, наманчлал, уучлал, хүндэтгэл, хайр энэрэл, өрөвч сэтгэл, ажил хөдөлмөр ба идэвхтэй амралтын зарчмууд дээр оршин тогтнодог билээ” (*Лиакхона*, 2010 оны 11-р сар, 129). Сүмийн удирдагчдын дараах сургаалууд, Есүс Христийн амьдралаас авсан жишээнүүд болон бусад эх сурвалжууд нь дээрх есөн зарчмыг болон тэдгээрийг амьдралд хэрэгжүүлэх арга замуудыг нарийвчлан авч үзэх боломжийг бидэнд олгож байна.

ИТГЭЛ



“Итгэл гэдэг бол Есүс Христэд итгэн найдах явдал бөгөөд энэ нь хүнийг Түүнийг дуулгавартай дагахад хөтөлдөг.”

Судруудын Удирдамж,
“Итгэл,” scriptures.lds.org.

Сүмийн удирдагчдын сургаалаас

Амьд Бурханы Хүү Есүс Христэд итгэх итгэлийн. . . сургаалыг ойлгуулахын’ (С ба Г 68:25) тулд хүүхдүүдээ заахыг эцэг эхчүүд бидэнд зарлиг болгосон билээ. . .

“Бидэнд итгэлээс өөр ямар ч баталгаатай үнэн байдаггүй. Амьдралд амар амгалан, баяр баясал, итгэл найдварыг авчирдаг зүйл итгэлээс өөр байхгүй. Тодорхойгүй бөгөөд хүнд бэрх цагт итгэл үнэхээр бидний хүч чармайлтуудын үр жимс болж ирдэг сүнсний бэлэг мөн. Бид үр хүүхдэдээ боловсрол олгож, хичээл заан, урлаг, спортын мэдлэг чадвар эзэмшүүлж, материаллаг зүйлсээр хангаж чадах ч бид тэдэнд Христэд итгэх итгэлийг өгч чадахгүй, өгсөн ч багаахныг л өгч чадна.”

Далын Ахлагч В.Пийрсон, “Их Эзэн Есүс Христэд итгэх итгэл,” *Лиахона*, 2009 оны 5-р сар, 38.



НАМАНЧЛАЛ




“Наманчлал нь хүн нүгэл хилэнцээс эргэж, зүрх сэтгэл, хүсэл тэмүүлээ Бурхан руу эргүүлэх зорилготой юм.”

Судруудын Удирдамж,
“Наманчлал, наманчлах,” scriptures.lds.org.

Сүмийн удирдагчдын сургаалаас

Маргааш гэж хойшлуулах биш харин өнөөдөр наманчлах нь хамгийн чухал. . . . Бид арай хожуухан уучлагдаж болох ч гэсэн Их Эзэн хайртай болон үйлчилдэг хүмүүст маань зөвхөн өнөөдөр нөлөөлөх бидний наманчлалын сайн үр нөлөөг хожим нь сэргээдэггүй. Энэ нь бага насны хүүхэдтэй эцэг эхчүүдэд бүр ч чухал юм. Балчирхан насанд нь зан төлөвийн сайн чанаруудыг тэдэнд төлөвшүүлж, өргөн дэмжих боломж бидэнд дахиад хэзээ ч олдохгүй. Тэр ч бүү хэл, өөрийнхөө хүүхдүүд дээр ийм боломжийг ашиглаж чадаагүй эмээ өвөө нар хүртэл өнөөдөр наманчлалыг сонгох замаар энэхүү боломжийг ач зээ нарынхаа төлөө ашиглаж болно.

Ерөнхийлөгч Хенри Б.Айринг, Тэргүүн Зөвлөлийн Нэгдүгээр зөвлөх, “Бүү хойшлуул,” *Лиахона* 2000 оны 1-р сар, 40.





Зүүн талаас: Гэрэл зураг "Мимэглэлийг крест" даймонд, Коди Белл, Кристина Смит нар © IRI, Их эзэн Есүс Христ Дел Парсон © IRI


Есүс Христийн амьдралаас

Аврагч нифайчуудад хийсэн үйлчлэлийнхээ анхны өдрийн төгсгөлөөр хүмүүсийн нүүр рүү хараад, “тэд нулимс унагаж буйг, мөн тэд өөрийг нь тэдэнтэй хамт дахин хэсэгхэн зуур ч гэсэн үлдэхийг гуйх мэт түүний зүг тэд ширтэн харж байхыг” болгоожээ. Тэрбээр өрөвч энэрэнгүй сэтгэлээр бялхан, “Та нарын дунд өвчтөнүүд байна уу? . . . Тэднийг нааш нь авчрагтун, би тэднийг эдгээх болно” хэмээн хэлсэн билээ.

Цугласан олон өвчтэй хүмүүсээ түүнд авчрахад Есүс тэднийг нэг бүрчлэн эдгээв. Тэгээд тэд бүгд нийлээд 2500 эрэгтэй, эмэгтэйчүүд, хүүхдүүд Есүсийн хөлд унаж, түүнийг шүтэн биширчээ.

Дараа нь Аврагч бяцхан хүүхдүүдийг Өөр рүүгээ авчрахыг мөн цугласан олныг өвдөг дээрээ сөхрөхийг зарлиглажээ. Тэр хүүхдүүдийн дунд өвдөг сөгдөн залбирч эхэлжээ. Хүмүүс Түүний залбирлыг үлэмж баяртайгаар сонссоны эцэст дараах гэрчлэлийг хуваалцжээ: “Эцэгт хандан Есүсийн ярьсныг бид харж мөн сонссон шиг тийм агуу хийгээд гайхамшигт зүйлүүд урьд нь нүдэнд хэзээ ч үзэгдээгүй, бас чихэнд хэзээ ч сонсогдоогүй бөлгөө” (3 Нифай 17: 1–17-г үзнэ үү.)


ЗАЛБИРАЛ



“Залбирал бол Эцэгийн хүсэл, хүүхдийн хүсэл хоёр хоорондоо нэгдэн нийлдэг үйлдэл буюу үйл явц мөн. Залбирлын зорилго нь Бурханы хүслийг өөрчлөхөд биш харин Бурхан та нарт өгөхийг хүсдэг адислалуудыг олж авахад өөртөө болоод өрөөл бусдад туслах явдал бөгөөд Түүнээс чухам юу хүсч байгаагаас хамааралтай байдаг.”

Bible Dictionary, “Залбирал.”

УУЧЛАЛ



“Уучлах нь ерөнхийдөө хоёр талт үйл явц юм: (1) Бурхан хүмүүсийг уучлахдаа нүглийн төлөөх шийтгэлийг цуцлах буюу хойшлуулдаг. . . . (2) Хүмүүс бие биеэ уучилснаар нэг нэгэндээ Христийнхтэй адил хайраар ханддаг.”

Судруудын Удирдамж,
“Өршөөх, уучлах,” scriptures.
.lds.org.

Тэгээд Есүс Симоноос, “[Өртөнгүүдээс] хэн нь [зээлдүүлэгчийг] илүү хайрлах бол?” гэж асуухад илүү өгөөмрөөр өрнөөс хэлтрүүлэгдсэн нь болов уу гэж Симон хариулжээ. Тэгэхэд нь Есүс нөгөөх эмэгтэй рүү эргэж, “Чи энэ эмэгтэйг харж байна уу? . . . Түүний олон нүгэл уучлагдсан. Учир нь тэр ихэд хайрласан. Харин багахан шигээр уучлагдсан нэг нь бага хайрладаг” гээд эмэгтэйд, “Нүгэл чинь уучлагдсан. . . . Итгэл чинь чамайг аварлаа. Амар тайван яв даа” гэжээ (Лук 7:36–50-ийг үзнэ үү).

Сүмийн удирдагчдын сургаалаас

“Уучлагдсан хүмүүс бусдыг уучилдаг гэсэн нийтлэг дүрмийг баримталдаг хүмүүсээр тэнгэр дүүрэн байдгийг санагтун.”

Тэргүүн Зөвлөлийн Хоёрдугаар зөвлөх Ерөнхийлөгч Диетер Ф.Угдорф,
“Өршөөнгүй хүмүүс өршөөл энэрлийг хүлээн авна,” *Лиахона*, 2012 оны 5-р сар, 77.

Есүс Христийн амьдралаас
Симон гэгч фарисай хүн Аврагчийг гэртээ зоогт урьжээ. Тэднийг хоол идэж байх үед тэр хотдоо нүгэлтэн гэгддэг байсан нэг эмэгтэй Есүс рүү хүрч ирэн, дэргэд нь зогсоод уйлж эхэлснээ Аврагчийн хөлд сөгдөн нудимсаараа хөлийг нь норгож, үсээрээ арчин, хөлийг нь тосолжээ. Симон тэр эмэгтэйг хараад, “Хэрэв энэ хүн эш үзүүлэгч мөн байсан юм бол Түүнд гар хүрч буй энэ эмэгтэй хэн болохыг, түүний нүгэлт хүн болохыг нь мэдэх учиртайсан хэмээн дотроо боджээ.”

Тэгэхэд нь Аврагч Симон руу эргэж, түүнд дараах сургаалт зүйрлэлийг ярьсан гэдэг:

“Нэгэн мөнгө зээлдүүлэгчид хоёр хүн өртэй байжээ. Нэг нь таван зуу, нөгөө нь тавин денарын өртэй байв.

Тэд төлөх чадваргүй тул өнөөх хүн тэднийг хоёуланг нь өрнөөс хэлтрүүлжээ.”

Тэгээд Есүс Симоноос, “[Өртөнгүүдээс] хэн нь [зээлдүүлэгчийг] илүү хайрлах бол?” гэж асуухад илүү өгөөмрөөр өрнөөс хэлтрүүлэгдсэн нь болов уу гэж Симон хариулжээ. Тэгэхэд нь Есүс нөгөөх эмэгтэй рүү эргэж, “Чи энэ эмэгтэйг харж байна уу? . . . Түүний олон нүгэл уучлагдсан. Учир нь тэр ихэд хайрласан. Харин багахан шигээр уучлагдсан нэг нь бага хайрладаг” гээд эмэгтэйд, “Нүгэл чинь уучлагдсан. . . . Итгэл чинь чамайг аварлаа. Амар тайван яв даа” гэжээ (Лук 7:36–50-ийг үзнэ үү).

Зүүн талаас: Гэрэл зураг-чимэглэлийг стив Бундерсон, Дэвид Минтерс, Маттью Реймер, Есүс төлөөлөгчдийн хөлийг уугааж байгаа нь, Наривчилсан зураг, Дел Парсон © IRI





Есүс Христийн амьдралаас

Түүний Цовддолтын өмнөх орой буюу Гетсемани дахь зовлон шаналлаас хэдхэн цагийн өмнө Есүс Христ Төлөөлөгчидтэйгөө хамт Дээгүүр Өнгөрөх сүүлчийн Баярыг тэмдэглэсэн юм. Зоог дуусах үед Есүс “энэ ертөнцөөс салж, Эцэг уруугаа очих цаг нь болсныг мэдээд, Өөрийн хүмүүсийг хайрлан, тэднийг эцэст нь хүртэл хайрлав.” Тэгээд Аврагч зоогийн ширээнээс босч, гадуур хувцасаа тайлаад, алчуур авч бүслэв. Тэгээд саванд ус хийж, шавь нарынхаа хөлийг угаав. Тэр ажлаа дуусгаад дараах шинэ зарлигийг тэдэнд өгсөн билээ:

“Би та нарыг яаж хайрласны адил та нар мөн бие биенээ хайрлагтун. . . .

Үүгээр чинь бүх хүн та нарыг Миний шавь нар мөн гэдгийг мэдэх болно” (Иохан 13:1–5, 34–35-г үз).

ХАЙР



“Бусдыг энэрэн хайрлах гүнзгий мэдрэмж. . . . Бурханы хайрын хамгийн агуу жишээ нь Есүс Христийн хязгааргүй Цагаатгалаар илэрсэн юм.”

Судруудын Удирдамж,
“Хайр,” scriptures.lds.org.

“Дээдлэн хүндлэх, өндөр хүндэтгэл үзүүлэх.”

Merriam-Webster’s Collegiate Dictionary, 11th ed. (2003), “respect.”


Сүмийн удирдагчдын сургаалаас

Бид дэлхийн зүйлсийг судалж мэдэж, үүнд суралцахдаа энэ нь үнэхээр түр зуурын бөгөөд заримдаа ертөнц хэтэрхий өнгөцхөн, нүд хуурсан болохыг ухаардаг бөгөөд энэ үед гэр бүл болон бидний хайртай хүмүүсийн үнэнч байдал зэрэг итгэж найдаж болох зүйлс бидэнд байгаад баярлан талархах нь өсөн нэмэгддэг билээ. Үүрэг хариуцлага, хүндэтгэл, нийтэч зан чанар зэргээр хоорондоо холбогдоно гэдэг юу гэсэн утгатай болохыг бид мэддэг. Адислагдсан гэр бүлийн амьдралын хэлхээ холбоог юугаар ч орлуулж болохгүйг бид мэддэг.” . . .

“Ах нар аа, эхнэртээ хайр, хүндэтгэлийн дээдээр хандацгаая. Хань ижил тань та бидний мөнхийн хамтрагчид билээ. Эгч нар аа, нөхрөө хүндэлж бай. Тэд та нараас сайн сайхан үгсийг сонсох хэрэгтэй. Тэдэнд халуун дулаан инээмсэглэл хэрэгтэй. Тэдэнд үнэнч хайраа чин сэтгэлээсээ илэрхийлж бай.

Ерөнхийлөгч Томас С.Монсон, “Гэр бүл дэх хайр—бидний Бошиглогчийн зөвлөгөө,” *Лиакона*, 2011 оны 8-р сарын 4.

ХҮНДЭТГЭЛ



ӨРӨВЧ СЭТГЭЛ



“Өрөвч сэтгэл гэдэг нь ‘хэн нэгэнтэй хамт зовох’ буюу өөр хүнийг өрөвдөн хайрлаж, энэрэнгүй сэтгэлээр түүнд хандах гэсэн утгатай юм.”

Судруудын Удирдамж,
“Өрөвч сэтгэл,” scriptures.
lds.org.

хүргэж, “Би чамд хэлж байна. Залуу минь, бос” гэжээ. Тэр даруй нөгөөх залуу босч ирэн ярьж эхлэхэд Аврагч түүнийг зовлон үзсэн эхэд үхлээс чөлөөлж өгчээ.

Есүс Христийн амьдралаас

Аврагч бусдад өрөвч сэтгэлээр хандсан өдий төдий түүх судруудад байдаг. Тэрбээр өрөвч сэтгэлээрээ хараагүй хоёр хүнд хараа оруулж (Матай 20:30–34-ийг үз), уяман өвчтэй хүнийг цэвэршүүлж (Марк 1:40–41-ийг үзнэ үү), цугласан үй олон нифайчуудын дундах өвчтэй бүх хүмүүсийг эмчилсэн билээ (3 Нифай 17:6–9-ийг үзнэ үү).

Есүс Найн хотын хаалганд ойртон ирэх үед “бэлэвсэн эмэгтэйн ганц хүү байсан” нэг залуугийн оршуулгын цувааг харсан түүх онцгой сэтгэл догдлуулам юм. Аврагч хотын хэчнээн хүмүүс тэр эмэгтэйтэй хамт явааг болон сайхь эмэгтэй хэрхэн уй гашуу болж явааг хараад түүнийг “ихэд өрөвджээ” (Лук 7:11–15-ыг үзнэ үү). Тэрбээр залуу хүний цогцостой авсанд гараа



АМРАЛТ, ЧӨЛӨӨТ ЦАГ



Эрүүл саруул, санаа сэтгэл өргөсөн үйл ажиллагаанууд оролцсон бүх хүмүүсийн сүсний хүч чадлыг нэмэгдүүлдэг.

Сүмийн удирдагчдын сургаалаас

Шударга ажил хөдөлмөрийн үр шим амттай сайхан байдаг лугаа адил идэвхтэй эрүүл амралт бол бидний найз нөхөр, ажил хөдөлмөрийн найдвартай хамтрагч мөн. Дуу хөгжим, уран зохиол, урлаг, жүжиг, спорт—энэ бүхэн хүний амьдралыг баялаг агуулгатай болгож, цаашид улам хөгжүүлдэг. Үүний сацуу өнөө үеийн үзвэрүүдийн ихэнх нь бүдүүлэг, олхиогүй, хүчирхийлэл, оюуны хоосролыг сурталчилсан, цаг үрсэн шинжтэй байгааг хэлэх хэрэгтэй. Зарим үед чөлөөт цагаа өнгөрүүлэх газар олох нь маш хэцүү байдаг. Үзвэр цэнгүүн сэтгэл татам сайхан зүйлээс олхиогүй юм болж хувирсан үед ариун журамт амьдралыг бусниулагч болдог.”

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Д.Тодд Кристофферсон, “Өргөл болгосон амьдралын тухай бодол эргэцүүлэл,” *Лиэхона*, 2010 оны 11-р сар, 17.





ЗҮҮН ТАЛААС, ГЭРЭЛ ЗУРАГ ЧИМЭГЭЛИЙГ КРЕЙГ ДАЙМОНД, КОДИ ВЕЛЛ, ДЭВИД СТОКЕР НАР, БИ ИТГЭЖ БОЛНО, ЛИЗ ЛЕМОН СВИНДЛ, ХУУЛБАРЛАХ БОЛОХГҮЙ


Сүмийн удирдагчдын сургаалаас

Шударга хөдөлмөрөөс ирдэг баяр баяслыг хүүхдүүддээ заах нь тэдэнд таны өгч чадах хамгийн агуу бэлгүүдийн нэг юм. Өнөөдөр гэр бүлийн өдий төдий хосууд салж сарниж байгаа шалтгаануудын нэг нь эцэг эхчүүд бид хөвгүүддээ гэр орон, гэр бүлээ авч явах үүрэг хариуцлагыг нь болон энэхүү үүрэг хариуцлагаас үүдэлтэй сорилт бэрхшээлүүдийг зааж сургахгүй байгаа явдал гэдэгт би итгэдэг. Бас биднээс олон нь гэр орноо өнгөтэй өөдтэй, эмх цэгцтэй авч авах хүслийг охиддоо төлөвшүүлж чадахгүй байна . . .

“[Аав минь] надад шударга хөдөлмөрийг эрхэмлэн дээдлэхээс ирдэг баяр баясгаланг гүнээ ухамсарлуулж, ирээдүйд амьдралдаа өрх гэрээ тэргүүлэн авч явах үүрэг хариуцлага тулгарах тэр үед намайг бэлтгэсэн юм. Ухаант эцгийн минь надад заасан шударга хөдөлмөрийн тухай, үрлэгэн биш байх тухай, сахилгын тухай, ажлыг заавал дуустал нь хийж байх тухай зарчмууд миний амжилтын үндэс болсон юм.” ■

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Л.Том Перри, “Шударга хөдөлмөрөөс ирдэг баяр баясгалан,” *Ensign*, 1986 оны 11-р сар, 62, 64.

АЖИЛ ХӨДӨЛМӨР



“Хүн өөрийгөө бие махбод хийгээд оюун санааны хувьд тэтгэх зорилго бүхий хүч чармайлт.”

Merriam-Webster's Collegiate Dictionary, 11th ed. (2003), “work.”

БИД ЯГ ОДОО Л ЗАЛБИРАХ ХЭРЭГТЭЙ

Манай гэр бүл Эдмонтон дахь гэрээсээ таван цаг орчим явж хүрэх зайтай Канадын Альбертагийн Пийз Ривера руу долоо хоногоор явсан аялаасаа буцах замдаа гарсан юм. Умард нутгийг харанхуй аль хэдийн нөмрөөд салхи цас хуйлуулан, бидний өмнөх замыг дарж байсан ч бүхээгтэй машин дотор амар тайван, нам гүмхэн байх шиг санагдаж байлаа.

Гэтэл хяналтын самбар дээр гэнэт гэрэл асч түгшүүрийн дохио өгч эхэллээ. Нэлээд хэдэн жилийн өмнө зөвхөн ганцхан удаа ийм түгшүүрийн гэрэл ассаныг би харсан билээ. Харин энэ удаа машины мотор дотор нэг юм болохоо байж дээ гэж айлаа. Тэгээд би тэр даруй шаардлагагүй бүх цахилгаан холбоосыг салгатад, удалгүй мотор унтарчихав. Бид сүүлчийн хотын хажуугаар өнгөрснөөс хойш нэлээд хэдэн цаг явсан байлаа. Дараачийн хот хүртэл дахиад олон цаг явах хэрэгтэй байлаа. Би хамгийн сүүлд хэзээ замаар машин зөрснийг ч санахгүй байлаа.

Одоо яах билээ хэмээн намайг

толгойгоо гашилгаж байх зуур манай 11 настай хүү Кассон, “Бид яг одоо л залбирах хэрэгтэй!” гэлээ. Кассон гурван сар хүрэхгүй хугацааны өмнө хавдраар нас барсан дүүгээ алдаад уй гашуу болж байлаа. Кассон цорын ганц дүүгээ юуны учир алдах болсноо ойлгож цөхөн, тэнгэр өөд хэчнээн олон залбирал илгээсэн гэж бодно?

Залбирал зөвхөн бидний хүсэл байдаггүй, харин энэ нь Тэнгэрлэг Эцэгийн хүсэлтэй нэгдсэн байх ёстойг хүү минь хэрхэн бүрэн дүүрэн ойлгодог байсныг эхнэр бид хоёр мэдээгүй байж билээ. Тийнхүү бид Тэнгэрлэг Эцэгт хандан залбирах хэрэгтэйг мөн Түүнд хэрхэн үргэлж итгэлтэй хэвээр байх ёстойг хүү минь бидэнд харуулсан юм.

Биднийг залбирч дуусаад удаагүй байтал ар талын толинд ойртон ирж яваа машины гэрэл туслаа. Хэдхэн хормын дараа Эдмонтон руу явж байгаа намхан тэвштэй ачааны машин бидний урд зогслоо.

Ачааны машины жолооч бид хоёр өөд өөдөөсөө угтан ирж

уулзахад тэр Канадын франц аялгаар, “Танай машин дотор хүүхдүүд байгаа юу?” гэж асуулаа. Тийм ээ байгаа гэж намайг хариулахад тэр жолооч, хэдэн километрийн цаана цасанд суусан нэг машины дэргэдүүр өнгөрсөн тухайгаа ярилаа. Харин бидэн рүү ойртон ирсэн үедээ машин дотор хүүхдүүд байгаа, тэдэнд тусламж хэрэгтэй гэсэн мэдрэмж түүнд тодхон төрсөн ажээ. Тиймээс тэр зогссон гэнэ.

Хэдэн минутын дараа бид бүхээгтэй тэргээ татуургаар түүний машин дээр гаргаж ачаад Эдмонтон руу хөдлөв. Бид даарсан ч, Тэнгэрлэг Эцэг бидний залбирлыг сонсож, хариулсанд сэтгэл бүлээцэн баярлаж билээ. Заримдаа залбирлын хариу бидний бодоогүй эсвэл хүсэн хүлээгээгүй замаар ирдэг бол зарим үед залбирлын хариу бидний төсөөлж чадахаас илүү хүчтэй, тод томруунаар ирдэг. Бид гагцхүү Их Эзэнд итгэх тууштай итгэлтэй байх хэрэгтэй. ■

Жеффери Р.МкМахон, Альберта, Канада



Биднийг залбирч дуусаад удаагүй байтал ар талын толинд ойртон ирж яваа машины гэрэл туслаа.

БИ ДАХИАД БҮЖГЭНД ХЭЗЭЭ Ч ЯВАХГҮЙ

АНУ-ын Иллинойн Чикагогийн дүүрэг, манай хотод 4400 орчим оюутан сурагчидтай оюутны хоёр хотхонд 20 хүрэхгүй Хожмын Үеийн Гэгээнтэн өсвөр үеийнхэн ахлах сургуульд явдаг. Манай хүү боловсрол эзэмшсэнд мөн манай бүсэд өндөр жишгүүдтэй олон сайхан гэр бүл амьдардагт бид их баяртай байдаг билээ.

Манай хүү ахлах сургуулиа төгсөхийн өмнөх хавар сургуулийнхаа нэг бүжигт уригдсан юм. Түүний хослон бүжиглэгч нь гоё атлаа даруухан хувцасласан байлаа. Тэдний бүжгийн үдэшлэг хэрхэн болж өнгөрсөн тухай сонсохыг бид тэсч ядан хүлээж байлаа. Тэр бүжгээс гэртээ эргэж ирээд, “Би сургуулийн бүжгэнд дахиад хэзээ ч явахгүй!” гэх нь тэр. Сурагчид бэлгийн харилцаанд өдөн дуудсан бүжиг хийхэд сургуулийн захиргаа бүжгийг зогсоосонгүй. Би үүнд цочирдон гайхсан гэж хүү маань яриу.

Би энэ сургуулийн дүүргийн хагас цагийн ажилтан учраас бүжгээс хойш хоёр өдрийн дараа сургуулийн орлогч захиралтай уулзлаа. Тэр бол зарчимч хүн байсан болохоор миний санааг зовоосон асуудлыг анхааралтай сонсоно гэж бодож байлаа. Тэр надад ахлах сургуулиудын захирлуудад энэ тухай захидал бичихийг зөвлөмж болголоо.

Би тэдэнд юу хэлэхээ залбирч үзээд, зохимжгүй бүжиг зохион байгуулсанд болон үүнийг тухайн үед нь зогсоогоогүйд сэтгэл дундуур байгаагаа тэдэнд хэлэхээр шийдэв. Их дээд сургуулиудад өндөр шаардлага тавидаг хэрнээ үйл ажиллагаануудад нь яагаад өндөр шалгуур тавьж болохгүй гэж?

Түүнээс хойш хэдэн сар өнгөрөхөд таг чимээгүй байсан болохоор ахлах сургуулийн захирлууд миний захидлыг үл ойшоож дээ гэж бодож

байлаа. Гэтэл сурагчдын дахин бүртгэлийн үеэр нөгөөх орлогч захирал надаас “Та сургуулийн бүжгийн талаар бичсэн тэр ээж мөн үү?” гэж асуухад би.

“Тийм ээ, мөн” гэж хариулав.

“Таны захидал биднийг нэлээд их бүжигнуулсан шүү!” гэж тэр хэллээ.

Захирлуудын нэг нь нэлээд хэдэн сурагчдын саналыг асуухаас нааш бүжгийн талаар өөрчлөлт хийхгүй гэж зүтгэсэн гэнэ. Гэтэл саналыг нь сонссон сурагч бүр: “Бид сургуулийн бүжгэнд дахиад хэзээ ч явахгүй. Үнэхээр ичмээр юм билээ!” гэж хариулсныг би мэдлээ.

Тиймээс сургуулийн захиргаа бүжгийн ёс зүйн дүрмийг батлан гаргасан бөгөөд уг дүрмийг дөхөж байгаа хонхны баярын бүжигт чанд мөрдөх болжээ. Бүжгийн дүрэм тэдэнд таалагдахгүй байна гэж үзсэн сурагчид бүжгийг орхин явж болно гэдгийг сургуулийн захирал мэдэгдсэн ажээ.

Би хүүгээ хонхны баярын бүжгээс буцаж ирэхийг нь сэтгэл хөдлөн хүлээж байлаа. Хуучнаараа бүжиглэхийг хүссэн сурагчид

бүжгээс гарч явсныг мөн тэр ийм сайхан бүжигт өмнө нь хэзээ ч орж байгаагүйгээ хэллээ.

Хонхны баярын энэ удаагийн бүжиг сургуулийн хамгийн сайн бүжгүүдийн нэг болсонд би сургуулийн захиргаанд талархал илэрхийлэн захидал бичлээ. Миний таньдаг орлогч захирал: “Өнгөрсөн хавар та бидний хооронд болсон яриа үр дүнгээ өгсний төлөө танд баярлалаа. Таны оролцоогүйгээр бид энэ талаар урагш ахьсан өөрчлөлт гаргаж чадахгүй байсан” хэмээн хариу захидалдаа өгүүлсэн байлаа.

Манай дүүргийн ихэнх сургуулиуд дээрх бүжгийн шинэ дүрмийг авч хэрэглэснээр мянга мянган сурагчдад сургуулийн бүжиг таалагдах болсныг би мэдсэн билээ.

Итгэдэг зүйлээ хэлэх болон үүнийхээ төлөө тууштай зогсдог байх зоригор Их Эзэн биднийг адислахын төлөө би залбирдаг. Нэг хүн өөрчлөлт гаргаж чадна гэдгийг би ийнхүү мэдсэн билээ. ■

Венди Ван Нои, Иллиной, АНУ



Сургуулийн захиргаа бүжгийн ёс зүйн шинэ дүрмийг хэрэгжүүлсний дараа би хүүгээ хонхны баярын бүжгээс буцаж ирэхийг нь сэтгэл хөдлөн хүлээж байлаа.

БИ ЧИН ИЙ ТӨЛӨӨ ЗАЛБИРСАН

Саяхан би сүмийн цуглаанд жаахан шхоцорч ирээд нээлтийн дуу дуулж байх үеэр цуглааны байранд яаруу орж ирлээ. Танхимд орж ирээд тэнд ердийнхөөс илүү олон хүн суусныг харлаа. Эргэн тойрон дахь олон зочдыг хараад би хоёр зүйлийг ойлгов: нэгдүгээрт манай тойргийн Хүүхдийн Хэсгийн ариун ёслолын танилцуулга болж байгаа ажээ. Хоёрдугаарт, миний суудалд өөр хүн суусан учир надад суудал байсангүй.

Би эхний эгнээний сандлуудын нэгэнд яаруухан суутал, хоёр настай хүүгээ хөтөлж, зургаан сартай охиноо тэвэрсэн залуу ээж орж ирэхийг харлаа. Нөхөр нь араас нь орж ирсэнгүй. Цуглааны байрыг тойруулан харвал залуу эмэгтэйн нөхөр индэр дээр төгөлдөр хуурын ард сууж байлаа. Тэр Хүүхдийн Хэсгийн хөгжимчин байсан юм.

Цуглааны туршид би хоёр настай хөвгүүнд тусалж, Хүүхдийн Хэсгийн хүүхдүүдийн үг хэлж, дуулахыг сонирхон сонсож суулаа.

Би ганц бие болохоор нэг найзтайгаа хамт суудаг байв. Гэвч тэр өдөр найз маань хотод байхгүй байсан юм. Тиймээс би тэр залуу ээж болон хүүхдүүдтэй нь хамт сууя гэж бодоод тэдэнтэй нийлж болох уу гэж асуухад нөгөөх ээж зөвшөөрөв. Цуглааны туршид би хоёр настай хөвгүүнд тусалж, Хүүхдийн Хэсгийн хүүхдүүдийн үг хэлж, дуулахыг сонирхон сонсож суулаа.

Ариун ёслолын цуглааны төгсгөлд нөгөөх ээж над руу бөхийж, тэр өглөө миний төлөө залбирсан гэж хэллээ. Би түүнийг тодорхой тайлбарлахыг нь хүлээв. Тэр ээж намайг сүмд ирж, түүнтэй болон хүүхдүүдтэй нь хамт суухыг хүсч залбирснаа хэллээ. Тэр ариун ёслолын цуглааны үед ганцаараа хоёр хүүхдээ харж хандахад хэцүү байх

болно гэж боджээ. Би тэр өглөө түүний хийсэн энгийн залбирлын хариу болсондоо сэтгэл их догдолсноо мэдэрлээ.

Их Эзэн биднийг үнэхээр бидний ойлгож чадах тэр хэмжээнээс хамаагүй илүү хайрладгийг би мэднэ. Энгийн нэгэн хүсэлтийн хариуг гэрчилсэн тэрхүү туршлага надад чухал сургамж өгсөн бөгөөд уг туршлага тэр ээжид ч мөн чухал сургамж болсон гэдэгт итгэлтэй байна. Би тэр эгчтэй хамт сууж болох эсэхийг асуухдаа түүний залбирлын хариу болж байгаагаа мэдээгүй. Харин хэрэв би түүний оронд байсан бол өөр хэн нэгний хийхийг хүссэн зүйлийг л хийсэн гэж бодож байлаа.

Тэнгэрлэг Эцэг бидний залбирлуудыг, тэр ч байтугай, өчүүхэн жижиг залбирлуудыг ч гэсэн үнэхээр сонсож, хариулдаг билээ. ■

Ами Рханак Жонсон,
Айдахо, АНУ



ЧИ МИНИЙ ГУНИГИЙГ АРИЛГАЛАА

Би нэг үе гэр бүлийн түүхийн болон ариун сүмийн ажлыг идэвхтэй хийдэг байлаа. Гэвч судалгааны ажил ихсэхийн хэрээр өвөг дээдсүүдийнхээ нэг нь болох ээжийн талын өвөг эцгийн тухай мэдээлэл олж авахад бэрхшээл тулгарч байгааг мэдлээ.

Миний ээж өөрийн аав, дүү нартай хамт өсөөгүй ажээ. Тэр тэдэнтэй холбоо тасарсан учраас аавынхаа төрөл төрөгсөдтэй хамт өссөн юм. Ээжид төрсөн он сар өдөр, төрсөн газраа нотлох ямар нэг зүйл байсангүй. Аав нь хаана, хэзээ нас барсныг ээж мэддэггүй. Ээжийн талын өвөөгийнхөө тухай шаардлагатай мэдээллийг ер нь олж чадах болов уу хэмээн би эргэлзэж байлаа.

Нэг өдөр би ээжийнхээ тэмдэглэлийг үзэж байгаад өвөг эцгийнхээ гэрэл зургийг оллоо. Зургийг эргүүлж хартал, тэр зурган дээр өвөө он сар болон тэр жил хэдэн настай байснаа бичиж, гарын үсгээ зурсан байлаа. Одоо би түүний төрсөн он сар өдрийг ойролцоогоор мэддэг боллоо! Би сэтгэл догдлон түүний нэр төрсөн огноог FamilySearch-өөс эрж эхэллээ. Түүний ёслолууд аль хэдийн хийгдчихсэнийг хараад би бүр мэл гайхаж орхилоо! Өвөөгийн минь төлөө Ариун сүмийн ажлыг хэн хийлгэсэн байж таарах вэ?

Өвөөгийн өмнөөс Ариун сүмийн ажлыг миний ээжийн талын холын хамаатнуудын нэг нь хийлгэснийг би удалгүй олж мэдлээ. Тэгээд түүнтэй холбоо барих мэдээллийг хайсаар эцэстээ утасных нь дугаарыг олж авлаа.

Би түүн рүү утасдахаасаа санаа зовоод байлаа. Учир нь тэр хамаатан маань 30 жилийн өмнө намайг нэгтэй байхад нэг л удаа харсан гэдэг. Тэр юу гэж хариулахыг би мэдэхгүй байлаа.

Тэгээд юу ч гэсэн утасдаад үзэхээр шийдэв. Түүнийг утас авахад би өвөөгийнхөө болон түүний эцгийн тухай мэдээллийг хэрхэн олж авснаа тайлбарлаад, би түүний зээ хүү байна гэж хэллээ.

“Ээжтэй чинь холбоо тасраад би ямар их гунигтай байсныг чи хэзээ ч мэдэхгүй. Одоо чи миний тэр их гунигийг арилгалаа!” хэмээн тэр хариулсныг би үргэлж санаж явах болно.

Түүний гэр бүл, манай гэр бүл хоёр хэдийгээр хоорондоо холбоо тасарсан ч нэг л үед баптисм хүртэж, Есүс Христийн Хожмын Үеийн

Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүнээр батлагдсан бөгөөд хоёр гэр бүл хоёул сайн мэдээнд бат бөх итгэлтэй байсныг би мэдлээ. Энэ бол бидний хувьд баяр баясгалантай, сэтгэл догдлом агшин байлаа.

Гэр бүлийн түүхийн болон ариун сүмийн ажил биднийг нас барсан өвөг дээдэстэй маань холбож чадна гэдгийг би сэтгэл зүрхээрээ мэдэрч, ойлгодог байсан ч энэ ажил биднийг бас амьд байгаа төрөл саднуудтай холбож, уулзуулж өгнө гэж огт бодоогүй. ■

Кисси Райквилм Рохас,
Чили



Нэг өдөр би ээжийнхээ тэмдэглэлийг үзэж байгаад өвөг эцгийнхээ гэрэл зургийг оллоо.



Далын
Ахлагч Кевин
В.Пийрсон

Хувийн залбирлаа ХЭРХЭН САЙЖРУУЛАХ ВЭ?

Таны хувийн залбирлыг сонсоод өөрийн тань тухай бас Тэнгэрлэг Эцэгтэй харилцах харилцааны тань тухай юу мэдэж болох вэ?

Эцэгт хандан Есүс Христийн нэрээр залбирах бурханлаг урилга нь цэдэглэгдсэн бүх сударт хамгийн олонтоо дангаараа дурдагддаг зарлиг бөгөөд энэ нь хувь хүний сүсэг бишрэлийн үндсэн гол хэлбэр юм.

Хувийн залбирал бол Сүмийн гишүүд ялангуяа өсвөр үеийнхэн болон залуучуудад тулгарч байгаа хамгийн чухал сорилтуудын нэг мөн гэдэгт би итгэдэг. Тэдэнд залбирал хүндрэл учруулдаг учраас тэд сүнслэг байдлын хувьд хүндрэлтэй тулгардаг.

Бидний хувийн залбирал бол бидний сүнслэг хүч чадлын хэмжүүр, сүнсний сайн сайхан байдлын үзүүлэлт юм. Хэн нэгний залбирлыг сонссоноор түүний тухай бас Бурхантай харилцах түүний харилцааны тухай их зүйлийг мэдэж болно гэдгийг би эцэг хүний хувьд, санваартны удирдагч хийгээд номлолын ерөнхийлөгчийн хувьд мэдсэн юм.

Таны хувийн залбирлыг сонсоод өөрийн тань тухай бас Тэнгэрлэг Эцэгтэй харилцах харилцааны тань тухай юу мэдэж болох вэ?

ГЭРЭЛ ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ ЛЭС НИЛССОН

Залбирал бол Бурхан Мөнхийн Эцэг оршдог нь үнэн бодитойн хүчтэй бөгөөд итгэл үнэмшилтэй нотолгоо мөн. Бурхан болоод бидний тэнгэрлэг гарал үүслийг ойлгоход хувийн залбирал зайлшгүй чухал.

Хувийн залбирлын зарчим

Залбирна гэдэг нь дэргэд нь очихгүй ч бидний сүнсний Мөнхийн Эцэг Бурхантай ярина гэсэн үг. Тэр бидний хүн нэг бүрийг төгс хайрладаг бөгөөд нигүүлсэл ба ойлголтоор дүүрэн юм. Тэр бидний юм бүхнийг бас бидэнд юу хэрэгтэй байгааг мэддэг. Тэр бүр бид зөвхөн өөрийн хүслийг харж байгаа цагт ч бидний юу хүсч байгааг мэддэг. Биднийг удирдан дэмжих хязгааргүй хүч Түүнд бий. Тэр үргэлж биднийг уучлах, бүх зүйлээр бидэнд туслах хүсэлтэй байдаг.

Бид Тэнгэрлэг Эцэгтэй үгээр болон оюун ухаан, зүрх сэтгэл дэх бодол санаагаа илэрхийлэх замаар ярьж болно. Хувийн залбирал хүндэтгэлтэй, магтаал, талархлын ариун үгсээр дүүрэн, чухал хэрэгцээгээ чин сэтгэлээсээ хүссэн, даруухан бөгөөд чин үнэнээсээ гэмшсэн, уучлал, тайтгарал, удирдамж чиглэл, илчлэлт гуйсан байх ёстой. Эдгээр зүйлс нь биднийг бүх санаа бодлоо хайраар дүүрэн Тэнгэрлэг Эцэгтээ уудлан илчлэхэд хүргэдэг.

Залбирал нь ихэвчлэн богинохон яриа байдаг ч энэ нь бас өдөржин шөнөжин үргэлжилсэн илэн далангүй харилцан яриа байж болно (Алма 34:27-г үз).

Хувийн залбирал маш чухал

Тэнгэрлэг Эцэгийн бурханлаг төлөвлөгөөгөөр бид бие болон сүнсээрээ Түүний дэргэдээс тусгаарлагдах нь зайлшгүй шаардлагатай байсан юм. Залбирал бол Бурхан хүн хоёрын хоорондох нэн чухал сүнсний болон боломж олгогч хэлхээ холбоо мөн. Залбирал байхгүй бол бид Тэнгэр дэх Эцэгтээ эргэж очих боломжгүй. Залбирал байхгүй бол зарлигуудыг ойлгож, тэдгээрийг сахих хангалттай итгэл байх боломжгүй юм. Залбирал байхгүй бол уруу таталтаас зайлсхийж, бэрхшээл сорилтуудыг даван туулахад шаардлагатай сүнсний хүч чадал байхгүй байсан. Залбиралгүйгээр наманчлал,

уучлал, Цагаатгалын ариусгагч хүч байхгүй байсан. Хувь хүний залбирлын хүчээр бүх зүйл боломжтой юм.

Залбирал нь Ариун Сүнсээр дамжуулан хувиараа илчлэлт авах болон сүнсний бэлгүүдийг хүлээж авахыг боломжтой болгодог. Залбирал бол Бурханы бүх хүүхдүүдэд Мөнхийн Эцэг, Түүний Хайртай Хүү болон Ариун Сүнсстэй байнгын холбоотой байх боломжийг олгодог сүнсний суваг юм. Залбирал бол Бурхан Мөнхийн Эцэг оршдог нь үнэн бодитой хүчтэй бөгөөд итгэл үнэмшилтэй нотолгоо мөн. Бурхан болоод бидний тэнгэрлэг гарал үүслийг ойлгоход хувийн залбирал зайлшгүй чухал юм.

Залбирлаа хэрхэн сайжруулах вэ Залбирахад бэлтгэ

Бид өглөө эрт сэрж боссоныхоо дараа хийдэг анхны зүйл бол залбирал. Бас үр ашигтай залбирахад дэндүү ядарсан байдаг шөнө болсон хойно бид олонтоо залбирдаг. Бие махбод, оюун ухаан, сэтгэл санааны хувьд ядарсан байх нь үр ашигтай залбиралд саад болдог.

Залбирал бол оюун санааны болон сүнсний бэлтгэлийг залбирахаас өмнө хийхийг шаарддаг сүнсний ажил мөн. Хэрэв бид өөрийгөө даруусгах болон Мөнхийн Эцэг Бурханыг Есүс Христийн нэрээр дуудахад анхааралтай, буурь суурьтай хандахад цаг гаргахгүй бол биднийг адислахын тулд бий болгосон бурханлаг загварын мөн чанарыг ойлгохгүй.

Зүрх сэтгэлийнхээ чин хүслийг Тэнгэрлэг Эцэгт даруухнаар, анхааралтайгаар илэрхийлэхэд хангалттай цаг гаргаж бай. Юуны төлөө залбирахаа мэдэхэд туслалцаа авахын тулд Ариун Сүнсийг урь. Чангаар залбирах нь залбирал дээрээ анхаарал төвлөрүүлэн сонсож, санаа сэтгэлээ хамгийн чухал зүйл рүү чиглүүлэхэд надад тусалдаг.

Өөрийн амьдрал болон хэрэгцээний тухай анхааралтайгаар тунгаан бодох

цаг болоод газрыг хэрхэн олох талаар би та нарт зөвлөгөө өгье. Тэнгэрлэг гарал үүсэл хийгээд Бурхантай ямар холбоотойгоо тунгаан бод. Нэрээр нь Эцэгт хандан залбирдаг Аврагчийн тухай бод. Энэ бүгд нь даруухан бөгөөд талархагч зүрх сэтгэлтэйгээр залбиралд анхаарлаа төвлөрүүлж, бэлтгэхэд тань туслах болно.

Зохистой амьдар

Хэрэв бид ёс суртахууны хувьд цэвэр ариун биш байх юм бол Тэнгэрлэг Эцэгийнхээ оршихуйд итгэлтэй байж чадахгүй. Порнограф, бэлгийн харилцааны нүгэл, ёс суртахуунгүй явдалд өдөн дуудсан аливаа үзвэр цэнгүүн нь залбиралд итгэх бидний итгэлийг үгүй болгож, сүнсний өдөөлтүүд хүлээн авахад саад болно. Зөвхөн Сатан л чи залбирч чадахгүй, залбирах ч хэрэггүй гэж өөрт чинь хэлэх болно гэдгийг санагтун. Хэрэв бид дуулгавартай, зохистой байх юм бол Ариун Сүнс биднийг залбирахад үргэлж урамшуулан дэмжих болно.

Зорилготойгоор залбир

Хувиараа илчлэлт хүлээн авахад залбирал зайлшгүй чухал юм. Сүнс-лэг нөлөө бүхий асуултууд бидний залбирлыг зорилготой, анхаарал төвлөрүүлсэн бөгөөд үр өгөөжтэй болгодог. Та нар залбирлаараа дамжуулан хувийн илчлэлтүүд хүлээн авахыг хүсвэл ямар асуулт асуухаа сайтар бодох хэрэгтэй. Илчлэлтийн үйл явц нь биднээс судруудыг судалж, тунгаан бодоод, амьдралдаа хэрэгжүүлэхийг шаарддаг. Эдгээр зүйлсийг хийвэл Ариун Сүнс бидэнд сүнс-лэг нөлөө бүхий асуултууд асуухад тусална.

Өөрийн хүслийг Тэнгэрлэг Эцэгийн хүсэлтэй нэгтгэ

“Эцэгт хандан [Их Эзэний нэрээр] үргэлж залбирах ёстой” (3 Нифай 18:19) хэмээн Аврагч бидэнд удаа дараа зарлиг болгосон билээ. Бид

Есүсийн нэрээр залбирснаар “бидний оюун ухаан Христийн оюун ухаан, бидний хүсэл Христийн хүсэл болдог. . . . Ингэсэн тохиолдолд бид Бурханы талаас боломжтой юмсыг гуйж болно. Христийн нэрээр хэлээгүй учраас олон залбирал хариулагдахгүй үлддэг. Ийм залбирлууд хүний амин хувиа хичээгч үзлээс үүдэлтэй учраас Түүний оюун ухаанд хүрдэггүй” (Bible Dictionary, “Залбирал”-ыг үзнэ үү). Ийм загвартай залбирал нь итгэл биш, хоосон найдвар байдаг.

Залбирал бол хэлэлцэн тохиролцох үйл явц биш. Энэ бол нэгдэн нийлэх үйл явц. Бид хүсэл бодлоо Бурханд зүгээр л хүргээд орхидоггүй. Залбирал бидний нөхцөл байдлыг багахан өөрчилдөг, харин биднийг өөрсдийг маань илүү их өөрчилдөг. Энэ бол Түүний хүслийг эрэлхийлж, бид юу хийх хэрэгтэй байгаа талаараа Түүний тусламжийг гуйх явдал мөн. Бид өөрсдийн хүслийг Тэнгэрлэг Эцэгийн хүсэлтэй нэгтгэсэн үед хариулт болон сүнсний хүч чадал илүү чөлөөтэйгөөр ирэх болно. Энэ загварыг баримтлах нь итгэлээр залбирах боломжийг бидэнд олгодог.

Тэнгэрлэг Эцэг миний залбирлыг сонссон болов уу?

Манай тав дахь хүү Бенжамин бараг 20 жилийн өмнө төрсөн. Тэгэхэд манай эхнэр, Бенжамин хоёр нүд нэг л хэвийн биш байгааг мэдэртээ. Бид манай тойрог дахь өөрсдийн дотны найз, нүдний торлог бүрхэвчийн мэргэжилтэнтэй зөвлөдөхөд тэрээр Бенжамин нэн ховор тохиолддог нүдний торлог бүрхэвчийн хавдартай болохыг оношлов. Энэхүү оношинд бид цочирдон балмагдаж билээ.

Бенжаминд хийх ёстой олон мэс заслаас анхныхыг нь ганц хоёрхон долоо хоногийн дараа хийлээ. Бид

Залбирал бидний нөхцөл байдлыг багахан өөрчилдөг, харин биднийг өөрсдийг маань илүү их өөрчилдөг. Энэ бол Түүний хүслийг эрэлхийлж, бид юу хийх хэрэгтэй байгаа талаараа Түүний тусламжийг гуйх явдал мөн.





мэс заслаас өмнө эмчтэй уулзаж, тэрээр Бенжамины нүдийг авах биш харин эдгээнэ гэдэгт бид итгэж байгаагаа хэллээ. Манай гэр бүл бүгдээрээ бас тойргийн олон гишүүд манай хүүгийн төлөө мацаг барьж, залбирсан. Бенжамины өвчин эдгэрнэ гэдэгт бид маш их итгэлтэй байв.

Цагийн дараа мэс заслын эмч эргэж ирээд Бенжамины нэг нүдийг хавдрын эс бүрмөсөн гэмтээсэн байна. Нөгөө нүдэнд нь хавдрын хэд хэдэн ноцтой үсэрхийлэл бий болсон учраас яаралтай эмчилгээ хийх шаардлагатай гэхэд би дуугарч ч чадсангүй. Тэгээд гутрал, цөхрөлд бүрмөсөн автагдаж, эмнэлгээс гараад Сан Францискогийн чийглэг өглөө хар нулимс асгаруулан уйлж гарав.

Би заалгасан бүхнээ хийсэн. Бид залбирсан, энэ эмчийг сүнсний хүчтэй мэдрэмжээр сонгож авсан. Бид мацаг барьж, залбиран, бяцхан үр минь итгэл болон санваарын хүчний тусламжтайгаар эдгэрэх болно гэдэгт маш их итгэл найдвартай байсан. Гэвч Их Эзэн хөндлөнгөөс оролцсонгүй. Бидний итгэл хоосон найдвараас цаашгүй болсон мэт санагдлаа. Би өмнө нь итгэдэг байсан бүх зүйлдээ эргэлзэх болов. Гэр рүүгээ явахдаа надаас бүх зүйл нүүр буруулсан юм шиг санагдаж, уур хүрч байлаа. Зүрх шимшрэм гай зовлон намайг ингээд ялаа гэж үү?

Би тэр өглөө уйлан хайлж, учраа олохгүй сажилж явахдаа Тэнгэрлэг Эцэгтэй харилцсан яриагаараа бахархсангүй. Харин хэсэг хугацааны дараа сэтгэлийн сөрөг хөөрлөө дарж чадлаа. “Тэнгэрлэг Эцэг Та үнэхээр байдаг уу? Хүүхэд бүрийн залбирлыг Та сонсож, хариулдаг уу?” гэсэн Хүүхдийн Хэсгийн нэгэн дууны үг миний санаанд орж ирэв. Та миний залбирлыг сонсоогүй эсвэл надад болон хүүд минь анхаарал тавиагүй нь тодорхой байна хэмээн би бодож билээ (“A Child’s Prayer,” *Children’s Songbook*, 12.)

Яг тэр агшинд надад нэгэн сайхан мэдрэмж төрлөө. “Кевин, Бенжамин

чинь бас Миний хүү шүү дээ” гэсэн үгсийг би оюун ухаан, зүрх сэтгэлээрээ мэдэрлээ. Сүнсний энэхүү өдөөлт андуурах аргагүй тод томруун байлаа. Би залбирлын зорилгыг огт ойлгодоггүй байснаа тэр агшинд мэдлээ. Зөвхөн зөв учир шалтгааны төлөө санваарын хүчийг ашиглаж, мацаг барин, залбирснаар Бурханы хүслийг өөрчилж болох юм шигээр би бодож явжээ.

Миний бодол зөв биш байсныг би амьдралдаа анх удаа бүрэн ойлгож, Тэнгэрлэг Эцэгийн хүсэлд захирагдах хэрэгтэйгээ мэдсэн. Зөвхөн зарлигуудыг сахьдаг учраас хүссэн зүйлээ хэзээ, хэрхэн хүлээж авахыг би өөрийн хүслээр шийдэж чадахгүй шүү дээ. Залбирлын зорилго бол юу хийхийг нь Бурханд хэлж өгөх биш, харин Тэр надаар юу хийлгэхийг, надад юут мэдүүлэхийг хүсч байгааг мэдэх явдал мөн. Би өөрийн хүслийг Бурханы хүсэлтэй нэгтгэн нийлүүлэх хэрэгтэй.

Бид бяцхан хүүгийнхээ өрөөсөн нүдийг болон амь насыг нь аврахын тулд дахиад зургаан жил олон хүнд сорилттой нүүр тулгаран тэмцэлдсэн билээ. Гэвч энэ удаа Тэнгэрлэг Эцэг бидний зовлонг ойлгож, хөндлөнгөөс оролцсон юм. Юмс эцсийн дүндээ хэрхэн өөрчлөгдсөн нь хамаагүй, Тэрбээр миний залбирлыг сонсож хариулсан билээ. Өнөөдөр манай гайхамшигт хөвүүн Испанид бүрэн цагийн номлолд үйлчилж байна.

Бурхан бол хайраар дүүрэн, бидний Тэнгэрлэг Эцэг бөгөөд бидний залбирлыг үнэхээр сонсож, хариулдгийг би амьдралынхаа туршлагаар баттай нотолж байна. Бид хувийн залбирлын бурханлаг зарчмыг Аврагчийн зааснаар ойлгож, мэдсэнээр залбирал нь өөрийн тань амьдралд сүнсний хүч чадал хийгээд илчлэлтийн агуу эх сурвалж болж чадна. ■

Хавай дахь Бригам Янгийн Их Сургууль дээр 2011 оны 5-р сарын 17-нд онцгой цугларалт дээр хэлсэн үгнээс. Англи хэлээрх бүрэн эхийг devotional.byuh.edu -гээс үзнэ үү.

“Манай ах порнограф үздэг болсон. Тэр энэ талаараа бишоптой хамтран ажиллаж байгаа учраас би түүнд туслахыг хүсдэг. Гэвч энэ нь түүнд итгэх миний итгэлд нөлөөлсөн. Энэ асуудлыг би хэрхэн шийдэх вэ?”

Та ахдаа туслахыг хүсч байгаа нь тун сайн хэрэг. Өөрийн тань урам дэм түүнд хэрэгтэй байх болно. Ах чинь амьдралдаа тохиолдсон энэхүү сорилтыг өөрт чинь мэдэгдсэн нь дүүдээ итгэл найдвар хүлээлгэсэн анхны том алхам юм. Энэ сорилтой олонтоо холбоотой байдаг асуудлаа нуух, худал хэлэх явдлыг даван туулсан нь томоохон ахиц дэвшил гарахын нотолгоо мөн. Энэ нь ахдаа илүү их итгэдэг болоход тань тусална. Энэхүү итгэл өсч хөгжихөд цаг хугацаа шаардагдана. Гэвч энэ нь түүнийг хайрлах хэрэггүй гэж байгаа юм биш. Та ахынхаа төлөө залбирч, түүнд сайн үлгэр дууриал үзүүлж, түүнд туслахын тулд бусад зүйлсийг хийх хэрэгтэй.

Түүнийг шүүх гэсний хэрэггүй. Хэрэв тэр өөрийг нь шүүж байна гэж бодвол сорилтынхоо талаар муугаар бодож, өөрчлөлт гаргах нь түүнд улам хэцүү болно. Хүн бүхэнд сул тал байдаг. Энэ бол Аврагч Цагаатгалыг хийсэн нэг шалтгаан. Их Эзэнд болон наманчлалаар дамжуулан ах чинь асуудлаа шийдэн өөрчлөлт гаргаж, уучлагдаж чадна гэдэгт итгэлтэй бай.

Ах чинь энэ асуудлаар бишоптойгоо ажиллаж байгааг та мэддэг учраас энэ талаар бишоптойгоо ярилцаж болно. Бишоп болон эцэг эх тань юу хийхийг мэдэхэд тань тусалж болно. Та нар түүнд туслахын тулд гэр бүлээрээ хамтран ажиллаж болно. Гэр бүлээрээ түүний төлөө мацаг барьж болно. Энэ нь түүнд уруу таталтын эсрэг бамбай болно (Матай 17:21-ийг үзнэ үү).

Анхааруулга: Олон залуу эмэгтэйчүүд бас порнографт донтохтой тэмцэлдэж байна. Ийм асуудалтай эгч нарт өгөх зөвлөгөө ч мөн адил юм.

Харамслаа илэрхийл харин хэзээ ч бүү зэмлэ



Порнограф бол шалихгүй зүйл биш. Өөрийн чинь хайрладаг хэн нэгэн ийм асуудалтай болсныг мэдэх нь үнэхээр харамсалтай байдаг. Уг асуудал урт удаан хугацаанд үргэлжлэх байлаа ч түүнийг уучлахыг үргэлж хичээ. Уучлал, итгэл хоёр тусдаа зүйл гэдгийг санагтун.

Харамслаа илэрхийл харин хэзээ ч бүү зэмлэ. Тэр асуудалтайгаа тэмцэхэд ганцаараа биш гэдгийг мэдрэх нь чухал. Тиймээс үйлдлийнхээ төлөө хариуцлага хүлээдэг байх хэрэгтэй. Донтолтыг нь эс харгалзан та түүнийг хайрлавал тэр асуудлаа даван туулах найдвар, хүч чадлыг олох болно.

Бетани А., нас 18, Аризона, АНУ

Түүнд урам хайрла



Таны маш их итгэдэг хүн итгэлийг тань хөсөрдүүлбэл энэ нь танд хүнд тусдагийг би мэднэ. Таны хийвэл зохих эхний зүйл бол

ахтайгаа ярилцах хүч чадлын төлөө Тэнгэрлэг Эцэгт хандан залбирч гуйх явдал мөн. Та ахтайгаа асуудал нь ямархуу байгаа тухай долоо хоног тутам ярилцаж, тусламж авахад нь урам дэм өгөх судруудыг хувиараа судлан олж түүнд өгч болно. Хэдийгээр тэр итгэлийг тань алдсан ч гэсэн түүнийг дэмжиж туслах нь чухал. Их Эзэн түүнд хайртайг болон түүнийг уучлах болно гэдгийг ойлгуул. Дуулал 187-г “(God Loved Us, So He Sent His Son” [Бурхан биднийг хайрладаг учраас Хүүгээ илгээсэн юм]) гэдгийг түүнд сануул.

Наоми Б., нас 16, Миннесота, АНУ

Түүнд тусал

Тэр ямар сонголт хийснийг үл хайхран түүнд хайртайгаа харуул. Асуудлаа шийдэхийн тулд хийж байгаа алхам бүрийг нь дэмжиж, түүнтэй хамтран ажиллаж байгаадаа баяртай байдгаа харуул. Алдагдсан итгэл тэр дороо эргээд ирдэггүй ч итгэлийг тань дахин олж авахыг тэр хичээж байгаа шүү дээ. Тэр зөв зам дээр нэгэнт гарч, асуудлаа хэрхэн шийдэж, өөрчлөлт гаргахыг мэдэж байгаа

болохоор та түүнд дахин итгэж сурах хэрэгтэй.

Көрстин М., нас 17, Хойд Каролина, АНУ

Уучилж бай

Хэрэв та Цагаатгалын хүчийг ашиглавал наманчлах хүч чадалтай болоход нь ахдаа тусалж чадна. Цагаатгал нь сэтгэл санааны зовлонд унасан болон буруу сонголт хийсэн хүмүүсийг эдгээж чадна. Үргэлж уучилж, уур уцаарын оронд хайрын элдэв харцаар харж бай.

Сет Б., нас 18, Миссури, АНУ

Удирдамж хүсч залбир

Өвдөг сөгдөн, Тэнгэрлэг Эцэгээсээ удирдамж хүсэн, ахтайгаа ярилцаж, түүнтэй хамт залбир. Хэрэв бид Тэнгэрлэг Эцэгийнхээ өмнө өөрийгөө даруусгавал Тэр “[биднийг] хэрээс хэтэрсэн хүчээр соригдохыг зөвшөөрдөггүй, харин сорилтыг тэсвэрлэж чадахын тулд мөн сорилттой хамт мөн гарах замыг ч өгдөг юм” (1 Коринт 10:13). Тэр ахад чинь уруу таталтын эсрэг хүчтэй байж, үргэлж зөвийг сонгоход нь туслах болно.

Александра Б., нас 22, Калифорни, АНУ

Итгэл найдвараа бүү орхи

Ахдаа итгэх итгэл найдвараа бүү орхи. Учир нь энэ үе бол гэр бүл нь түүнд хамгийн хэрэгтэй үе мөн. Порнографын асуудал нь өөрт нь итгэх гэр бүлийнхээ итгэлийг адда-хад хүргэж мэдэх учраас түүнийг даван туулах нь ахад чинь яггүй хэцүү байгаа. Надад бас ийм асуудал тулгарсан бөгөөд би гэр бүлтэйгээ лацдан холбуулахаар Ариун сүмд явахаар зохистой болохын тулд наманчлахаар ажиллаж байна. Аав ээж хоёр юу гэх бол, тэд надад яаж хандах бол гэхээс би үргэлж айдаг байсан. Гэтэл тэд намайг дэмжин, асуудлыг хэрхэн шийдэхэд надад туслах хүсэлтэй байгааг нь би их

гайхсан шүү. Хэрэв ах чинь бишоп-тойгоо зөвлөлдөж, асуудлыг шийдэхэд хүч чармайлт гаргаж байгаа бол ахиц дэвшил гарч байгаа гэсэн үг.

АНУ-ын Аляскийн нэг залуу

Их Эзэнд итгэ



Цагаатгал зөвхөн бидний нүглийн төлөө төдийгүй бидэнд тохиолддог хүнд сорилт бэрхшээлүүд болон тэдгээрийг даван туулахын төлөөх хүч чармайлтуудын төлөө хийгдсэн юм. Есүс Христ таны сэтгэл санаа ямар байгааг яг тодорхой мэддэг, өмнө нь ч мэддэг байсан. Түүнд ханд, тэгвэл Тэр өөрийг чинь өргөхөөр гараа бэлэн байлгах болно. Түүний тусламжийн төлөө бас Цагаатгалын эдгээгч хүчний төлөө залбир. Өөрийн бүх санаа зоволт, асуудал бэрхшээл, нөхцөл байдлын талаар бодол санаагаа Тэнгэрлэг Эцэгт хэл. Хамгийн чухал нь гайхамшиг тохиохыг зүгээр хүлээж суух биш харин ямар нэг юм хий. Судруудыг судалж, өөрт чинь туслах мэргэн ухааныг эрж хай мөн бүх зүйл сайхан болно гэсэн итгэлтэй бай.

Меган А., нас 19, Аризона, АНУ



ЗАЛРУУЛАХ АРГА ЗАМ

“Биднийг энэ дэлхийд ирэхээс өмнө сөрөг хүчнүүд биднийг замаас гажуудуулахын тулд

уруу татах болно гэдгийг Тэнгэрлэг Эцэг мэдэж байсан учир ‘бүгд нүгэл үйлдсэнээр Бурханы алдарт хүргэдэггүй,’ (Ром 3:23) хэмээн хэлсэн билээ. Чухам иймээс Тэр бидэнд алдаагаа залруулах замыг бэлтгэсэн юм. Жинхэнэ наманчлалын нигүүлсэнгүй үйл явц болон Есүс Христийн Цагаатгалаар дамжин бидний нүгэл уучлагдаж, бид ‘мөхөхгүй, харин мөнх амьтай болох юм’ (Иоан 3:16).”

Тэргүүн Зөвлөлийн Хоёрдугаар зөвлөх Ерөнхийлөгч Диетер Ф.Угдорф, “A Matter of a Few Degrees,” Лиахона, 2008 оны 5-р сар, 60.

ХАРИУЛАХ АСУУЛТ

“Би ариун ёслолын үед юуны тухай бодож байх хэрэгтэй вэ?”

Хариултаа 7-р сарын 15-ны дотор liahona.lds.org дахь дараах э-мэйл хаягаар liahona@ldschurch.org эсвэл доорх хаягаар шуудангаар ирүүлнэ үү:

Liahona, Questions & Answers 7/13
50 E. North Temple St., Rm. 2420
Salt Lake City, UT 84150-2400, USA

Хариултын хэмжээг тохируулах болон тодорхой болгохын тулд хянан засварлаж болно.

Э-мэйл буюу захидалдаа дараах мэдээлэл болон зөвшөөрлийг оруулна уу: (1) бүтэн нэр, (2) төрсөн он сар өдөр, (3) тойрог буюу салбар, (4) гадас буюу дүүрэг, (5) таны хариулт болон гэрэл зургийг нийтлэхийг зөвшөөрсөн өөрийн чинь бичгээр гаргасан зөвшөөрөл, 18 нас хүрээгүй бол эцэг эхийн бичгээр гаргасан зөвшөөрөл (э-мэйл байж болно).



Сүмийн түүхч,
Далын
Ахлагч
Стивен Э.Снөү

Сүмийн түүх нь
итгэлийг хөхүүлэн
дэмжсэн, сэтгэл
догдлом үйл явдлууд
аар дүүрэн бөгөөд
үнэхээр сүнслэг
нөлөөтэй юм.

Гэгээнтнүүдтэй нэгдэхийн тулд гал голомтоо орхин, өгүүлэхийн аргагүй их золиослол хийсэн Сүмийн анхны гишүүдийн тухай түүхийн шастируудыг би амтархан уншдаг. Миний хувьд Сүмийн түүх нь баатарлаг үйл явдлуудаар дүүрэн бөгөөд анхдагчдын туулж өнгөрүүлсэн амьдрал, тэд өгүүлшгүй бэрх зовлонг хэрхэн даван туулсан хийгээд бошиглогчдыг дагасан тэдний тууштай итгэлээс би агуу хүч чадлыг олдог билээ. Та *тэдний* амьдрал үйлсийн тухай уншаад үзвэл *өөрийн* тань амьдралын нөхцөл байдал тийм ч хэцүү бишийг ойлгох болно.

Би Сүмийн түүхэнд дуртай. Би урьд өмнө нь хэзээ ч байгаагүйгээр Сүмийн түүхийг өнөө үед уншиж байгаа бөгөөд энэ нь миний хувьд улам сэтгэл догдлом, итгэлийг улам хөхүүлэн дэмжигч шинжтэй болж байна. Жишээ нь, гал халуун итгэл, гайхалтай зүйлсийг хийхэд тэднийг өдөөн урам зориг оруулж байсан гэрчлэлээс өөр юу ч үгүй байсан анхны номлогчдын ажил үйлс үнэхээр гайхамшигтай юм. Хэрэв би

итгэл, гэрчлэлээ байнга бэхжүүлэн бат бөх болгох юм бол тэдний үлгэр дууриал хүнд сорилт, бэрхшээлүүдийг даван туулахад надад туслах болно гэдгийг би ойлгодог. Их Эзэний агуу ажлыг урагш ахиулахад ямар гайхамшигт зүйлс тохиож байсныг харах бүрд миний гэрчлэл хүчирхэгжин бэхждэг билээ.

Өнгөрсөн үеийг өнөө үеэс ялгаатайгаар авч үзэх нь

Түүх бол өөрийгөө сүнслэг байдлын хувьд бэлтгэлтэй болгох нэг чухал арга зам мөн. Сүнслэг байдлын хувьд бэлтгэлтэй байж, туйлын хүнд сорилт бэрхшээлүүдийг даван туулсан хүмүүсийн тухай бас болох зүйлд сүнслэг байдлын хувьд бэлтгэдэггүй учраас урвасан хүмүүсийн тухай бид Сүмийн түүхээс уншдаг билээ. Сайн мэдээ, залбирал болон гэрчлэлд сэтгэл зүрх, цаг заваа зориулах нь сүнслэг байдлаа хөгжүүлж, үр жимсийг нь хүртэх агуу үйлсийг бүтээхэд бидэнд тусалж чадна гэдгийг бид мэддэг билээ.

Сүмийн түүхэн дэх хүмүүс бол

СҮМИЙН ТҮҮХИЙГ СУДЛАХДАА ТЭНЦВЭРТЭЙ БАЙДЛЫГ ХАНГАХ НЬ





бидэн шиг жирийн хүмүүс бөгөөд тэднээс олон нь ер бусын үйлсийг бүтээсэн билээ. Тэд бүгдээрээ төгөлдөржилтийн төлөө тэмцэж байсан ч төгс төгөлдөр болоогүй юм. Өнөөдөр бидэнд тохиолдож байгаа бөгөөд тэдгээрийг даван туулахын төлөө бидний тэмцэж буйтай адил олон хүндрэл бэрхшээл Сүмийн анхны гишүүдэд тохиолдсон юм. Гэвч төгөлдөржилтийн төлөө урт удаан хугацаанд тэдний хийж байсан хүнд хүчир тэмцлийг мэдсэнээс би хүч чадлыг олдог билээ.

Дэлхий сүүлчийн хоёр үеийнхний амьдралын хугацаанд их өөрчлөгдлөө. Интернет Сүмийн түүхийн талаарх бүх төрлийн мэдээллийг, ашигтай, үнэн, чухал мэдээллийг бас худал, төөрөгдүүлсэн мэдээллийг ч нүд ирмэхийн зуур олж үзэх боломжийг бидэнд олгож байна. Та Сүмийн түүхийн талаар асар их материалыг уншиж болно. Харин үүнийг тухайн үеийн түүхэн нөхцөл байдалд нь авч үзэн, ойлгох нь чухал. Онлайн дахь Сүмийн түүхийн талаарх зарим мэдээллийг тухайн



Та бусад аливаа зүйлсийн нэгэн адил Сүмийн түүхийг судлахдаа тэнцвэртэй байдлыг хангах ёстой.

АСУУЛТУУДАД ХАРИУЛАХ НЬ

Манай Сүмийн түүхийн зарим асуудлууд, жишээ нь тэнгэр элчүүд, газарт булаастай байсан алтан ялтсууд зэрэг нь итгэхэд хэцүү юм гэж хэлдэг найз нартаа би юу гэж хариулах вэ?

Хэрэв хүмүүс манай Сүмийн түүхэн дэх эдгээр зүйлүүд үнэн болсон явдал гэдгийг төсөөлж чадахгүй байгаа бол тэд үл итгэгчид юм. Дээрх зүйлүүд бол түүхийн туршид хүмүүн Бурхантай харилцан ажилласан гайхамшигт үйл явдлуудын нэг хэсэг гэдгийг бид ойлгох ёстой. Түүнчлэн бид тэдэнд гэрчлэлээ хэлж болох бөгөөд үүнийг өөрсдөө судалж үзэхийг тэднээс хүсч болно. Үүний дараа бид үүнийг тунгаан бодож, энэ талаар Тэнгэрлэг Эцэгт хандан, "Христэд итгэлтэй байж, чин сэтгэлтэйгээр, үнэн хүсэлтэйгээр" (Моронай 10:4) залбирч асуухад тэднийг урьж болно.

Хэрэв тэд энэхүү "туршилтыг" хийж, "итгэлийн өчүүхэн хэсгийг ашиглан" (Алма 32:27) Бурханаас асуух хүсэлтэй байвал Ариун Сүнс тэдэнд үнэнийг илчлэх болно.

үеийн түүхэн нөхцөл байдлаас нь салган авч үзсэн учраас үйл явдлыг өргөн хүрээнд бүхэлд нь ойлгох боломжгүй юм.

Сүмийг ичгүүртэй байдалд оруулах зорилготой мэдээлэл ерөнхийдөө үндэслэлгүй, шударга бус юм. Бид Сүмийн түүхийг болон бидний итгэл бишрэлийг илүү үнэн бодитойгоор дүрсэлсэн эх сурвалж материалуудыг олж унших ёстой. Зарим вэб сайтуудад зориуд мушгин гуйвуулсан эсвэл маргаантай, худал хуурмаг материалыг тавьж байна. Сүмийн гишүүн байна уу, гишүүн бус байна уу хамаагүй олон нийтийн сайн мэдэх, нэр хүндтэй түүхчдийн бичсэн эх сурвалжуудыг олж унш.

Зарим залуу хүмүүс интернет дэх Мормоны сүмийн эсрэг материалуудыг үзээд гайхаж, дуу алдан цочирддог нь тэд ийм зүйлд бэлтгэлгүй байгаагийнх. Тэд тохиолдож болох аливаа зүйлд сүнслэг байдлын

хувьд бэлтгэлтэй байж, өөрийгөө хүчирхэгжүүлэхэд хангалттай цаг зориулдаггүй байж болох юм. Амьдрал санаандгүйгээр тэдний өмнө сорилт бэрхшээлүүдийг бий болгоход тэд бидний үргэлж ярьдаг хоёр чухал зүйлийг хийдэг байх нь чухал юм. Энэ хоёр зүйл бол судруудыг тогтмол судалж, Тэнгэрлэг Эцэгтээ хандан үр өгөөжтэйгөөр залбирах явдал мөн. Амин чухал хоёр зүйл нь хүмүүсийг бүхий л сорилт бэрхшээлүүдэд, түүний дотор онлайнд тааралдаж болох Мормоны сүмийн эсрэг өгүүлүүдийг уншаад цочирдон балмагдахгүй байхад бэлтгэх болно.

Тэнцвэртэй байдлыг хангаж байх шаардлага

Та бусад аливаа зүйлсийн адил Сүмийн түүхийг судлахдаа хэт нэг талыг барихгүй байх ёстой. Үнэн Сүм үргэлж цөөнх байсан бөгөөд дайснууд бидний улыг ямагт шагайсаар ирсэн юм. Бид хүнд сорилт бэрхшээлүүдтэй үргэлж тулгарсаар байгаад бүр дасчихсан улс. Сорилт бэрхшээлийг даван туулах хамгийн сайн арга бол бид бүгд зохистой байж, гэрчлэлээ



Хэрэв та Сүмийн түүхийн талаарх маргаантай, худал ташаа мэдээллийг дагнан судлахад илүү их цаг зориулвал Сүмийн түүхийн олон зүйлийг мэдэхгүй өнгөрч, цөөхөн зүйлийн талаар өрөөсгөл ойлголттой болж мэднэ.

хүчирхэгжүүлэх явдал мөн. Та Сүмийг болон үүний түүхийг мушгин гуйвуулж, шүүмжилсэн вэб сайтад цаг гаргадаг атлаа судруудад зориулж цаг гаргадаггүй бол буруу зам руу халтиран орж байгаа нь тэр. Энэ нь танд мөн таны итгэлд сөргөөр нөлөөлж мэднэ. Харин та хэт нэг талыг барихгүй бол ийм зохисгүй зүйл танд тохиолдохгүй.

Би өсвөр насандаа сүнсэлэг байдлыг өөртөө хөгжүүлэх нь хэчнээн чухал болохыг ойлгодоггүй байж. Чухамдаа Мормоны Номыг чамбайхан судлахын оронд сайн хөл бөмбөгчин болохыг илүү сонирхдог байлаа. Би олон залуу эрэгтэйчүүдийн адил номлолын талбарт очих хүртлээ хувь хүний амьдралд гардаг өөрчлөлт, жинхэнэ аз жаргал гэж юу болохыг ойлгоогүй юм. Энэ бол Их Эзэнд үйлчлэхээс, суралцаж, залбирахаас, бусдыг хайрлаж, тэдэнд үйлчлэхээс ирдэг баяр баясгалан юм. Хэрэв би амьдралдаа эдгээр зүйлсийг хайхрахгүй явж ирсэн бол юмс одоогийнх шиг сайн сайхан байхгүй байсан гэдэгт би итгэдэг. Хэрэв би эдгээр зүйлсийг хийх юм бол бүх зүйл хэвийн байх болно.

Би Сүмийн түүхийн асуудлуудаар аль нэг тал руу хэт хэлбийхгүй, бодитой хандсанаар бидний өвөг дээдсийн ихэнх нь хүнтэй л адил алдаа гаргадаг, эгэл жирийн атлаа үнэхээр бахархан биширмээр хүмүүс байсныг ойлгосон. Тэд хүнтэй л адил учраас алдаа гаргадаг байжээ. Манай Сүмийн түүхэнд гунигтай эсвэл ээдрээтэй зүйлүүд байдгийг бид илүү сайн ойлгохыг хичээдэг ч магадгүй эдгээр асуудлын зарим нь энэ амьдралд хариулагдахгүй байж болох юм. Хэрэв тэгвэл юу нь муу байхав.

Хэрэв найз маань над руу ирж, Сүмийн түүхийн талаарх ямар нэг маргаантай асуудлын тухай шударгаар асуувал би түүний асуулгад

хариулахын тулд чадах бүхнээ хийх болно. Хэрэв найз маань Сүмийн түүхийн талаарх маргаантай асуудлуудыг судлахад олон цаг зориулж байгаа нь мэдэгдвэл би түүнээс юуны өмнө дараах асуултуудыг асуух болно: “Чи Мормоны Номыг уншсан уу? Залбирч үзсэн үү? Хүнд сорилт бэрхшээлүүдээс өөрийгөө хамгаалахын тулд амьдралдаа тэнцвэртэй байдлыг хангаж чадаж байгаа юу?”

Сүмийн түүх нь итгэлийг хөхүүлэн дэмжсэн, сэтгэл догдлом үйл явдлуудаар дүүрэн юм. Хэрэв та Сүмийн түүхийн талаарх маргаантай, худаа ташаа мэдээллийг дагнан судлахад илүү их цаг зориулбал Сүмийн түүхийн олон зүйлийг мэдэхгүй өнгөрч, цөөхөн зүйлийн талаар өрөөсгөл ойлголттой болж мэднэ. Харин та Сүмийн түүхийг бүхэлд нь түүхэн нөхцөл байдалд нь ойлгох хэрэгтэй. Тэгвэл энэ нь танд асар их сүнсэлэг нөлөө үзүүлэх болно.

Жишээ нь, Иосеф Смит гайхамшигтай хүн байлаа. Харин тэр төгс төгөлдөр байсан уу? Үгүй. Бид бүгдээрээ жирийн хүмүүс. Гэвч тэр богинохон хугацаанд Сүмийг сэргээхийн тулд юу хийснийг ойлгохын тулд Мормоны Номыг болон Сургаал ба Гэрээн дэх илчлэлтүүдийг уншвал гайхалтай гэрчлэлтэй болно. Бүх бошиглогчдоо хүнд сорилт бэрхшээлүүд тулгарч байсан бөгөөд Иосеф Смитэд үй түмэн бэрхшээл байсан бөгөөд цөөн хүмүүс түүнд гомдож байсанд гайхах зүйл үгүй юм. Гэвч тэр Бурханы бошиглогч байсан нь тодорхой юм.

Одоогийнх шиг цаг үе байхгүй

Сүмийн гишүүн болсноор миний амьдралд төсөөлөхийн аргагүй агуу үе эхэлсэн юм. Намайг эхнэртэйгээ гэрлэж, гал голомтоо бадраахад Сүмд нийтдээ 13 Ариун сүм байлаа. Бид хоёр бүх Ариун сүмд орох

зорилго тавьснаа санаж байна. Өнөөдөр дэлхий даяар 140 орчим Ариун сүм үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд бид хэзээ ч эдгээр Ариун сүмүүдэд бүгдэд нь орж чадахгүй. Энэ бүхэн бол Сэргээлтийн үр дүн, бошиглогчид, төлөөлөгчид, Ариун сүмүүд, санваар, Мормоны Номын үр дүн мөн. Илчлэлтүүд бол бидний амьдралд ирдэг агуу адислал юм. Аврагч болон Түүний сайн мэдээ, бидний Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөө энэ бүхнийг бидэнд боломжтой болгосон билээ.

Би аль ч талаараа жирийн л нэг хүн, гэвч Тэнгэрлэг Эцэг минь надад хайртайг би сайн мэднэ. Тэрбээр бид бүгдийг хайрладаг. Бид үнэхээр Түүний хөвгүүд, охид билээ. Тэр бидний амьдралын аарсаар жижигхэн юм бүрийг удирдан чиглүүлдэггүй. Энэ бол бидний өсч хөгжих үйл явцын хэсэг юм. Тэнгэрлэг Эцэг биднийг сонгох эрхээ мэдэж, ашиглан, сорилт бэрхшээлүүдийг шийдвэрлэх чадвартай байхыг хүсдэг. Миний амьдралд, гэр бүлийн минь амьдралд Түүний нөлөө үнэхээр их байдгийг би мэднэ. Би амьдралд хайртай учраас энэхүү мөнх бус оршихуйдаа талархалтай байдаг. Амьдралд олон буруу зүйл байдаг ч бас олон агуу зүйлс тохиож байдагт, сүнсэн хүмүүс дэлхийд ирж, бие махбодыг олж, үүрд мөнхийн туршид бидэнд туслах зүйлсэд суралцаж байгаад би талархалтай байдаг.

Түүх нь өнгөрсөн үеэ эргэж харах боломжийг бидэнд олгодог учраас бидний амьдралыг адисалдаг. Зарим үед өнгөрсөн амьдралаа эргэж харах нь хэцүү байдаг ч бид түүхээр дамжуулан бусад хүмүүсийн өнгөрсөн амьдралыг харж, тэднийг адисалсан зүйлсийг мэдэж болно. Бид бас өвөг дээдсээ адисалсан зүйлсийг мэдсэнээр алдаа гаргахаас сэрэмжлэхэд өөрсдөдөө тусалж чадна. ■



Арванхоёр
Төлөөлөгчийн
Чуулгын
**Ахлагч Д.Тодд
Кристофферсон**



СҮНСНИЙ ХҮЧТЭЙ

*Тэнгэрлэг Эцэг,
Ариун Сүнс хоёр
бид бүгдийг нэг
бүрчлэн мэддэг
учраас хаана ч бай-
сан гэсэн хүн бүрт
гэрчлэл ирж болно.*

Ариун ойн цоорхойд залбиралдаа хариу авахыг эрэлхийлсэн минь

Би залуу байхдаа зуны нэг орой Нью-Йоркийн Палмирад очих завшаан тохиож, Ариун ойн цоорхойд ганцаараа очсон юм. Тэгээд өвдөг сөгдөн залбирч, тэрхүү ариун газар болсон хэмээн миний өмнө нь мэддэг байсан зүйл үнэн гэдгийг надад дахин мэдүүлж өгөхийг Тэнгэрлэг Эцэгээс гуйлаа. Би удаан хугацаанд чин сэтгэлээсээ хүндэтгэлтэй залбирсан. Гэтэл би ямар ч хариу эсвээс Ариун Сүнсний өдөөлт хүлээж авсангүй. Юу ч мэдэгдсэнгүй. Эцэстээ би урам хугарч, “Би ямар буруу юм хийчихсэн юм бол? Яагаад ингэв? Өөр юу хэрэгтэй байсан юм бол?” гэж бодлоо. Орчин тойрны байдал нь залбиралд хариу хүлээн авахад үүнээс илүү тохиромжтой газар хаана байх вэ гэж бодмоор.

Бид Бурханаас ямар нэг юм шаардаж болохгүй, “Та надад ийм байдлаар, яг энэ мөчид хариулах ёстой” хэмээн бид хэлж болохгүй гэдгийг би энэ туршлагаасаа мэдсэн юм. Бидэнтэй хэзээ, яаж харилцан, юуг хэлэх нь Түүний өөрийнх нь мэдэх хэрэг юм. Бидний үүрэг бол сүнсний өдөөлт буюу шивнээ, илчлэлт, Сүнсний удирдамж хүлээн авах хамгийн тааламжтай нөхцөлд үргэлж байх явдал мөн. Харин хэрхэн, хэзээ гэдэг шийдвэрийг Бурхан гаргадаг.

Хариуг гэртээ хүлээж авсан минь

Тэр үед хүсээд хүлээж аваагүй зүйлээ би тав зургаан долоо хоногийн дараа гэртээ хүлээж авсан юм. Би гэртээ Мормоны Номыг уншиж байлаа. Гэтэл Ариун Сүнсээр дамжин миний итгэл, гэрчлэлийг баталсан хүчтэй сэтгэгдэл, мэдрэмж ба



МЭДРЭМЖҮҮД

бодол миний оюун ухаанд зурсхийн орж ирлээ.


Тэрхүү асар их хүчтэй мэдрэмж намайг бүр уйлахад хүргэв. Энэ бол бас үгээр илэрхийлэх шаардлагагүй тийм цэвэр мэдрэмж байлаа. Сүнсний мэдрэмжийг үгээр хязгаарлах аргагүй. Сүнс сүнстэйгээ алдаа мадаггүй хэлээр харилцдаг бөгөөд

энэхүү харилцаанд үг хэрэглэгддэггүй. Энэ бол Сүнснээс ирдэг цэвэр мэдлэг ба оюун билгийн харилцаа юм. Мөн энэ нь мэдлэг эзэмших үнэхээр шилдэг арга зам болохыг би мэдсэн билээ. Энэ нь юмсыг барьж үзэх буюу харахаас илүү хүчтэй ба урт удаан хугацаанд оршдог. Бид бие эрхтний мэдрэмжүүдэд

эргэлзэж болно, харин Ариун Сүнс бидэнд хандан ярьж байгаа үед ямар ч эргэлзээ байдаггүй. Чухам иймээс Ариун Сүнсийг буюу Ариун Сүнсний гэрчлэлийг үгүйсгэх нь уучлагдашгүй нүгэл байдаг.

Бурханы хайрыг мэдрч, ойлгосон минь

Их Эзэн Ариун ойн цоорхойд яагаад миний залбиралд хариулаагүйг би сайн ойлгосон. Учир нь хүн Палмирад аялаар очих далимдаа Бошиглогч Иосеф Смитийн тухай гэрчлэлтэй болох мэтээр би эндүү бодсон байлаа. Залбирлын хариу хаана ч ирж болдгийг би одоо ойлголоо. Бид Их Эзэн Есүс Христийн тухай гэрчлэлтэй болохын тулд Иерусалим руу явах албагүй шүү дээ. Бидний Тэнгэрлэг Эцэг, Ариун Сүнс хоёр бид бүгдийг нэг бүрчлэн мэддэг учраас гэрчлэл, хэнд ч гэсэн



хаана байгаагаас нь үл хамааран ирдэг. Тэд биднийг хаана байгааг бас хэрхэн олохыг ч мэддэг. Тэдэнд виз шаардлагагүй. Тэд бүх дэлхийг нэгд нэгэнгүй мэддэг! Аль хэдийнээс ийм байсаар ирсэн билээ.

Хэрэв та нар итгэлтэй хэвээр байх юм бол Их Эзэн надад өгсөнтэй адил залбирлын хариут тийм гэрчлэл болон баталгааг та нарт өгөх болно гэдгийг би залуу хүмүүс та нарт амлаж байна. Учир нь Тэрбээр намайг эсвэл Ерөнхийлөгч Томас С.Монсонг болон Өөрийн аль ч хүүхдийг хайрладаг шигээ та нарыг бас бүгдийг нь тийнхүү хайрладгийг би мэднэ.

Бурхан хүн бүрийг хязгааргүй хайраар энэрэн хайрладаг. Тэр хүн бүртэй яаж харилцахаа бас та нарыг хаана байгааг болон Ариун Сүнсээр дамжуулан та нарын зүрх сэтгэлд хэрхэн хүрэхээ мэддэг.

Байнга залбирч, үргэлж асууж бай. Зарлигуудыг дагахаа орхиж болохгүй. Та нар одоо биш юм аа гэхэд цаг нь ирэхээр хүчтэй гэрчлэлтэй болно. Ийм гэрчлэл ганцхан удаа гэнэт ирэхгүй. Харин энэ нь Их Эзэний нигүүлслээр дамжин алгуураар бүх амьдралын тань туршид ирэх болно.

Гэрчлэл хүлээж авсаар байгаа минь

Надад ийм нэг явдал тохиолдож билээ. Би Аргентины Тукумбад номлолд үйлчилж байхдаа нэг гэр бүлд зааж, Бошиглогч Иосеф Смитийн Анхны Үзэгдлийн тухай гэрчлэлээ хуваалцлаа. Гэтэл тэд үүнд итгэсэнгүй. Гэвч би гэрчлэлээ хуваалцаж байх үеэр гэрчлэлийнхээ тухай өөр нэг баталгааг хүлээн авлаа. “Гэрчлэлийн тань үгс үнэн шүү” гэж Сүнс надад хэллээ. Тэр

миний гэрчлэл үнэнийг надад баталсан юм.

Бурхан байдаг, Тэр бол бидний Тэнгэрлэг Эцэг, Тэр амьд бөгөөд Бошиглогч Иосеф Смитийг Сэргээлтийн Бошиглогч болгон Өөртөө үйлчлүүлэхээр дуудсан, Түүний Хүү мөн амьд бөгөөд Түүний ач ивээл бид бүгдийг аврах, цэвэршүүлэх болон уучлахад хангалттай гэсэн баталгааг та бүхэн насан туршдаа дахин дахин хүлээн авах болно.

Би эдгээр зүйлсийг мэдэх бөгөөд эдгээр зүйлсийн онцгой гэрч мөн. Бидний Их Эзэн амьдыг, Тэр бол үхээд амилсан хүмүүн гэдгийг, Тэр биднийг удирддаг бөгөөд Түүний нэрээр нэрлэгддэг энэ Сүмийн тэргүүн гэдгийг, энэ Сүм Түүнийх гэдгийг, та бүхэн Түүний хонин сүрэг гэдгийг би мэднэ. ■

2011 оны 11-р сард Аргентины Салтад өсвөр үеийнхэнд хандаж хэлсэн үгнээс.



АЙ БУРХАНЫ МААНЬ ТӨЛӨВЛӨГӨӨ

ХЭЧНЭЭН АГУУ БИЛЭЭ!



Зүрх сэтгэлд минь гомдол, ганцаардал давамгайлсан үед сайн мэдээний тухай мэдлэг урагш тэмүүлэх итгэлийг надаг төрүүлдэг билээ.

Э.Амарсанаа

Би зүүн хойд Монгол дахь Бэрх хэмээн нэрлэгддэг сууринд өссөн хүн. Бэрхэд хүмүүс Сүмийн тухай бараг мэддэггүй байлаа. Би айлын гурван хөвгүүний дундах нь. Бид ах дүү гурав үргэлж хамт байдаг байлаа. Ахыгаа хот руу сургуульд явахад би түүнийг ёстой л бэтгэртлээ санадаг байж билээ. Ах маань хоёр жилийн дараа зуны амралтаараа гэртээ ирлээ. Тэр зун манайх хадат толгодын дунд гурван сарааран хийхээр явлаа. Ийнхүү анд явсан нь миний амьдрал дахь хамгийн сайхан зуны амралт болсон юм.

Ах надад өөрийнхөө элссэн сүмийн тухай яриад энэ Сүмийг Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм гэдэг гэж ярьдаг байлаа. Тэр үед би Христийн сүмүүдэд дургүй байсан болохоор ахынхаа хэлсэн зүйлийг нэг их анхаарсангүй.

Намрын нэг өдөр биднийг анд яваад гэртээ иртэл хотоос манайд зочид ирсэн байлаа. Тэд ахын яриад байсан нөгөөх Сүмийн хүмүүс ажээ. Ах тэр оройдоо тэдэнтэй хамт хот руу буцлаа. Дараахан нь бид тэр яагаад явсныг мэдсэн. Тэр номлолын дуудлага хүлээн авсан ажээ.

Ах номлолын өргөдөл явуулснаа ч бидэнд яриагүй. Түүнээс хойш удалгүй ах маань Америкийн Нэгдсэн Улс руу номлолд явсан.

Сайн мэдээнд хөрвөсөн нь

Би дараа жил нь ахлах сургуулиа төгсөөд их сургуульд сурахаар хот руу явлаа. Хотод миний очсон айлынхан Сүмийн гишүүд байлаа. Ням гарагийн өглөө тэд намайг өөрсөдтэйгөө хамт сүм рүү очихыг урилаа. Би энэ Сүмийн тухай их зүйл сонссон болохоор яахав нэг удаа очоод үзье гэж бодлоо.



БҮР ХАМГИЙН ХҮНД ЦАГ Ч АДИСЛАЛ БАЙЖ БОЛНО

“Хэрэв бид Есүс Христэд итгэх итгэлтэй байвал амьдрал дахь хамгийн хэцүү үе, хамгийн аз жаргалтай сайхан цаг аль аль нь адислал болж чадна. Бид бүх нөхцөлд Сүнсний удирдамжаар зөвийг сонгож чадна. Хэрэв бид Есүс Христийн сайн мэдээг сонговол энэ нь бидний амьдралд нөлөөлөн, биднийг удирдах болно. Авралын төлөвлөгөөн дэх бидний байр суурийг илчилдэг бошиглогчдыг дагавал бид төгс итгэл, амар амгалангийн мэдрэмжтэйгээр амьдарч чадна.

Тэргүүн Зөвлөлийн Нэгдүгээр зөвлөх Ерөнхийлөгч Хенри Б.Айринг, “Авирах уулс,” Лиакхона, 2012 оны 5-р сар, 26.

Сүүдээ би сүмд олон удаа очсон. Яагаад гэдгийг мэдэхгүй ч би сүмд очих болгондоо амар амгаланг мэдэрдэг байлаа. Сүмийн хүмүүс сайхан зантай, намайг очих болгонд гар барина. Сүм миний боддог байснаас огт өөр ажээ. Би удалгүй номлогчдоос ярилцлага авч эхэллээ. Би бараг хоёр жилийн турш номлогчидтой уулздаг байсан.

Би баптисм хүртэхийг хүсдэг байсан ч надад Мэргэн Ухааны Үгийн талаар асуудал байсан учраас миний баптисм хойшилсныг мэддэг байлаа. Мэргэн Ухааны Үгийг сахих нь надад хэцүү байсан ч би эцэстээ баптисм хүртэхэд бэлэн болсон. Номлолоосоо эргэж ирээд ганц хоёрхон сар болж байсан ах маань надад баптисм хүртээх аз тохиосон юм. Одоо би тэр агшныг эргэн санаад заримдаа уйлдаг. Энэ бол миний амьдралын хамгийн аз жаргалтай агшин байлаа.

Намайг Сүмд нэгдсэний дараа ах маань номлолын ажлын талаар бараг өдөр болгон ярьдаг байв. Тэр намайг номлолд явахыг үргэлж урамшуулан дэмждэг байсан. Тиймээс би ахынхаа туслалцаатайгаар номлолын өргөдлөө бөглөлөө. Би

тэр үед ахтайгаа хамт хэчнээн сайхан байснаа хэзээ ч мартахгүй.

Аймшигтай үйл явдал

Нэг орой ах намайг хүрээд ир гэж утасдсанд би ажлынхаа дараа түүнтэй очиж уулзлаа. Тэр надтай миний номлолын талаар зарим зүйлийг ярилцах гэсэн ажээ. Бид хотын төв талбай дээр уулзахаар тохиролцов.

Тэр үед Монголд парламентын сонгууль болоод ганц хоёрхон хонож байв. Ах бид хоёрыг төв талбай дээр уулзахад сонгуулийн будлианы улмаас тэнд иргэдийн жагсаал цуглаан болж байлаа. Цагдаа нар тэнд байсан ч жагсаал улам бүр хүчирхийллийн шинжтэй, аймаар болж эцэстээ үймээн самуун болж өргөжив. Нэг том барилга, хэдэн машин шатаж, хүмүүс улангассан мэт хашгирагдах нь үнэхээр аймаар байлаа.

Бид хоёр жагсаал цуглаан болж байсан газраас хол уулзсан ч ах санаа нь их зовсон байлаа. Тэр надад такси авах мөнгө өгөөд гэр рүүтээ шууд яв гээд намайг маргааш өөртэйгөө ирж уулзаарай гэж билээ. Тэр ажлынхаа газрын ойролцоо байдаг гэр рүүтээ явна гэж хэлсэн. Такси хүрч ирэхэд бид



хоёр баяртай гэж бие биедээ түргэн хэлээд би хөдөлсөн.

Үймээн самуун улам өргөжин газар авсан учир засгийн газар бүх замыг хаасныг би удалгүй мэдлээ. Би хотын зах дахь гэртээ харьж чадсангүй, шөнө нь ажил дээрээ хонолоо. Үймээн самуун улам хүчээ авсан учир төрийн тэргүүн тэр шөнө онцгой байдал зарлав. Хаа сайгүй хуягт машинууд, зэвсэгтэй цэргүүд. Онцгой байдал дөрвөн өдөр үргэлжлэв.

Онцгой байдал дуусахад манай хүргэн ах намайг авахаар ирлээ. Бид хоёр манай бүх садан төрлүүд цуглаад хүлээж байсан тэдний гэр рүү очлоо. Тэд бүгдээрээ уйлж байх юм. Ахыг минь гэр рүүгээ явж байхад нь буудаж, амийг нь хөнөөсөн ажээ.

Миний зүрх гэнэт зогсчих шиг болов. 24-тэй ах минь нөгөөх үймээн самууны үеэр бууны суманд өртөж амиа алдсан юм. Ахын минь амь насыг хөнөөсний дараах өдрүүд миний амьдралд хамгийн аймшигтай муухай үе болсон юм.

Ийм хүнд цаг үед би номлолын дуудлагаа хүлээж авлаа. Би хөрвөлт болон баптисмынхаа үед түүнчлэн номлолын өргөдлөө бэлтгэж бөглөхдөө үргэлж ахтайгаа хамт байсан бол номлолын дуудлагаа задлахад

ганцаархнаа байлаа. Гайхалтай нь, би эх орондоо үйлчлэхээр дуудагдсан байв.

Би ганцаараа байсан болохоор тэр дороо өвдөг сөгдөж, залбирлаар дамжуулан Тэнгэрлэг Эцэгтээ талархал өргөлөө. Бас ахынхаа төлөө залбирав. Би залбирч байхдаа тувт уйлсаар байлаа. Зүрх сэтгэл минь гомдол, ганцаардлаар дүүрсэн үед Сүнс надад авралын төлөвлөгөөг улам бүр тод томруунаар гэрчилж байгааг, үүний улмаас гэрчлэл минь улам хүчтэй болж байгааг мэдэрдэг байлаа.

Түүний төлөвлөгөөний тухай гэрчлэл

Намайг номлолын дуудлагаа задлахад ах минь байгаагүй ч би түүнд үргэлж талархалтай байх болно. Би бас Есүс Христийн Цагаатгалаар дамжуулан авралын төлөвлөгөөг бидэнд өгсөн Бурханд үргэлж баярлан

талархаж явах болно. Энэ бол хамгийн гайхамшигтай төлөвлөгөө. Хэрэв бид энэ төлөвлөгөөг дагах юм бол зүрх сэтгэлдээ амар амгаланг мэдрэх болно.

Судруудад бидэнд ийн өгүүлдэг билээ: “Ай Бурханы маань төлөвлөгөө хэчнээн агуу билээ! Учир нь. . . Бурханы диваажин зөв шударгыг үйлдэгчдийн сүнснийг чөлөөлнө; мөн булш зөв шударгыг үйлдэгчдийн биеийг чөлөөлөх ёстой, мөн сүнс болон бие нь өөртөө дахин нэгдэнэ, иймээс бүх хүмүүн муудашгүй, мөн үхэшгүй болж, мөн тэд амьд бодгаль байх болно” (2 Нифай 9:13).

Ах минь сүнсний дэлхийд амьд байгааг би мэднэ. Энэхүү мэдлэг номлолын ажлаа сайн хийхэд хэрэгтэй итгэлийг надад өгсөн юм. Хүнд үед ах минь бас Их Эзэн надтай хамт байх болно гэдгийг би мэднэ. ■



Зүүнээс баруун тийш: Э.Амарсанаа ба түүний ах Э.Доржсүрэн, дүү Э.Амарсайхан нар





ТА НАР ОРОН НУТГИЙН УДИРДАГЧДАА ДАРААХ АРГА ЗАМУУДААР ДЭМЖИЖ БОЛНО:

- Үйлчлэх дуудлагыг хүлээн авах.
- Хүссэн үед удирдагчдад болон бусад хүмүүст туслах.
- Хичээлүүдийг заахаас нь өмнө уншиж бэлтгэх.
- Удирдагчдынхаа төлөө залбирах.
- Хичээлд оролцох.

Санваартны удирдагчдын зөвлөгөөг дагах таван арга зам

Их Эзэн Өөрийнхөө үед шавь нартаа хандан ярьж, хүмүүст заадаг байлаа. Тэр өнөөдөр ч бас үүнийгээ хийсээр байна.

Аврагч хэдийгээр бидний дунд өөрийн биеэр байхгүй ч биднийг удирдуулахаар Өөрийн Сүмийн гишүүдийг дуудаж, тэдний зөвлөгөөг дагахыг биднээс хүсдэг. Тэд энэхүү зөвлөгөөг Ариун Сүнсээр дамжуулан хүлээн авдаг билээ.

Надад хамаатай илчлэлтийг хэн хүлээн авдаг вэ?

Хувийн илчлэлт танд Сүнсээр дамжин ирж болно. Энэ нь бас гишүүдийг дуудлагуудад адисалдаг бөгөөд тэдний төлөө санаа тавих болон удирдамж хүлээн авахад нь тэдэнд туслах үүрэг хүлээсэн санваартны удирдагчдаар дамжин ирж болно.

Бошиглогч Сүмд бүхэлд нь зориулсан илчлэлт хүлээн авдаг. Харин Бүсийн Ерөнхийлөгчийн Зөвлөл өөрийн бүсэд зориулсан илчлэлтийг, харин гадасны ерөнхийлөгч гадсандаа зориулсан, бишоп тойрогтоо зориулсан илчлэлтийг хүлээн авдаг.

Удирдагчдаа дэмжих гэдэг нь юу гэсэн үг вэ?

Бид хүмүүсийг дэмжихийн тулд баруун гараа өргөдөг нь тэднийг дуудлагаа эрхэмлэн биелүүлэхэд нь дэмжлэг үзүүлж, тэдэнд хүндэтгэлтэй хандах болно гэсэн амлаал өгч байгаа хэрэг юм. Удирдагчдынхаа зөвлөгөөг дагах нь бид тэднийг


дэмжиж байгаа нэг хэлбэр мөн. Удирдагчид мэргэн ухаантай, холын бодлоготой байдаг бөгөөд тэдний заавар сайн мэдээгээр амьдрахад бидэнд туслах зорилготой юм.

Санваартны удирдагчдынхаа зөвлөгөөг дагаж болох таван арга замыг дор дурдав:

1. *Ерөнхий чуулган, гадасны болон тойргийн чуулгануудад оролцож байх.* Чуулганууд дээр хэлсэн үгсийг тэмдэглэх цаас, үзэгтэй ирж байх хэрэгтэй. Санваартны удирдагчдын үгийг сонсох үед өөртөө төрсөн онцгой сэтгэгдэл, хийх ёстой зүйлс, амьдралдаа гаргах ёстой өөрчлөлтийг тэмдэглэж бай. Сүмийн бусад цуглаанууд дээр хэлсэн үгс болон ярилцлагын үеэр өөрт чинь өгсөн зөвлөгөөг тэмдэглэж авч байхад анхаар.
2. *Удирдагчдын өгсөн зөвлөгөөний талаар гэрчлэлтэй болохын төлөө залбир.* Танд өгсөн зөвлөгөө бол Тэнгэрлэг Эцэгийн хүсэл юм шүү гэдгийг Ариун Сүнс Өөрт тань гэрчлэх болно.
3. *Удирдагчдын өгсөн зөвлөгөөг амьдралдаа хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргаж ажилла.* Жишээ нь, бошиглогчид Сүмийн гишүүдэд боловсролтой болох зөвлөгөө өгдөг. Танд



ЯРИЛЦЛАГАД ОРОЛЦ



Та нар зургадугаар сарын турш Залуу Эмэгтэйчүүдийн болон Няам гарагийн ангиуд, санваартны чуулгуудад санваарын тухай судлах болно. Санваарын тухай болон санваар амьдралд тань хэрхэн нөлөөлсөн болон санваартны удирдагчдаа хэрхэн дэмжвэл зохих тухай ямар асуултууд өөрт тань байна вэ гэдгийг бод. Асуултуудаа эцэг эх буюу өсвөр үеийнхний удирдагчидтай хуваалц. Тэгвэл энэ сарын хичээлүүдээрээ санваарын тухай сургаалуудыг сайн ойлгоход тань тэд туслах болно. Та нар бас санваар амьдралыг тань хэрхэн адисалсан талаарх туршлагынхаа тухай бодож болно. Бодол санаагаа тэмдэглэж, гэртээ, сүм дээр болон мэдээллийн хэрэгслээр дамжуулан бусадтай хуваалцахыг бод.

энэ талаар төлөвлөгөө байна уу? Коллеж эсвэл мэргэжлийн сургуульд орох уу? Тэр сургуульд юу судлах вэ? Хэзээ сургуульд орох вэ? Суралцахыг хүсдэг ажил мэргэжилдээ бэлтгэхийн тулд одоо юу хийж байна вэ?

4. *Байнга мэдээлэлтэй бай.* Сүмийн гарын авлага, бусад материалуудыг уншиж, Сүмийн удирдагчдаас тухайн үед өгсөн зөвлөгөөний талаар мэдлэгтэй бай. *Залуучуудын бат бөх байдлын төлөө* товхимол бол маш чухал эх сурвалж. *Лианхона* сэтгүүлд бошиглогчид,

төлөөлөгчдийн үгс нийтлэгддэг. Танай тойрог буюу салбар мэдээллийн хуудас гаргадаг бол тэндээс орон нутгийнхаа санваартны удирдагчдын захиасыг уншиж бай. Хамгийн чухал нь сүүлчийн ерөнхий чуулганууд дээр удирдагчдын хэлсэн үгсийг нэгтгэн дүгнэж бай.

5. *Тэр даруй эхэл.* Бид заримдаа удирдагчдынхаа зөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг хойш тавьж, уруу татагддаг. Зөвлөгөө, захиасыг хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргасан тэр даруйдаа идэвхтэй үйл ажиллагааг эхэл. ■



БИ БИШОПЫН ЗӨВЛӨЛӨӨС ДААЛГАВАР АВЛАА

Долдугаар анги төгсөх ойртож байх үед надад ямар нэг юм дутагдаад байх шиг санагдах болов. Би орой болгон залбирдаг, сүмд явдаг байсан ч энэ нь хангалтгүй юм шиг санагдах болов. Мормоны Номыг уншиж, Сүм үнэхээр үнэн үү гэдгийг мэдэхсэн гэж бодовч нэгэн хэвийн байдлаа эвдэж, үнэнийг мэдэхээс айж байлаа.

Манай бишопын зөвлөл өсвөр үеийнхэнд судруудыг бие даан тогтмол уншиж байх даалгавар өглөө. Судруудыг тийнхүү тогтмол унших цаг зав надад байхгүй юм шиг санагдав.

Тэгтэл би Мормоны Номыг уншиж, энэ ном үнэн үү гэдгийг мэдэх хэрэгтэй гэсэн хүчтэй сэтгэгдэл надад төрлөө.

Би Мормоны Номыг уншиж эхлээд дөнгөж нэгдүгээр бүлгийн дунд орох үед өмнө нь хэзээ ч мэдэрч байгаагүйгээр Сүнсийг тийм хүчтэй мэдэрлээ. Үүрд ийм л байгаасай гэж бодмоор маш сайхан амар амгаланг тэгэхэд би мэдэрч билээ.

Манай удирдагчид Мормоны Номыг унших сүнсээр нөлөөлөгдсөн даалгаврыг бидэнд өгсөнд би талархалтай байдаг. Тэд надад сүнслэг байдлын аливаа асуудлаа шийдэхэд туслахад үргэлж бэлэн байдаг.

Камрин Ж., Юта, АНУ



Залуу Эрэгтэйчүүдийн ерөнхий ерөнхийлөгч Дэвид Л.Бек

ТАЛАРХАЛ

Хэрэв биг талархлаар гүүрэн байвал бүгдээрээ аз жаргалтай байх болно.

2011 оны зун АНУ-ын Нью-Мексикийн Филмонт Скаут Ранчид Жош Ларсонтой танилцах аз завшаан надад тохиосон юм. Түүнээс хойш ганц хоёрхон сарын дараа Жош агуулахыг цэвэрлэхэд аавдаа тусалж байх үед нь 670 кг жинтэй дамжуулах шугамын дамнуурга гэнэт хугарч, дамнуурга Жош дээр унаж, толгойноос нь хөлийг нь хүртэл дарсан аж. Жошийн аав хүүгийнх нь дээрээс дарсан дамнуурган дороос амьсгал нь тасалдсан хүүгээ гайхамшигтайгаар гарган авч, түргэн тусламжийнхан иртэл анхны тусламж үзүүлсэн ажээ.

Жошийн амь нас хэд хоногийн турш хутганы ирэн дээр байлаа. Эмч нар түүний бяцарсан гавлын ясыг

эвлүүлж, тасарсан шөрмөсүүдийг нь залган, бусад ноцтой бэртлүүдийг эдгээхийн тулд шаргуу ажиллажээ. Олон мэс засал хийсний дараа Жош хэвийн болж эхэлсэн ч эдгэрэлт туйлын удаан үргэлжилсэн ажээ.

Өнөөдөр Жош ослын олон үр дагаврыг биеэрээ амсан туулж байна. Нэг нүд нь гэмтэж, өрөөсөн чих нь сонсголгүй болж, толгойд нь төмрийн өөдөс зоогдсон ажээ. Гэвч тэр энэхүү гай зовлонг адислал хэмээн үздэг гэнэ. Тэр амь насаараа болон ослын олон үр дагавраас эдгэрснээ Тэнгэрлэг Эцэгтэй болон эргэн тойрныхоо хүмүүсийн дэмжлэгтэй холбож үздэг ажээ. Талархал түүний зүрх сэтгэлд бялхаж байна.

Бэрхшээл тулгарсан үед талархалтай бай

Жош өсвөр үеийхний саяхны чуулган дээр гэр бүл, найз нөхөд, тойргийн болон гадасны удирдагчдын хийсэн залбирлууд болон мацаг барилтын тухай ингэж ярьжээ: “Би адислалуудаа тоолж байна. Миний олон залбирал хариулагдсан. Өөртөө тохиолдсон зүйлийг би гай зовлон гэхээсээ илүү адислал гэж үздэг. Би та нартаа бүгдэд нь хайртай шүү.”

Жош бол *Залуучуудын бат бөх байдлын төлөө* товхимол дахь “Талархлын сүнсээр амьдрагтун. Тэгвэл та нар агуу аз жаргал, сэтгэл ханамжийг олох болно. . . . Хамгийн хүнд бэрх цагт ч та нар талархаж болох маш олон зүйлийг олж чадна” гэсэн



Жошийн эдгэрэлт удаан байлаа. Ослын олон үр дагаврыг тэр биеэрээ амссан ч үүнийг гай зовлон гэхээс илүүгээр адислал хэмээн үздэг ажээ.





ТАЛАРХЛЫН ТУХАЙ ҮНДСЭН САНААНУУД

“Их Эзэн та нарыг хийж, хэлж байгаа бүх зүйлдээ талархлын сүнс-тэй байхыг хүсдэг. . . .

Залбирахдаа Тэнгэр дэх Эцэгтээ зүрх сэтгэлээ нээж, хүлээн авсан адислалуудынхаа төлөө талархлаа илэрхийл. . . .

Амьдралыг тань олон арга замаар адисалдгийнх нь төлөө бусдад талархлаа илэрхийл.”

Залуучуудын бат бөх байдлын төлөө (товхимол, 2011), 18.

сургаалын үлгэр жишээ мөн.¹

Талархал нь хүнд сорилт бэрхшээлийг, бүр Жошт тохиолдсон шиг ноцтой гай зовлонг ч адислал болгон хувиргаж болно. Талархалтай байж, амьдралд өөдрөг үзлээр хандах нь хүч чармайлт шаарддаг. Их Эзэн үнэхээр биднийг адисалдаг учраас Түүний нигүүлсэл, нинжин сэтгэл ажиглагдахгүй өнгөрөх буюу талархал илэрхийлэхгүй байх аргагүй юм. Мормоны Номын бошиглогч Моронай талархлын ач холбогдлыг бидэнд сануулж, “Адам бүтээгдсэнээс бүр та нар эдгээр зүйлсийг хүлээн авах цагийг хүртэл Их Эзэн хүмүүний үрсэд хэчнээн нигүүлсэнгүй байсаар буйг санагтун” (Моронай 10:3) хэмээн бидэнд урам хайрласан билээ.

Ариун Сүнсний тусламж

Бид завгүй амьдралдаа түүртээд өдөр тутмын ажил үйлсдээ Тэнгэрлэг Эцэгийн удирдамжийг хайхрахгүй өнгөрүүлэх буюу амархан мартаж болно. Бид юм бүхэнд талархалтай байх ёстойг санахад Ариун Сүнс бидэнд туслах болно. Тэргүүн Зөвлөлийн Нэгдүгээр зөвлөх Ерөнхийлөгч Хенри Б.Айринг:

“Бурхан бидний төлөө юу хийснийг мэдэхэд Ариун Сүнс бидэнд тусалдаг гэж заажээ.” “Бурханы энэрэнгүй нинжин сэтгэлийг таньж, санах арга замуудыг олохыг” тэр бидэнд хичээнгүйлэн захьсан билээ.²

Талархлын мэдрэмж нь Их Эзэнийг дагах болон үйлчлэлийн амьдралаар амьдрахад бидэнд сүнс-лэгээр нөлөөлөх болно

Бурханы нинжин сэтгэл хийгээд биднийг хайрладаг Түүний хайрыг сануулж байх боломжийг Ариун Сүнсэнд олговол бид талархлын мэдрэмжээр үргэлж дүүрэн байх болно. Ийм мэдрэмж Тэнгэр дэх Эцэгтээ талархалтай байхад бидэнд нөлөөлөх болно. *Итгэлдээ үнэнч байх нь* товхимолд ийн заасан байдаг: “Та нарт нинжин сэтгэлээр ханддагийнх нь төлөө Тэнгэрлэг Эцэгтээ талархал илэрхийлж бай. Та нар бүх зүйлд Түүний мутрыг хүлээн зөвшөөрснөөр, та нарт Түүний өгсөн бүх зүйлд талархсанаар, Түүний зарлигуудыг сахьсанаар

мөн бусдад үйлчилснээр Бурханд баяр талархлаа илэрхийлж болно. . . . Талархалтайгаар ажлаа хий. Ингэвэл гайхамшигтай үр дүнд хүрэх болно.”³

Адислалуудаа мэддэг болсон үед бидний гэрчлэл өсөн нэмэгдэх болно. Бидний амьдралд Их Эзэний гар ямар үүрэг гүйцэтгэдгийг бид хэдий чинээ сайн харж чадвал Түүнд төдий чинээ ойртож чадна. Бид Тэнгэр дэх Эцэгтээ талархлаа илэрхийлэх хамгийн сайн арга замуудын нэг бол бидний амьдралд нөлөөлснийх нь төлөө Түүнд болон бусад хүмүүст талархал илэрхийлж байх явдал мөн.⁴

Талархлын мэдрэмж нь Их Эзэнийг дагаж, эргэн тойрныхоо хүмүүст сүнс-лэг нөлөө үзүүлж, сайн өөрчлөлтийг хөхүүлэн дэмжсэн амьдралаар амьдрахад бидэнд сүнс-лэг нөлөө үзүүлэх болно. ■

ЭШЛЭЛ

1. *Залуучуудын бат бөх байдлын төлөө* (товхимол, 2011), 18.
2. Хенри Б.Айринг, “Ай санагтун, санагтун, та нар” *Лиакхона*, 2007 оны 11-р сар, 67–68.
3. *Итгэлдээ үнэнч байх нь: Сайн мэдээний эшлэлүүд* (2004), 79.
4. *Залуучуудын бат бөх байдлын төлөө* товхимол, х.18-ыг үзнэ үү.



ЭМЭЭДЭЭ ӨГСӨН БЭЛЭГ

Кимберли Сабин Плам

Баярласнаа илэрхийлж, энгийн захидал бичихэд эмээ минь их баяртай байдаг.

Намайг бага байхад эмээ минь миний үеэл ах, эгч дүү нарыг надтай хамт олон удаа хардаг байж билээ. Бид бүгдээрээ нийлээд 14 хүүхэд байсан бөгөөд эмээ минь биднийг оройн хоолонд, унтахад, үдэш тоглоход болон баяр тэмдэглэхэд урихад бид үргэлж баярладаг байлаа. Эмээгийнхэнд байхад мөн ч сайхан шүү.

Эмээгийн гэрт болдог үйл ажиллагаа бүр хөгжилтэй байсан. Гэвч үйл ажиллагаа бүрд ямар цаг хугацаа, хүч чармайлт шаардагддаг байсныг би мэдэхгүй. Харин би эмээ нар юу хийдгийг болон тэдний хийдэг зүйлд дуртай байсан.

Эмээгийн гэрт үеэлүүдтэйгээ өнгөрүүлдэг хөгжилтэй жилүүд өнгөрч, манайх тэндээс нүүсэн юм. Хожим нь эмээ манай шинэ гэрт бидэн дээр зочлон очдог байсан. Манайхан эмээдээ хэрхэн хамгийн сайхан бэлэг өгөх билээ гэж удтал толгойгоо гашилдаг байж билээ. Эмээ минь миний мэдэх хэнээс ч илүү их юмтай байсан. Юм бүхэн байдаг эмээдээ бид ямар бэлэг өгч болох вэ?

Энэ талаар санаагаа хэлээч гэж би ааваасаа гуйхад тэр жил бүр нэг л зүйлийг: “Чи эмээдээ маш сайхан захидал бичиж болно шүү дээ” гэдэг байв. Миний толгойд олигтой санаа орж ирсэнгүй, тэгээд маргааш өглөө нь хэн ч сэрээгүй байхад би босч гал тогооны өрөөний хүйтэн хавтан шалан дээр хөлөө даруулан байж, эмээдээ онцгой сайхан захидал бичихээр суулаа.

“Эмээ минь та гайхалтай сайхан хүн. Надад зориулдаг юм бүхний тань төлөө тандаа их баярладаг шүү” гэж бичээд цааш нь юу гэж бичихээ мэдсэнгүй. Тэгээд би гал тогооны өрөөний цонхоор гадагшаа дал моддыг болон цэнхэр тэнгэрийг ширтэн хараад эмээ минь өдий олон жилийн турш бидний төлөө мөн ч олон зүйлийг хийж дээ гэж бодлоо.

Би захидалдаа эмээдээ хайртай гэдгээ бас онцгой дурсамж үлдээсэн олон сайхан үйл явдлын төлөө эмээдээ баярлан талархаж явдаг гэдгээ бичлээ. Бүр олон жилийн дараа одоо ч гэсэн эмээ минь наддаа туйлын чухал хүн хэвээр байгааг хэлээд захидалдаа дугтуйд хийж, улаан туузаар ороогоод, хивс дэвссэн дулаан өрөөндөө эргэж ирлээ.

Эмээдээ бэлгийг нь өгөх цаг болоход би захидалаа гаргаж ирлээ. Эмээ бэлгийнхээ талаар ямар

сэтгэгдэлтэй байхыг нь би үнэхээр мэдэхгүй байлаа.

Эмээ намайг дугтуй өгөхөд гайхан харлаа. Тэр дугтуйг булангаас нь болгоомжтой задлаад нарийхан ягаан цаасан дээр бичсэн захидлыг гаргаж ирлээ. Эмээ захидлыг уншаад инээмсэглэж, нүд нь нулимсаар дүүрч эхэллээ. Би урьд нь эмээгээ уйлж байхыг огт хараагүй юм. Эмээ захидлаас толгойгоо өндийлгөн, над руу дөлгөөхөн дулаан харцаар ширтэн харснаа “Баярлалаа, миний хүү. Намайг ингэж дурсдаг хүн байдаг гэж би боддоггүй байлаа” гэж шивнэв.

Гэр бүлийнхээ бат бөх харилцааг бий болгохын төлөө өдий ихийг хийсэн эмээ минь намайг түүнийг болон түүнтэй хамт өнгөрүүлсэн олон сайхан өдөр саруудыг дурсан санаж, талархал илэрхийлэх юм гэж санаагүй ажээ. Эмээ нулимсаа арчаад “Кимберли, хүү минь чамд их баярлалаа. Энэ бол надад өгч чадах хамгийн сайхан бэлэг” хэмээн хэлж билээ.

Эмээгээ чанга тэврэхэд тэр зөөлөн бүлээхэн хацраа миний хацарт нааж “эмээгийн” үнэр, булбарайхан хүүхдийн содон үнэртэй холидон үнэртэв. Эмээдээ захидал бич гэсэн аавын санаад би хэчнээн их баярласан гээч. Эмээд минь хайр, талархлын үгс, мөнгөөр худалдаж авч болох гэрийн аар саархан чамин зүйлс, үнэртэй ус, жимстэй бялуунаас хавьгүй илүү үнэ цэнэтэй болохыг би мэддэггүй байж дээ. ■

Энэ өгүүллийг бичигч АНУ-ын Калифорнид амьдардаг.



ХАЙРАА ҮГЭЭР БОЛОН ҮЙЛСЭЭР ИЛЭРХИЙЛ

“Бид зүрх сэтгэлийн талархлаа-

раа хамгийн чухал үйлсийг бүтээж, амьдарч байгаа цаг үеэ сайхан болгоцгооё. Хүмүүст хайраа үг хэлээр болон үйлсээрээ илэрхийлж, тэднийг баярлуулцгаая.”

Ерөнхийлөгч Томас С.Монсон, “Аялалдаа баяр баясгаланг олохуй,” *Лиакхона*, 2008 оны 11-р сар, 87.

Муу КИНО

Эвелин киноны нэрийг
хараад дотор нь
палхийгээд явчихав.



Жюли Вудбери

Сүмийн сэтгүүлчүүд

Бодит түүхээс сэдэвлэв

“Би зөвхөн Тэнгэрлэг Эцэгийн таалалд нийцэх зүйлсийг уншиж, үзэж байх болно” (Миний сайн мэдээний жишгүүд).

Ангийнхаан, та нарт дуулгах онцгой сонин мэдээ байна” гэж хатагтай Тейлор ангийн өмнө гарч ирэн хэлэв.

Эвелин шалгалтын тестээсээ толгойгоо өндийлгөн дээш хараад яралзтал инээмсэглэв. Тестийн дээд буланд том “А+” гэсэн дүн байлаа.

“Та нар тестээ бүгдээрээ сайн хийсэн болохоор шагналд нь маргааш нэг кино үзэх болно” гэж хатагтай Тейлор хэлээд самбар дээр гурван киноны нэр бичив. “Эндээс бид саналаараа сонголт хийнэ” гэж хэлэхэд бүгд баярлан шуугилдав.

Эвелин ямар кинонуудын нэр байгааг харахын тулд суудал

дээрээсээ өндийн харлаа. Эхний хоёр кино нь ямар нэг хэмжээгээр түүний дуртай кино байлаа. Тэр найз Кати руугаа харж, “Чи ямар кино үзэхээр санал гаргах гэж байна?” гэж асуув.

“Мэдээж хэрэг, гурав дахь нь” гэж Кати хэллээ. “Аав ээж хоёр энэ киног гэртээ үзэхийг бидэнд зөвшөөрдөггүй юм. Тэгэхлээр би хэзээ ч үүнийг үзэж чадахгүй ш дээ.”

Эвелин самбар руу дахин харж, гурав дахь киноны нэрийг харлаа. Зүрх нь түргэн түргэн цохилж эхэллээ. Эвелин энэ киноны тухай сонссон бөгөөд үүнийг үзэх нь зөв зүйл биш гэдгийг мэдэж байлаа. Хэрэв ангийнхан нь энэ киног үзнэ гээд санал гаргачихвал яах вэ?

“Нэг дэх киног үзэх саналтай хүн байна уу? гэж хатагтай Тейлор асуув.

Эвелин гараа өндөрт өргөж, эргэн тойрноо харлаа. Тэр сэтгэл түгшин уруулаа хазав. Өөр хоёрхон хүүхэд нэг дэх киног үзэх саналтай байлаа.

Хатагтай Тейлор нэг дэх киног үзэх саналтай сурагчдын тоог самбар дээр бичлээ. “Хоёр дахь киног үзэх саналтай сурагчид гараа өргөнө үү?”

Эвелингийн дотор палхийгээд явчихав. Гуравхан хүн гараа өргөлөө.

“За гурав дахь киног?”

Арвантаван хүн гар өргөлөө. Эвелиний дотор эвгүй болж,



“Бид бусад туслахын тулд хаана ч байлаа гэсэн нүгэл хилэнцийг эсэргүүцэх сүнний болоод ёс суртахууны зоригтой байх хэрэгтэй.”

Томас С.Монсон, “Өөрийгөө удирдах гурван зорилго,” *Лиэхона*, 2007 оны 11-р сар, 119.

Эвелин маргааш нь ангидаа орж ирлээ. Хэрэв тэр киног үзвэл Эвелинд хэрхэн муу болох тухай ээжийнх нь бичсэн зурвасыг нэг гартаа, үзэж болох дуртай гурван киноныхоо нэрийг нөгөө гартаа барьсан байлаа. Эвелин зурвасыг хатагтай Тейлорт өгөөд тэр зурвасыг хэрхэн уншихыг харж байлаа.

“Өөрийнхөө бодлыг хэлсэнд баярлалаа” гэж хатагтай Тейлор хэлжээ.

“Кино гарах үеэр өөр ангитай хамт хичээллэх хэрэгтэй” гэж ээж надад хэлсэн. Гэвч бусад хүүхдүүдэд бүгдэд нь таалагдвал би бас үзэж болох хэдэн шинэ киноны нэр авчирсан” гэж Эвелин хэлжээ.

Хатагтай Тейлор инээмсэглээд кинонуудын нэр бичсэн цаасыг авав. “Хэрэв кино хүн бүрт таалагдахгүй бол шагнал болж чадахгүй шүү дээ” гэв.

Хатагтай Тейлор шинэ киноны нэрсийг самбар дээр бичлээ. “Ангийнхаан, өнөөдөр би та нараас үзэх киноны талаар та нарын саналыг дахин авах гэсэн юм. Би шинэ кинонуудыг санал болгож байна.”

Эвелин ширээндээ очиж суулаа. Тэр ангийнхаа шагналаас хоцроогүйдээ баяртай байлаа. Гэвч хамгийн үнэтэй шагнал нь Тэнгэрлэг Эцэг айдсыг нь зайлуулж, зөвийг хийх зоригийг түүнд өгсөн явдал байлаа. ■

суудалдаа улам шигдэв. Хэрэв бусад бүх сурагчид энэ киног үзье гэвэл би үүнээс яаж зайлсхийх вэ?

Эвелин гэртээ ирээд шууд өрөөндөө орж, цүнхээ шалан дээр хаячихаад суув. Өвчин туссан юм шиг өдөржингөө уруу царайлж явлаа. “Үнэхээр маргааш өвдчихөөсэй тэгвэл сургуульд явахгүй амар байхгүй юу” гэж тэр бодлоо.

Эвелин тестээ цүнхнээсээ гаргаж, гартаа бариад ширтэн харлаа. “Тэр кино шагнал биш шийтгэл болох нь ээ!” гэж бодоод тестээ ууртайгаар базаж, орон доогуураа далд хийв. Нүдэнд нь нулимс цийлэгнэн, уйлмаар санагдав. Тэр орныхоо дэргэд өвдөг сөгдөөд

уйлж гарснаа залбирлаа. Хоолой нь зангиран хэдэн өгүүлбэр хэлээд асуудлыг нь байхгүй болгож өгнө үү гэж Тэнгэрлэг Эцэгээс гүйснаа хэсэг хугацааны дараа залбирлаа өөрчлөв. Энэ удаа тэр “Энэ асуудлыг илүү сайнаар шийдэхэд надад туслаач. Эвгүй сэтгэгдэл төрүүлэх киног би үзэхийг хүсэхгүй байна. Найз нар болон багш маань ойлгоно гэдэгт би найдаж байна” гэж залбирчээ.


Эвелин залбирлаа дуусгалаа. Санааг нь зовоосон, эвгүй бодол нь алга болов. Айдас нь ч алга болов.

Эвелин орноосоо үсрэн босч, ээжтэйгээ уулзахаар өрөө рүү нь очлоо. Түүнд ямар нэгэн санаа төржээ.



Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын
Ахлагч Квинтин Л.Кук

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүд
бол Есүс Христийн онцгой гэрчүүд юм.



Тэнгэрлэг
Эцэг Сүмийн
гишүүдийг бусад
хүмүүсээс илүү
хайрладаг
уу?

Бурхан Өөрийн
бүх хүүхдүүдэд
хайртай.

Тэрбээр тэднийг
бүгдийг нь
Өөртөө эргэж
ирэхийг хүсдэг.

Бид бас бүх
хүмүүсийг
хайрлаж,
хүндлэх ёстой.

Бурхан
өөрсдийг нь
хайрладгийг
мэддэггүй
хүмүүст бид
тусалж чадна.

Тэгвэл тэд их
баяртай байх
болно!



Далын
Ахлагч Хосе Л.Алонсо

Шаргуу залбирал

Би Мексикт ээж, эмээ, дүү нартайгаа өссөн. Би өдөр бүр гэрийн даалгавраа бас гэрийн ажлаа хийсний дараа хөл бөмбөг тоглодог байлаа. Хөл бөмбөгт ёстой л хорхойтой байлаа! Баруун хөл минь нэг баг, зүүн хөл минь нэг баг гэж боддог байж билээ.

Нэг өдөр хөл бөмбөг тоглож байтал гэнэт амьсгал бөглөрч дотор эвгүй болох нь тэр. Хэдэн минут амарсан ч, амьсгалахад хүнд хэвээр байв. Тэгээд эмчид үзүүлж эмнэлэгт хэвтэв.

Миний хэвтсэн эмнэлгийн өрөөнд өөр олон хүүхэд байсан ч би гэрээ санаж, маш их ганцаардаг байлаа. Тэгэхэд би Сүмийн гишүүн болоогүй байсан ч Бурханд итгэдэг байсан. Би түргэн эдгэрэхийн төлөө өдөр бүр залбирдаг байсан ч бие улам бүр дордсоор байлаа. Эмч нар намайг эдгэрэхгүй гэж бодсон гэдэг.

Эцэстээ эмч нар намайг эмнэлгээс гаргаж, би гэртээ ирсэн ч хойтон жил нь бүр хэвтэрт орсон байлаа. Би олон эм ууж, өдөрт хоёр удаа тариа хийлгэдэг байв. Үүний хажуугаар би зүрх сэтгэл, оюун ухаандаа залбирсаар байсан. Хэрэв би эрүүл болдог л юм бол амьдралынхаа үлдсэн хугацааг Тэнгэрлэг Эцэгтээ үйлчлэхэд зориулна гэж Түүнд хэлдэг байлаа.

Нэг өдөр би орон дотроо ном уншиж байгаад номоо санаандгүй шалан дээр унагачихав. Номоо авах гэж доошоо бөхийтөл миний амьсгал хэвийн болсон байлаа.



Номоо дахин доош нь унагаад тонгойж автал зүгээр амьсгалж байлаа!

Тэгээд би орноосоо босов. Удаан хугацаанд өөрөө явж чадахгүй байсан болохоор эхний удаад толгой эргэлээ. Толинд өөрийнхөө инээмсэглэсэн дүрсийг хараад Тэнгэрлэг Эцэгээс залбирлынхаа хариут авснаа ойлгов.

Би тэр үеэс хойш өдөр бүр Тэнгэрлэг Эцэгт талархлаа илэрхийлэхийн тулд ямар нэгэн зүйл

хийхийг хичээдэг болсон. Би насанд хүрсэн үедээ бусад хүүхдүүдийн залбиралд хариулахад туслахын тулд эмч болсон юм. Одоо би Сүм дэх дуудлагаараа Тэнгэрлэг Эцэгтээ үйлчлэхийг хичээж байна.

Залбирлын хариу үргэлж амархан бас тэр дороо ирдэггүй ч Тэнгэрлэг Эцэг бидний залбиралд хариудгийг би мэднэ. Тэр бидний хэрэгцээг мэддэг бас бидэнд юу хамгийн сайн болохыг мэддэг. ■

Би баптисм хүртэж, гишүүнээр батлуулснаар Тэнгэрлэг Эцэгийн ТӨЛӨВЛӨГӨӨГ дагана

Хүүхдийн Хэсгийн энэ сарын сэдвийн тухай илүү ихийг мэдэхийн тулд та нар энэ хичээл болон үйл ажиллагааг ашиглаж болно.

Мормон гэдэг ойд цугласан бүлэг хүмүүсийн тухай Мормоны Ном өгүүлдэг. Тэд Есүс Христийн сайн мэдээний тухай Алмагийн заахыг сонсохыг хүссэн ажээ. Алма тэдэнд олон өдөр заасны дараа тэднээс Бурханд үйлчлэх болон Түүний зарлигуудыг сахих гэрээ байгуулахыг хүсч байна уу гэж асуусан гэнэ. Хэрэв тэд баптисм хүртвэл тэдэнд Ариун Сүнс ирэх болно гэдгийг тэр хэлжээ (Мозая 18:7–10-ыг үзнэ үү).

Хүмүүс үүнийг сонсоод “баярласандаа алгаа ташин” (Мозая 18:11) ихэд баяртай байсан аж. Алма Мормоны усанд 200 орчим хүнд баптисм хүртээжээ. Тэдгээр хүмүүс Мормоны ойг сайхан газар хэмээн боддог болсон гэнэ. Учир нь тэд тэнд Аврагчийн тухай мэдэж, баптисм хүртсэн юм (Мозая 18:30-ийг үзнэ үү).

Бид Алмагийн хүмүүстэй адил баптисм хүртэхээр хүлээж байхдаа эсвэл баптисм хийлгэснээ эргэн санасан үедээ баяртай байдаг. Бид Алмагийн хүмүүстэй адил баптисм хүртэхдээ Бурхантай гэрээ хийдэг. Бид Түүний

зарлигуудыг сахиж, Түүнд үйлчлэх амлалт өгдөг. Бид Есүс Христийн нэрийг өөр дээрээ авч, Сүмийн гишүүд болдог. Бид гишүүнээр батлагдах үедээ хэрэв бид Бурханы

зарлигуудыг сахвал Ариун Сүнс бидэнтэй үргэлж хамт байх болно гэсэн Алмагийн хүмүүсийн хүлээн авсан гайхамшигтай амлалтыг хүлээн авдаг билээ. ■



НАМУУХАН, ЗӨӨЛӨН ДУУ ХООЛОЙГ СОНС

Энэ хуудсан дээрх зургуудыг хайчилж, уутанд хийхэд туслахыг аав, ээж хоёрынхоо нэгээс эсвэл насанд хүрсэн өөр хэн нэгнээс хүс. Зургуудыг ээлжээр уутнаас гаргаж ир. Зураг бүрт тохирох өгүүлбэр болон судрыг олж, чанга унш.



Ариун Сүнс бидэнд Тэнгэрлэг Эцэгийн хайрыг болон баяр баясгалан, амар тайван байдлын сүнсийг мэдрэхэд тусалдаг (Галат 5:22–23-ыг үзнэ үү).

ЯРИЛЦАЦГААЯ

Баптисм хүртэж, гишүүнээр батлагдсан нэг хүнээс тэрхүү онцгой өдөр түүнд ямар сэтгэгдэл төрснийг асуу. Хэрэв та баптисм хүртсэн бол баптисм хүртэж, гишүүнээр батлагдах үед төрсөн сэтгэгдлээ өөр хэн нэгэнтэй хуваалц.


Ариун Сүнс биднийг аюулаас сэргэмжлүүлж, хэдийд сонор сэрэмжтэй байх хэрэгтэйг мэдэхэд тусалдаг (С ба Г 9:9-ийг үзнэ үү).



Ариун Сүнс бол багш мөн. Тэр бидэнд Есүс Христийн тухай зааж, эцэг эхчүүд, багш нар болон судруудаас сурч мэдсэн зүйлээ санахад тусалдаг (Иохан 14:26-г үзнэ үү).



Ариун Сүнс биднийг удирдаж, биднийг Тэнгэрлэг Эцэгт буцааж аваачих зөв шийдвэрүүдийг тод томруунаар харахад тусалдаг (2 Нифай 32:5-ыг үзнэ үү).



Ариун Сүнсийг заримдаа Тайтгаруулагч гэдэг. Ариун Сүнс бидэнд зөөлхөн хөнжил шиг сайхан, ая тухтай амар амгаланг мэдрэхэд тусалдаг (Иохан 14:16, 27-г үз).



СУДАР БА ДУУ

- Мозая 18:8–11
- “Намайг баптисм хүртэхэд” (*Children’s Songbook*, 103)



Балтисм бол адислал



Тревор усан дотор орохоос үргэлж айдаг байлаа. Тэр балтисм хүртэж чадах болов уу даа?

Кейси Айре

Тревор буйдан дээр эрүүтээ гараараа тулан сууж байлаа. Эрэгтэй дүү нар нь эмээтэйгээ тоглоно. Тэр бас хөгжилтэй байхыг хүссэн ч балтисмынхаа талаар санаа нь зовохгүй байж чадсангүй.

Ээж нь түүний хажууд суугаад үсийг нь илснээ “Юу болоов? Яагаад тоглохгүй байгаа юм бэ” гэж асуулаа.

Тревор хөмсгөө зангидан толгой сэгсрэв.

Ээж нь хүүгээ хоромхон зуур харснаа түүнийг тэврээд, “Усан дотор орохоос айсан хэвээрээ л байна уу?” гэж асуухад,

Тревор толгой дохив.

Усан дотор орно гэдэг бодол Треворыг үргэлж айлгадаг гэнэ. Учир нь тэр гурван настай байхдаа нэг удаа цөөрмийн усанд унасан ажээ. Тэр ус руу улам бүр

гүнзгий живж эхлэхэд маш их айснаа огт мартдаггүй гэнэ. Тэгтэл нэг хүн түүнийг уснаас татаж авчээ. Түүнээс хойш тэр ус харахаараа айдаг болсон ажээ.

“Уснаас айхгүй болоход яагаад юу ч тус болдоггүй юм бол оо? Бид залбирсан, бүр баптисмын санг очиж үзсэн. Гэтэл юу ч болохгүй юм!” гэж Тревор бодсоноо буйдангаас үсрэн босч, өрөө рүүгээ гүйв.

Тревор унтлагын өрөөний хаалгыг савж хаагаад орондоо орж хэвтлээ. Удалгүй хаалга аяархан тогших нь сонсогдов.

Тревор аав нь түүний хажууд сууж байхыг харав. “Чамайг баптисмынхаа талаар санаа зовоод байгаа гэж ээж чинь ярилаа” гэж аав нь хэллээ.

Тревор толгой дохив. “Би залбирсан л даа. Гэсэн ч айгаад байх юм.”

Аав нь түр зуур бодолхийлэв. “Зарим үед бид ямар нэг зүйлийн төлөө залбирахад хариу нь тэр дороо ирдэггүй. Чи өнөөдөр айж байлаа ч маргааш гэхэд тайван болж болно.”

Тревор толгой сэгсэрсэн ч өнгөрсөн жил сургуульд орохдоо мөн л айж байснаа саналаа. Тэгэхэд аав нь түүнд адислал өгсөн ажээ. Тэгэхээр одоо баптисм хийлгэхэд нь туслахын тулд түүнд адислал өгч болох юм биш үү. Тэр аав руугаа харав. “Өвөө та хоёр надад адислал өгч болох уу?”



Аав нь толгой дохив. “Энэ чинь тун аятайхан санаа байна.”

Тревор дараахан нь том өрөөндөө сандал дээр сууж байлаа. Аав, өвөө хоёр нь түүний толгой дээр гараа тавин, аав нь түүнийг адисалж, тайван байхад нь Тэнгэрлэг Эцэг түүнд тусална гэдэгт итгэлтэй байгаагаа хэлжээ.

Тревор маргааш нь баптисм хүртэхээр цагаан хувцастай сууж байхдаа мөн л сэтгэл түгшүүртэй байлаа. Тэр адислал авсандаа баяртай байсан ч айсан хэвээр байвал яах бол оо? Баптисм хүртэж чадах болов уу даа?

Баптисмын тухай хэн нэгэн нь үг хэлсний дараа аав нь түүн рүү хараад “Баптисмын сан руу очих цаг боллоо” гэв. Тревор толгой дохиод аавынхаа араас дагалаа. Аав нь эхлээд ус руу орлоо.

Треворын ээлж боллоо. Тэр эргэлзсэн ч өмнө нь хэрхэн залбирснаа санаад “Тэнгэрлэг Эцэг минь, итгэлтэй байхад надад туслаач” гэж гуйн дотроо чимээгүй залбирлаа.

Тревор нэг хөлөө алгуурхан усанд дүрлээ. Ус сайхан бүлээхэн байлаа. Тэр усан дотор дахиад нэг алхлаа.

Тэр усан дотор алхах бүрдээ айдас, түгшүүр нь алга болж байгааг мэдрэв. Аав нь түүнийг хөтлөн инээмсэглэж явлаа. “Бэлэн үү?”

Тревор амар амгаланг мэдрлээ. Энэ бол Тэнгэрлэг Эцэгийн түүнд өгнө гэж амласан мэдрэмж байлаа. Тэр “Бэлэн!” хэмээн толгой дохив.

Аав нь түүний баруун гарыг өргөж, баптисмын залбирлыг хэлэв. Аав нь Треворыг усан дотор доош нь оруулахад тэр айсангүй. Түүнд амар амгалангийн мэдрэмж улам хүчтэй мэдрэгдэж байлаа.

Тревор уснаас инээмсэглэн гарч ирэв. Итгэл нь түүний айдсыг ялсан учраас тэр баптисм хүртэж чадсанаа мэдэж байлаа. Зөвийг сонгохыг хичээсэн үед нь Тэнгэрлэг Эцэг үргэлж түүнд тусална гэдгийг тэр мэдэж байв. ■

Энэ өгүүллийг бичигч АНУ-ын Невадад амьдардаг.



Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Квинтин Л.Кук, “Айдсаар биш, итгэлээр амьдар,” *Лиакхона*, 2007 оны 11-р сар, 73.

“Бид айснаасаа болж өөр замыг сонгох биш харин итгэлээрээ Христийг дагахаар сонговол адислагдах болно.

**Сайн
байна уу!
Би Монголын
А.ЭНХЖИН
байна**



Надад гэрийн ямар ч амьтан байхгүй, гэхдээ нэг гөлөгтэй болохсон гэж үнэхээр их хүсдэг. Бид заримдаа хөдөө явах үеэрээ үхэр, хонь, адуу, тэмээ, ямаа хардаг. Өвөл би цасан хүн хийж тоглох дуртай. Одоо Тэрэлж амралтын газрын ойролцоох Мэлхий хадны дэргэд байна.


Чи гэрийнхэнтэйгээ Чюу хийх дуртай вэ? Монголын 8 настай Энхжин, гэрийнхэнтэйгээ хамт хөдөө явж, зэрлэг жимсгэнэ, гүзээлзгэнэ түүх дуртай ажээ.

Манайхан гэр бүлээрээ хамт цагийг өнгөрүүлдэг нь сайхан санагддаг. Бид гэр бүлийн үдэш хийж долоо хоног бүр сүмд явахдаа баяртай байдаг. Бид бас Мормоны Номыг уншиж, өдөр бүр хамт залбирдаг. Эдгээр зүйлүүд манай гэр бүлийг бэхжүүлэхэд тусалдаг.





Би аав, ээж, хоёр эрэгтэй дүүгийнхээ хамт Монголын нийслэл Улаанбаатар хотод амьдардаг. Манай хотод нэг сая хүн амьдардаг гээд бод доо! Бид 15 давхар орон сууцны 12 дугаар давхарт амьдардаг.



Энэ зурган дээр би дүүдээ түүх уншиж өгч байна. Би ном унших их дуртай. Би гуравдугаар ангид сурдаг. Математик, зургийн хичээлд дуртай. Би ангийнхаа Сүмийн гишүүн биш нэг хүүхдэд Мэргэн Ухааны Үгийг зааж, цай, кофены оронд сүү ууж бай гэж хэлсэн. Би түүнд бас Тэнгэрлэг Эцэгт хандан хэрхэн залбирахыг заасан. Учир нь тэр үүнийг мэдэхгүй шүү дээ. Би түүнийг бас гэр бүлийнхээ үдэшт урьсан.

ЭНХЖИНГИЙН ДУРТАЙ ЗҮЙЛС:

Хоол—пицца, төмсний нухаш

Судар—1 Нифай 3:7

Дуунууд—“Тэжээлийн тэвшинд”,
“Мормоны Номын түүхүүд”



Хоньчин ба алга болсон хонь

Марго Мае, Юта, АНУ



Есүс түүхүүдийг ярьж, хүмүүст заадаг байв. Нэг өдөр Тэр 100 хоньтой хоньчны тухай түүх ярьжээ. Хоньчин нь маш эелдэг сайхан зантай хүн байв. Тэр хонин сүргээ хээрийн зэрлэг амьтдаас хамгаалдаг, шөнө нь манаж хонодог байлаа.

Нэг өдөр нэг хонь алга болчихож.
Хоньчин 99 хонио аюулгүй газарт
орхиод, алга болсон нэг хонио
хайхаар явж гэнэ.



Хоньчин хонио олоод их баярлав.
Тэр хонио мөрөн дээрээ үүрч,
гэртээ авчирчээ.



Хоньчин найзуудаа дуудаад хонио хэрхэн олсон тухайгаа хэлжээ. Тэд хамтдаа баяраа тэмдэглэжээ.



Есүс Христ энэ түүхэн дэх хоньчинтой, харин бид хонин сүрэгтэй нь адилхан юм. Есүс биднийг харж хандаж, аюулаас хамгаалдаг. Тэр биднийг алдаа гаргахад хаядаггүй. Харин биднийг наманчилж, Түүний сайн мэдээнд эргэж ирэхэд баярладаг. Тиймээс судруудад Түүнийг Сайн Хоньчин гэж нэрлэдэг. ■

Матай 18:12-14, Лук 15:3-7-гоос.



ЕСҮС АЛГА БОЛСОН ХОНИНЫ ТУХАЙ СУРГААЛТ ЗҮЙРЛЭЛ ЗААСАН НЬ
“Хэрэв та нарын дундаас хэн чинь зуун хоньтой байтал, нэг нь алдагдахад ерэн есөн хонио бэлчээрт орхин, алдагдсан хонины араас явж, түүнийг олтлоо хайдаггүй вэ?”
(Лук 15:4).

СҮМИЙН МЭДЭЭ

Сүмийн мэдээ болон үйл ажиллагаануудын тухай news.lds.org-аас үзнэ үү.

Ерөнхийлөгч Монсоны үйлчлэлийн үед Сүмд түүхэн өөрчлөлтүүд гарчээ

Ерөнхийлөгч Томас С.Монсоны Сүүлийн таван жил Сүмийг удирдах хугацаанд Сүмийн дэлхий даяарх гишүүдэд нөлөөлсөн түүхэн өөрчлөлтүүд гарчээ. Сүмийн 16 дахь ерөнхийлөгчийн гүн гүнзгий нөлөөг бид номлолын ажил, санваарын удирдлагын сургалтаас эхлэн олон ариун сүмийн барилга зэргийг хамарсан чухал зарлал мэдэгдлүүд болон сүм дэх шинэ бодлого хэрэгжүүлж байгаагаас харж болно.

Ерөнхийлөгч Монсоны үед илчлэгдсэн олон бодлого журам, мэдэгдлүүд нь дэлхий даяар нөлөөгөө үзүүлж байна. Үнэн хэрэгтээ эдгээр бодлого журам, мэдэгдлүүдийн олонх нь хувь хүмүүст үйлчилж, тэдгээрийг халамжлахад зориулагдсан юм. Хувь хүнд хандаж амьдралынхаа турш тавьсан түүний анхаарал халамжийг бид түүний үйлчлэлийн түүхэн цаг үе болгоноос харж болно.

Томас С.Монсонг ерөнхийлөгчөөр үйлчилсэн таван жилийн хугацаанд болсон гол чухал үйл явдлуудын тойм:

- 2012 оны 10-р сарын 6-нд Ерөнхийлөгч Томас С.Монсон Сүмийн залуу гишүүдийн бүрэн цагийн номлолд үйлчлэх боломжийг өргөжүүлэх зорилгоор эрэгтэйчүүд 18, эмэгтэйчүүд 19 насандаа үйлчлэлээ эхэлж болно гэдгийг мэдэгдсэн билээ. Тэрээр уг мэдэгдлийг Сүмийн хагас жил тутмын 182

дахь Ерөнхий чуулганы нээлтийн хуралдааны үеэр хийсэн бөгөөд энэ нь номлолын ажилд эрс урам зориг нэмсэн юм. Уг мэдэгдлээс хойш Сүмийн Номлолын алба үйлчлэх хүсэлтэй залуу эрэгтэй болон эмэгтэйчүүдээс түүхэнд байгаагүй олон тооны номлолын өргөдлийг хүлээн авсан билээ.

- Ерөнхийлөгч Монсон Тэргүүн Зөвлөл дэх өөрийн хоёр зөвлөх Ерөнхийлөгч Хенри Б.Айринг болон Ерөнхийлөгч Диетер Ф. Угдорфын зөвшөөрөлтэй захидалдаа 2013 оны өсвөр үеийнхэнд зориулсан шинэ сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх болсноо зарласан юм. Уг хөтөлбөр нь Сүмийн залуучуудын “итгэл, хөрвөлт, гэрчлэлийг бий болгож, хүчирхэгжүүлэх” зорилготой билээ. Уг шинэ хөтөлбөр нь Аврагчийн дэлхий дээрх тохиууладдаа хэрхэн зааж байснаас үлгэрлэн Аароны санваар, Залуу эмэгтэйчүүд болон Өсвөр үеийнхэнд зориулсан ням гаргийн ангиудад илүү олон давуу талтай хичээлүүдийг заах боломж олгож байна. Долоо хоног бүрийн уг ангиуд нь Сүмийн онлайн эх сурвалжуудыг ашиглаж байгаа ба өсвөр үеийнхэнд урьд өмнөхөөс илүү хичээлдээ хамрагдаж, идэвхтэй оролцсоноор баяр баясгаланг олох боломж олгож байна.

- Ерөнхийлөгч Монсон болон Тэргүүн Зөвлөлийн удирдлаган дор гишүүдэд үйлчилж, гүн гүнзгий хөрвөлтийг бий болгох хичээл зүтгэлд нь орон нутгийн санваарын, туслах бүлгийн удирдагчид болон гэр бүлүүдэд туслахын тулд Сүм дэлхий даяарх удирдагчдын сургалтыг үргэлжлүүлэн явуулж байна. Уг сургалт нь орон нутгийн удирдагчид болон гишүүдэд Тэргүүн Зөвлөл, Арванхоёр Төлөөлөгчийн Чуулга болон бусад Ерөнхий эрх мэдэлтнүүд, туслах бүлгийн ерөнхий удирдагчдаас удирдамж хүлээн авах боломж олгож байгаа билээ. Дэлхий даяарх сургалт нь (2010 онд танилцуулсан) шинэ удирдлагын гарын авлагуудыг ашиглах заавар, тойргийн зөвлөлүүдийг үр дүнтэйгээр хөтлөн явуулах, санваараар дамжуулан гэр бүл болон Сүмийг хүчирхэгжүүлэх талаарх сургалтуудыг багтаасан байгаа.
- 2010 онд Тэргүүн Зөвлөл Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүдэд олон улсын хэмжээний хоёр шинэ төрлийн хурлыг хөтлөн явуулахыг даалгасан юм. Уг хуралд санваарын удирдлагын чуулганууд болон бүсийн хэлэлцүүлэг ордог. Санваарын удирдлагын чуулган бүрийн үеэр Сүмийн томилогдсон аливаа бүсийн гадасны ерөнхийлөгчийн



2008 оны 2-р сарын 4-ны даваа гарагт Ерөнхийлөгч Томас С.Монсон Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн шинэ Тэргүүн Зөвлөлийг зарлан хэвлэл мэдээллийнхэнд хандаж үг хэлжээ.

зөвлөл, бишоп, салбарын ерөнхийлөгчид сургалтанд ирдэг. Бүсийн хэлэлцүүлэг бүрт удирдагчид Сүмийн томилогдсон тухайн бүсэд юу болж байгааг нарийвчлан авч үзэж, хүмүүнлэгийн үйлчлэл, халамжийн хэрэгцээ, номлолын ажил, гэр бүлийн түүх, ариун сүмийн ажил зэрэг зүйлсийн талаар хэлэлцдэг.

- Ерөнхийлөгч Монсоны үйлчлэлийн үеэр дэлхий даяар 31 шинэ ариун сүм барихаар зарлагдсан байна. 16 ариун сүмийг онцгойлон адисалж, өөр бусад таван ариун сүмийг засварлан шинэчилсний дараа дахин онцгойлон адисалсан. Ерөнхийлөгч Монсон Канадын Алберта мужийн Калгари хот; Филиппиний Себу хот; Бразилийн Куритиба хот; Украйны Киев хот; Панамагийн Панама хот; Канадын Бритиш Коламбиа мужийн Ванкувер хот; Ютагийн Драпер; Миссуригийн Канзас хот; Айдахогийн Рексбург; Ютагийн

Саут Жордан; Аризонагийн Гила Валлей; АНУ Айдахогийн Твин Фоллсын ариун сүмүүдийн онцгойлон адислалтыг өөрийн биеэр тэргүүлж, Мексикийн Мексик хот; Жоржиагийн Атланта; Айдахогийн Бойсе; АНУ Хавайн Лайен ариун сүмүүдийн дахин онцгойлон адислалтын ажиллагааг мөн тэргүүлсэн юм.

- Ерөнхийлөгч Монсон бошиглогчдын үгс болон Сүмийн хөтөлбөрүүдийг дэлхий даяарх 14 сая гишүүдэд интернетээр хүргэх боломжтой болсон энэ үед Сүмийг удирдаж байгаа билээ. Онлайн эх сурвалжууд нь Сүмээс гаргасан видео бичлэгүүд болон Шинэ Гэрээний чухал үйл явдлуудыг харуулсан кинонуудыг багтааж байна.
- Тэргүүн Зөвлөлийн удирдлаган дор Сүм *Daughters in My Kingdom: The History and Work of Relief Society* хэмээх шинэ номыг хэвлэж гаргасан билээ. Энэ ном

нь эмэгтэйчүүдийг тэдний үүрэг хариуцлагад нь хүчирхэгжүүлэх хувийн болон гэр бүлийн эх сурвалж болох зорилготой.

- Ерөнхийлөгч Монсоны удирдлаган дор Сүм дэлхий дээр тохиолдож буй гай гамшигт анхаарал хандуулж, тусламж хэрэгтэй хүмүүст хүрч тусалж байна. Өнгөрсөн таван жилийн зарим чухал хүмүүнлэгийн ажлуудаас харахад Сүм Хайти дахь газар хөдлөлт, Япон дахь газар хөдлөлт болон цунами, Тайланд дахь үер зэрэг гамшгуудад нэрвэгдэгсдэд тусламж үзүүлсэн байна. Сүм мөн зүүн Африкийн хоол хүнсний дутагдалд тусламж үзүүлэн, олон оронд хүүхдүүдийг вакцинжуулахад тусалж, алслагдсан олон тосгодоод цэвэр усны хангамж бий олгосон юм. Нэмж хэлэхэд Сүм АНУ-ын Юта мужийн Солт Лейк хот дахь 53,000 метр квадрат шинэ халамжийн байрыг онцгойлон адисалсан билээ. ■

Сүмийн удирдагчид “Ажлыг яаравчлуулах” талаар ярилцаж байна

Сара Жейн Вийвер

Сүмийн мэдээ

Хожмын үеийн гэгээнтэн өсвөр үеийнхнийг номлолын бэлтгэл, гэр бүлийн түүх, ариун сүмийн ажил болон Ням гарагийн заавруудад илүү үүрэг хариуцлагатай хандахыг шаардаж буй өөрчлөлтүүдийн зэрэгцээ Сүмийн өсвөр үеийнхнээс “үйлдэхэд дуудан”, “босч мөн урагш гэрэлтүүлэхийг” (С ба Г 115:5) хүсч байна гэж удирдагчид хэлжээ.

Уг өөрчлөлтүүд нэг зүйлийг хэлээд байна: “Их Эзэнд Түүний хийхийг хүссэн ямар нэгэн зүйл байна” гэж Далын Ахлагч Паул Б.Пийпер хэлжээ.

Санваарын албаны гүйцэтгэх захирал Ахлагч Пийпер өсвөр үеийнхэнд олон замаар нөлөөлөх өөрчлөлтүүдийн талаар хэлэлцэж буй *Сүмийн мэдээ* дугуй ширээний ярилцлагад саяхан оролцжээ. Уг ярилцлагад мөн Далын Ахлагч ба Гэр бүлийн түүхийн төвийн гүйцэтгэх захирал Аллан Ф.Пакер, Далын Ахлагч ба Ариун сүмийн албаны гүйцэтгэх захирал Виллиам Р.Вокер, Далын Ахлагч ба Номлолын албаны туслах захирал В. Грейг Звик, Далын Ахлагч ба Сүмийн боловсролын хорооны төлөөлөгч Паул В.Жонсон, Бүсийн Далын Ахлагч ба Гэр бүлийн түүхийн төвийн зохицуулагч захирал Деннис С.Вримхола мөн Нийгмийн халамжийн бүлгийн ерөнхий ерөнхийлөгч Линда К.Бөртөн нар оролцжээ.

Залуу эрэгтэй болон эмэгтэйчүүдийн номлолын үйчлэл хийж эхлэх насыг багасгасан талаар мөн шинэ өсвөр үеийнхэнд зориулсан сургалтын хөтөлбөр, өсвөр үеийнхнийг гэр бүлийн түүхийн хайлганд оролцуулж, ариун сүм рүү гэр бүлүүдийн нэрсийг авч явахыг хүссэн Тэргүүн Зөвлөлийн захидлын талаар Ахлагч Пийпер “ут гурван өөрчлөлтийг хамтдаа ирнэ” гэдгийг чуулганаас өмнө анзаараагүй гэдгээ хэлжээ. “Би чуулган руу ирэх замдаа өөрөөсөө ‘эдгээр гурван өөрчлөлт хэрхэн өөр хоорондоо холбогдож байна вэ?’ хэмээн асуусан юм. Энэ бол Их Эзэний ажил, Тэрээр үүнийг хүссэн гэдэг нь тодорхой байсан юм.”

Ахлагч Звик “Бибээр өөрийн ажлыг зохих цагт нь яаравчлуулах болно” (С ба Г 88:73) хэмээх Их Эзэний үг тодорхой хэмээн хэлжээ. Тэрээр мөн “Их Эзэн Өөрийн биеэр биднийг удирдаж байна” хэмээн нэмж хэлэв. “Өнөөдрийнх [өсвөр үеийнхэн] шиг ийм сургалтын хөтөлбөрт бэлтгэгдсэн өсвөр үеийнхэн урьд хожид байгаагүй гэж би бодож байна. Мөн нас барагсдын төлөө ийм олон баптисм болон бусад ёслолуудыг хийлгэж, . . . [эсвэл] ариун сүмийн ажилд мөн түүний бүхий л талуудад ингэж их оролцож байсан өсвөр үеийнхэн байгаагүй билээ. Мэдээж хэрэг эдгээр бүх зүйл . . . тэднийг номлолын үйлчлэлд бэлтгэж, номлолынх нь дараах нэмэлт үүргүүдэд нь зориулж бат бөх суурийг барьж өгдөг юм.”

Энэ бол Бурхан Өөрийн өсвөр үеийнхэнд итгэж байгааг харуулсан үнэхээр хүчирхэг захиас хэмээн Ахлагч Бримболл хэлжээ.

“Их Эзэн ямарваа нэгэн зүйлийг хийх үед энэ нь зөв цагтаа зөв газарт болдог ба яг ийм зүйл одоо тохиолдож байна” хэмээн Ахлагч Жонсон хэлэхдээ мөн шинэ өсвөр үеийнхэнд зориулсан сургалтын хөтөлбөр дээр ажиллаж байсан хүмүүс номлогчдын үйлчлэлээ эхлэх насанд өөрчлөлт гарна гэдгийг мэдээгүй байсан гэдгийг мэдэгджээ.

Ахлагч Вокер өсвөр үеийнхнийг гэр бүлийн түүхийн ажлаа хийж, ариун сүм рүү тэдгээр нэрсийг авч явахыг урамшуулсан Тэргүүн Зөвлөлийн захидлын талаар ярьжээ. “Өсвөр үеийнхэн хязгаартай ашиглах ариун сүмийн эрхийн бичгийг ашиглах боломжтой болсон нь . . . үнэхээр гайхамшигтай зүйл юм” гэж тэр хэлэв. “Залуу хүмүүс ариун сүмийн ажилд санаа сэтгэлээ бүрэн зориулж [байна], сургаалыг ойлгож байна. . . . Энэ нь тэдэнд зориулж хадгалагдсан гайхамшигтай эдгээр бүхий л зүйлст сүнслэгээр бэлтгэхэд нь тэдэнд тусалж байна.”



Ахлагч Пакер гэр бүлийн түүхийн ажлын талаар гэрчлэлээ хуваалцсан нэгэн залуу эмэгтэйн талаар саяхан сонссон гэдгээ хэлжээ. Тэр эмэгтэй “энэ нь настай хүмүүсийн юу болох гэж буйг хэлснээс хамаагүй илүү хөгжилтэй ажил байсан” гэжээ.

Ахлагч Вокер “Энэ бол Елиагийн Сүнс. Энэ бол эцгүүдийн зүрхийг хүүхдүүд уруу нь, хүүхдүүдийн зүрхийг эцгүүд уруу нь эргүүлж байгаа хэрэг” гэж хэлэв.

Ахлагч Пакер гэр бүлийн түүхийн ажил нь өсвөр үеийнхний хэрхэн шийдвэр гаргаж,

Сүмийн удирдагчид Их Эзэн Өөрийн ажлыг яаравчлуулж байгаа бөгөөд Сүмийн өсвөр үеийнхнийг үйлдэхэд урьж байгаа гэдгийг хүлээн зөвшөөрч байна.

сорилтуудад хандаж байгаа хандлагыг өөрчлөх болно гэж нэмж хэлжээ. Тэр мөн тэд “хэрэв өвөө үүнийг хийсэн бол би ч бас хийж чадна” гэж бодох болно гэжээ.

Өсвөр үеийнхэн хэн нэгний өмнөөс төлөөлөн баптисм хүртэх үедээ уснаас инээмсэглэн гарч ирдэг харин “тэд өвөг дээдсийнхөө өмнөөс үүнийг хийхдээ нүдэндээ нулимстай гарч ирдэг. Тэд илүү гүн гүнзгий мэдрэмжийг мэдэрдэг; тэд ямар нэг илүү зүйлийг мэдэрдэг” гэж ариун сүмийн ерөнхийлөгч ярьсан хэмээн Ахлагч Пакер хэлсэн байна.

Өсвөр үеийнхэнд алсын хараатай байхад туслах нь уг өсвөр үеийнхэнд зориулсан шинэ сургалтын хөтөлбөрийн зорилго бөгөөд сургалтын материалууд нь хичээлийн гарын авлагуудыг орлох болно хэмээн Ахлагч Пийпер хэлэв. Уг хөтөлбөр нь багш нарт өсвөр үеийнхнийг ариун сүм болон гэр бүлийн түүхийн ажил, номлолын үйлчлэлд бэлтгэхийн тулд Ням гарагийн ангид юу заах ёстойгоо тодорхойлоход тусална.

“Шинэ НБТ болон Шинэ гэр бүлийн түүхийн төв нь гэр орон бөгөөд уг шинэ сургалтын хөтөлбөр нь өсвөр үеийнхэн болон эцэг эхчүүд хоёуланд тэрхүү үүрэг хариуцлагад нь туслах болно” хэмээн Ахлагч Пакер хэлж байна.

Эцэг эхчүүдэд хандан бичсэн захиас нь “Сүмийн удирдагчид, эцэг эхчүүд та бүхэнд итгэдэг бөгөөд танай гэр бүлд өссөн эдгээр залуу эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдэд мөн итгэдэг” явдал хэмээн Ахлагч Звик хэлжээ.

Сүмд гарч буй бүх өөрчлөлтүүд “Сүмийг байх ёстой мөн байх болно гэж бошиглогсон газар руу нь хүргэдэг. Их Эзэн ирээдүйд юу болохыг мэддэг бөгөөд . . . энэ бол хаант улсыг дэвшүүлж, урагш өнхрүүлэхийн тулд Түүний хийж буй зүйлсийн зөвхөн нэг хэсэг нь л юм” хэмээн Ахлагч Жонсон гэрчилсэн байна.

Ахлагч Пийпер өнгөрсөн 10-р сарын чуулганы үеэр болсон бүх зүйлийг тунгаан бодох үедээ “бошиглогчийг Сүмийн хөгжлийн хаалгыг санваарын түлхүүрээр нээж, биднийг оруулж буйг мэдэрсэн хэмээн хэлээд ийн үргэлжлүүлэв: Бид та нарыг ирж, уг ажилд оролцохыг урьж байна. Энэ бол Их Эзэний цаг. Бид бүгд үүнийг мэддэг. Бид бүгд үүнийг мэдэрсэн. Сүм ч бас үүнийг мэдэрч байгаа. Мэдээж хэрэг энэ нь биеллээ олох болно.” ■



Ахлагч Кристофферсон Төв Америк дахь гишүүдэд зөвлөгөө өгөв

Ахлагч Дон Л.Сийрл

Сүмийн мэдээ

2013 оны 1-р сарын 20-нд Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Д. Тодд Кристофферсон өнөөдрийн Сүмийн ажил нь Их Эзнийг ирэх үед Түүнийг хүлээн авч, үйлчлэхэд бэлэн байх хүмүүсийг бэлтгэх явдал юм хэмээн Аррайжан Панама гадасны гишүүдэд хэлжээ.

Энэ бол Ахлагч Кристофферсоны 1-р сарын 11-нээс 20-ны хооронд Төв Америкт байх хугацаандаа өсвөр үеийнхэн, ганц бие залуучууд, номлогчид, Сүмийн орон нутгийн

Ахлагч Д. Тодд Кристофферсон 1-р сард Панамад болсон цуглааны дараа нэгэн залуу эмэгтэйтэй мэндчилж байна.



удирдагчид болон гишүүдэд гадасны чуулганы үеэр хэд хэдэн удаа давтан хэлсэн сэдэв юм.

Ахлагч Кристофферсонтой хамт эхнэр Кейти Кристофферсон мөн Далын ерөнхийлөгчийн зөвлөлийн Ахлагч Ричард Ж.Майнес болон түүний эхнэр Нейнси Майнес нар явсан байна. Тэрээр Коста Рика, дараа нь Гватемала, хамгийн сүүлд Панама руу аялахдаа Бүсийн ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүд болох ерөнхийлөгч Ахлагч Жеймс Б.Мартино, нэгдүгээр зөвлөх Ахлагч Карлос Х. Амадо, хоёрдугаар зөвлөх Ахлагч Кевин Р.Дункан нартай хамт өөр газруудаар мөн зочилжээ.

Ахлагч Майнес мөн Хондурас, Белиз рүү удирдагчид болон гишүүдтэй уулзахаар явсан байна.

Ахлагч Кристофферсон Коста Рика болон Панама дахь Залуучуудын бат бөх байдал хэмээх чуулгануудад цугласан залуучуудад мөн Коста Рика Сан Жосе, Гватемала, Панама дахь номлогчид, гурван өөр улсын ганц бие залуучуудад мөн санваар болон туслах бүлгийн удирдагчдад хандан үг хэлжээ.

Тэрээр мөн Коста Рика болон Гватемалагийн ерөнхийлөгчидтэй засгийн газартай чухал харилцаа холбоо тогтоохыг дэмжих зорилгоор уулзсан байна.

Ахлагч Кристофферсон Коста Рикад байхдаа өсвөр үеийнхэн

болон залуучуудад зарлигуудыг дагаж, Тэнгэрлэг Эцэг тэдэнд хайртай бөгөөд Тэднийг мэддэг гэдгийг санаж, судруудыг өдөр бүр судалж, судруудыг судлах үедээ Сүнсний тэдэнд өгөх бүх зүйлийг хүлээн авахаар эрэлхийлэхийг зөвлөжээ.

Тэрээр Бошиглогч Иосеф Смит болон Есүс Христийн талаар хүчирхэг гэрчлэлийг хуваалцсан байна. Тэрээр “би та нарын дээр миний гэрчилж буй энэхүү гэрчлэлийг хүлээн авахаар адисалж байна. [Есүс Христ] бол бодит. Би өнөө орой та нарт Түүний адислалуудыг үлдээж байна” гэжээ.

Тэрээр Гватемалад байхдаа гэр бүлийн ач холбогдлын талаар онцолсон байна.

“Бид гэр бүл үүсгэснээр дэлхий дээрх хамгийн агуу зорилгоо биелүүлдэг” хэмээн тэрээр хэлжээ.

Тэрээр мөн Панама дахь өсвөр үеийнхэнд хандан үг хэлж, “энэ Сүмийн удирдагч бол бидний Их Эзэн Есүс Христ юм. Тэр үнэхээр төгс удирдагч бөгөөд Өөрийн Сүмийг идэвхтэйгээр удирддаг” хэмээн гэрчилжээ.

Санваарын удирдлагын чуулган үүрэг даалгавар болон завгүй байхад биш харин санваарын үйчлэлийн үр дүнд ялангуяа хувь хүмүүсийн хөрвөлтөнд анхаарлаа хандуулахыг онцолсон юм.

Ахлагч Майнес Белиз, Хондурас дахь залуучуудад болон номлогчдын цуглаануудыг оролцуулан маш олон хурал цуглааныг тэргүүлж, Төв Америкийн газар нутгийн хүмүүст сүнслэг удирдамж, зөвлөгөөг өгсөн билээ. ■

Жасон Свенсен уг мэдэгдэлд тусалсан байна.

Мексик дэх Сүмийн дунд сургууль шинэ НБТ болно

1-р сарын 29-нд Мексикийн Мексик хот дахь Venemérito de las Américas хэмээх Сүмийн дунд сургуулийг номлогчийг бэлтгэх төв болгох зарлалыг танилцуулсан байна.

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Расселл М.Нелсон болон Жеффри Р.Холланд нар 1-р сарын 29-нд шинэ НБТ-ийг зарласан Бенемерито сургууль дээрх цуглааныг тэргүүлж, үг хэлсэн байна. Сургуулийг НБТ болгож өөрчлөх ажлыг Бенемерито сургуулийн төгсөлтийн дараа буюу 2013 оны 6-р сард эхлүүлэхээр төлөвлөөд байна. Бараг 40 жилийн турш Venemérito de las Américas сургууль гэрээсээ хол байгаа сурагчид байрлах зориулалттай дотуур байртай үйл ажиллагаагаа явуулсан байдаг. Иймээс НБТ-д шаардлагатай дотуур байр болон тоног төхөөрөмжүүд аль хэдийн тэнд байгаа билээ.

Уг шинэ НБТ нь зөвхөн Мексикт төдийгүй Өмнөд, Хойд, Төв Америкт үйлчлэх ахлагчид, систерүүд болон ахмад номлогчдыг сургах болно. Бүр өөрсдийн эх орондоо испани хэлээр номлох шаардлагатай Америкаас ирсэн номлогчид Мексик хотод бэлтгэгдэж болно. Юта мужийн Прово дахь НБТ нь мөн олон номлогчдод испани хэлний сургалтыг үргэлжлүүлэн явуулах болно.

Табернеклын найрал дуучид дуу бичлэг болон интернетээр дамжуулан амжилтанд хүрч байна

Дуу бичлэгийн үйлдвэрлэлийн худалдааны хэвлэл болох *Billboard* сэтгүүлийн жилийн эцсийн дүгнэлтээр 2012 оны хамгийн ашиг орлоготой байсан дуучид, урлагийнхны жагсаалтыг гаргасан байна. Эдгээр жагсаалтын тоонд Мормон табернеклын найрал дуучид ариун сүмийн талбай дахь найрал хөгжмийн хамт Номер 1 Үндэсний Сонгодог Цомгийн Уран Бүтээлчдээр тодорчээ.



Мормон табернекл найрал дуучид болон ариун сүмийн талбай дахь найрал хөгжим нь Billboard сэтгүүлээс гаргасан жилийн эцсийн жагсаалтанд эхний байр эзэлснээс гадна тэднийг 2012 оны эцэс гэхэд YouTube хөгжмийн вэбсайт дээр хүмүүс гурван саяас илүү удаа үзсэн байна.

Найрал дуучид болон найрал хөгжим нь жилийн эцсийн жагсаалтын тавд нь, мөн цомгийн жагсаалтад хоёр удаа бичигдсэн байна. Энэ нь (*Glory! Үндэсний сонгодог цомгийн 3 болон 9-р байранд бичигдэж; Music of Rejoicing ба This Is the Christ* цомгуудаар) Traditional Classical Albums Imprint-ын 4-р байранд; Traditional Classical Albums Label-ын 5-р байранд бичигдсэн байна; (Дэвид Арчулетатай хамтран дуулсан *Glad Christmas Tidings* цомгоор) Олон төрөлт сонгодог хөгжмийн цомгийн 12-р байранд мөн оржээ.

Уг амжилтуудаас гадна табернекл найрал дуучдын тоглолтыг 2012 оны 10-р сарын 30-наас хойш бараг гурван сарын дараа 1-р сарын 17-н гэхэд YouTube хөгжмийн вэбсайт дээр нэг саяас илүү үзэгчид үзсэн байна. Уг сайтыг 2012 оны эцсээр гэхэд үзэгчид 3.23 сая минут үзэж, өмнөх амжилтыг давсан байна. Уг сайтад зочлохын тулд www.YouTube.com/user/MormonTabChoir хуудас руу очно уу.

Бурханы сайн үгээр тэжээгдэх нь

*Лиахона*г сонссоноор би үнэхээрийн сургамжтай сүнслэг туршлага хуримтлуулж байна. Би татаж авсан дуу бичлэгийн файлаа харааны бэрхшээлтэй нэгэн гишүүнтэй, жолоочийн мэргэжилтэй өөр нэг гишүүнтэй мөн бичиг үсгэндээ тааруу бусад найз нартайгаа хуваалцсан юм.

Би гэрээсээ 200 киломертийн зайд оршдог магистрын сургалтанд хамрагдаж байгаа бөгөөд Лиахона сэтгүүлийн татаж авсан файлаа сонсох нь автобусан дахь миний аяллыг арай хурдан, ая тухтай болгож өгдөг. Би ерөнхий чуулганы яриануудыг сонсохдоо Иаковын үед очиж, “Бурханы сайн үгээр бүхэл өдрийн турш арчлагдаж” (Иаков 6:7) байгаа мэт санагддаг.

Франциско Флавио Диас Карнейро, Бразил

Лиахона биднийг сүнслэгээр урамшуулж, өдөөж, хүчирхэгжүүлдэг

Би *Лиахона*д дуртай! Энэ нь надад зөв зам дээр үлдэхэд сүнслэгээр урамшуулж нөлөөлдөг. Мөн залуу эрэгтэйчүүдийн дуудлагаа хийхэд минь тусалдаг. Би бэрхшээл тохиолдож, сэтгэлээр унасан үедээ Мормоны Ном болон *Лиахона*г уншдаг. Эдгээр нь Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христ бидний нэг бүрийг хайрлаж, санаа тавьдаг хэмээх гэрчлэлийг минь хүчирхэгжүүлдэг юм.

Жеймс Аарон С.Перез, Себу, Филиппин

АРЛЫНХНЫ ИТГЭЛ

Жошуа Ж.Пёрки

Сүмийн сэтгүүлүүд

Би саяхан Нэгдсэн Улсаас Маршаллын Арлууд болон Тонгад очих үеэрээ уулзсан хүмүүсийнхээ бат бөх итгэлийг гайхан биширлээ. Ёс суртахуун ба үнэний тодорхойлолт Өрнөдийн нийгэмд байнга өөрчлөгдөж байдаг бол арлынхны итгэл маш тогтвортой байдаг юм шиг надад санагдсан. Тонгад номлолын ерөнхийлөгчөөр үйлчилсэн Далайн гишүүн асан Ахлагч Жон Х.Гробергийн (1976–2005) тодорхойлсноор тэдний итгэл онцгой бат бөх юм. Тэдний итгэл Цагаатгал болон авралын төлөвлөгөөн дээр үндэслэдэг. Ийм итгэл Сүнсээр сурч мэдсэн зүйлд эргэлздэггүй.

Номхон Далайн арлууд дээрх хүмүүсийн амьдрал зарим талаар миний бодсоноос илүү алгуурхан өөрчлөгдөж байгаа ажээ. Машин, телевизор, кино, интернет, спорт болон өөр олон үйл ажиллагаа Арлынхны өдөр тутмын амьдралд хэвийн зүйл болсон ч эдгээр юмс олон улс оронд, түүний дотор Нэгдсэн Улсад байдаг шиг тийм сүрхий амин чухал хэрэгцээ биш бололтой.

Мэдээж хэрэг арлынханд өөрсдийнх нь асуудал бий л дээ. Тэд надтай л адилхан өөрсдийгөө хоол хүнс, орон байраар хангах арга замыг сүвэгчилж, гэрчлэлээ хамгаалахад санаа тавих ёстой. Гэвч сорилт бэрхшээлийн дарамтнаас болж гуйвж дайвдаггүй итгэлтэй хүмүүс байнгын зав чөлөөгүй байдал болон анхаарал сарниулах бусад зүйлст барьц алдаж тэвддэггүйд би дахин дахин итгэсэн юм.

Би Өмнөд Номхон Далай дахь аяллаасаа гэртээ буцаж ирээд дараах асуултуудыг тунгаан бодлоо: Зарим хүмүүс бат бөх итгэлтэй



*Миний уулзаж
ярилцсан ар-
лынхан үнэн
гэдгийг нь
мэдсэн зүйлээ
аливаа эргэлзээ-
гүйгээр хүлээн
авдаг ажээ.*


байхад зарим нь яагаад эргэлзэж, бодол санаа нь тогтворгүй байдаг юм бол? Зарим хүмүүс яагаад гэрчлэлтэй болсон атлаа дараа нь гэрчлэлээ сулруулж, хэврэг болгодог юм бол?

Эдгээр асуултуудын хариулт нь тухайн хүний зүрх сэтгэл Их Эзэн дээр хэрхэн бат бөх суурилсан эсэхээс хамааралтай биз ээ. Миний уулзсан арлынхан шийдвэрийг нэгэнт гаргасан л бол түүнээсээ эргэж буцаад, дахин өөрчлөөд байдаггүй ажээ. Тэд итгэлээ бат бөх суурь болох Гэтэлгэгчийнхээ Хадан дээр суурилуулснаар эргэлзээгээ арилгаж, гэрчлэл нь гуйвж дайван сулрахаас сэргийлж чадсан ажээ. Тэд үнэн гэдгийг нь мэдсэн зүйлээ аливаа эргэлзээгүйгээр хүлээн авдаг.

Энэ бол миний улам төгөлдөржүүлэхийг хүсдэг зан чанар. Итгэлд минь сорилт тулгарсан үед би Их Эзэн Оливер Каудерид хандан “Чи зүрх сэтгэлдээ эдгээр зүйлүүдийн үнэний талаар мэдэхийн тулд надад хандан залбирсан тэр шөнийг оюундаа санагтун. Энэ асуудлын талаар чиний оюунд амар амгаланг би яриагүй бил үү? Бурханаас илүү агуу ямар гэрч чамд байж болох билээ?” (С ба Г 6:22–23) хэмээн хэлсэн үгийг хэрэгжүүлэх чадвартай байхыг хүсдэг билээ. Ийнхүү санах нь гуйвшгүй бат бөх итгэл өөд хөтөлдөг.

Итгэлийн энэхүү хэлбэр гуйвшгүй бат бөх, үнэнч шударга бөгөөд анхаарал сарниулах зүйлсээс ангид юм. Энэ нь “Би үүнийг мэднэ. Үүнд дахин эргэлзэх шаардлагагүй” хэмээн баталдаг.”

Тэнгэрлэг Эцэг болон Түүний төлөвлөгөөнд итгэх энэхүү итгэлээ ашиглах нь Түүний хүч нөлөө бидний амьдралд идэвхтэй үйлчлэх үүд хаалгыг нээж өгдөг. Энэ нь бидний итгэлийг ганхуулахад хүргэдэггүй бөгөөд үл мэдэгдэх зүйл рүү хөтөлдөггүй. Энэ нь “Тэр амьд!” гэж хэлэх боломжийг бидэнд олгодог. Чухам энэ нь л надад хангалттай юм. ■



ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ РОБЕРТ Т.БАРРЕТТ

ЛОРЕНЗО СНӨҮ

Лорензо Снөү сайн мэдээг түгээхийн тулд дэлхий дахинаар аялсан хүн. Түүнийг Хавай руу хөвж явах үед далайн **шуурга** хөлөг онгоцыг нь хөмөрч орхижээ. Лорензо Их Эзэнд итгэдэг байсан учраас далайд живж амиа алдахаас аврагджээ. Ерөнхийлөгч Лорензо Снөү 1899 онд **Сейнт Жоржийн Табернеклд** үг хэлэх үедээ аравны нэгээ бүрэн төлөхийн ач холбогдлын талаар заахаар сүнсээр өдөөгдсөнөө мэдэрсэн ажээ. Улам олон гишүүд **аравны нэгээ** төлж эхэлснээр Сүмийн санхүүгийн байдал тогтвортой өссөн байна. Гэгээнтнүүд мөнгөтэй үедээ аравны нэгийг мөнгөөр харин мөнгөгүй үедээ өндөг, сүү, үхэр малаар төлдөг байжээ.



Тэргүүн Зөвлөл ба Арванхоёр Төлөөлөгчийн Чуулга “Гэр бүл нь Түүний хүүхдүүдийн мөнхийн хувь заяаны төлөөх Бүтээгчийн төлөвлөгөөний төвд байдаг” хэмээн “Гэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг”-т бичсэн билээ. Уг тунхагт гэрлэлт ба гэр бүлийг бэхжүүлэх есөн зарчим: “итгэл, залбирал, наманчлал, уучлал, хүндэтгэл, хайр энэрэл, өрөвч сэтгэл, ажил хөдөлмөр ба идэвхтэй алралтын үйл ажиллагаануудыг” жагсаасан байдаг. Эдгээр есөн зарчмыг тус бүрийг нь дэлгэрүүлэн авч үзсэн өгүүллийг 26-р хуудаснаас үзнэ үү.

